



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ЗӨВЛӨЛ



The Asia Foundation

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ

Сургалтын гарын авлага

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2018 он

DDC

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хаяг: Тасганы овоо, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо,
 Улаанбаатар хот, Монгол Улс, Зип – 15170
 Утас: 70008045
 Факс: 70007021
 Веб сайт: www.judcouncil.mn
 И-мэйл: contact@judcouncil.mn

Төслийн хаяг:

.....

.....

.....

Утас:

Факс:

Шуудангийн хаяг:

.....


.....

.....

COPYRIGHT: Шүүхийн ерөнхий зөвлөл
 Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр
 “Азийн сан”-гаас хэрэгжүүлж буй “Ардчилсан
 оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил
 тод байдлыг бэхжүүлэх нь” төсөл



Энэхүү сургалтын гарын авлага нь Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр “Азийн сан”-гаас хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр хэвлэгдэн гарсан тул зөвшөөрөлгүйгээр хэвлэх, олшруулах, худалдан борлуулах болон бусад хэлбэрээр зохиогчийн эрхийг зөрчихийг хориглоно.



Анхны хэвлэл /...../ 2018 он

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:

Цаасны хэмжээ: 70x100 1/16

Хэвлэлийн хуудас: 10 х.х

.....хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN:.....

ГАРЫН АВЛАГЫГ БОЛОВСРУУЛСАН:

П.Баярцэцэг	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн Шүүхийн сургалт хариуцсан ахлах референт
Л.Галбаатар	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш
Д.Гансүх	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч асан
Д.Мөнхөө	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
Ц.Мөнхтулга	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч
О.Номуулин	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
Д.Нямбазар	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Б.Отгон	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн Шүүхийн судалгаа хариуцсан ахлах референт
А.Сарангэрэл	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Б.Сугар	Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Б.Энхтайван	Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч
Дэ.Энхцэцэг	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Б.Эрдэнэбат	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

Шүүхийн ёс зүйн хороо

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

ЭМХЭТГЭСЭН:

Л.Галбаатар	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш
-------------	---

ТЕХНИК РЕДАКТОР:

С.Алунгоо	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн Шүүхийн сургалт хариуцсан референт
-----------	---

... Шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байхад шүүгчийн ёс зүйн дүрмүүд нэн чухал ач холбогдолтой. Шүүгчид шударга байдлын бодит шалгуур үзүүлэлтийг хангахаас гадна, бодит байдалд тийнхүү шударга гэж харагдаж байх ёстой.

Шүүгч, хуульчдын хараат бус байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгчийн тайлангаас /2004 оны 4 дүгээр сар/

ӨМНӨХ ҮГ

Ардчилсан нийгэмд шүүгч нь аливаа этгээд хооронд гарсан маргааныг эцэслэн шийдвэрлэдэг, гэм бурууг тогтоож ял шийтгэлийг оногдуулдаг шударга ёсны манаач нь байдаг билээ. Английн нэрт сэтгэгч, эрх чөлөөний философийг үндэслэгч Ж.Локк хүний амь нас, өмч хөрөнгө, эрх чөлөө гурвыг хүний салшгүй эрх, юугаар ч орлуулшгүй үнэтэй ашиг сонирхол нь гэж нэгэнтээ хэлсэн. Тэгвэл шударга ёсны үйлчилгээг хүргэх замаар хүний энэ амин чухал ашиг сонирхлыг дэнслэх онцгой бүрэн эрх зөвхөн шүүгч хүнд бий. Энэ өндөр нэр хүнд, хариуцлагыг хүлээдэг болохын хувьд шүүгчид олон төрлийн хязгаарлалт, хуулийн болон ёс зүйн хэм хэмжээ үйлчилж байдаг.

Сүүлийн жилүүдэд иргэд олон нийтийн эрх зүйн мэдлэг дээшилж, эрхийн мэдрэмж өндөрссөнтэй холбоотойгоор шүүгчийн ёс зүйн талаарх гомдол санал гаргах явдал нэмэгдэж байна. Нөгөө талаас энэ байдал нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг судлах нөхцлийг бүрдүүлж өгч байгаа юм. Практикаас харахад хуулийн холбогдох заалтууд, Шүүгчийн ёс зүйн дүрэм, Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, баримт бичгийн зүйл, заалтыг үзэл баримтлалынх нь түвшинд нэг мөр ойлгох, ёс зүйн нэгдмэл стандартыг төлөвшүүлэх, улмаар шүүгчийн ёс зүйн онол номлолыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа нь ажиглагдаж байна. Энэ гарын авлагад шүүгчийн ёс зүйн талаарх олон улсын стандарт, түүний дэлгэрэнгүй тайлбарыг оруулж байгаа нь дээрх хэрэгцээ шаардлагыг хангахад чухал алхам болох бөгөөд шүүгч, хуульч, судлаачид шүүгчийн ёс зүйн дэлхийн стандарт, түүний үзэл санаатай онол номлолынх нь түвшинд танилцах, судлах өргөн боломжийг нээж байна.

Энэхүү сургалтын гарын авлагыг Монгол Улсын шүүхийн сургалтын онцгой хэсэг болсон шүүгчийн ёс зүйн сургалтад зориулан боловсруулсан бөгөөд шүүгчийн ёс зүй, хариуцлагатай байдлыг бэхжүүлж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна. Гарын авлага нь шүүхийн сургалтын дотоод хэрэгцээнд зориулагдсан тул зарим эх сурвалжийг дурдаагүй, зохих нууцлал хийгээгүй ашигласан аваас хүлцэл өчье.

Энэ чухал ажлыг хэрэгжүүлэх бидний санаачилгыг сайшаан хүлээн авч, эхлэлээс дуусах хүртэл тууштай дэмжлэг үзүүлсэн Азийн сангийн хамт олонд уншигчдын өмнөөс талархлаа илэрхийлье.

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ СТАНДАРТ ...	7
1.1. Шүүгчийн ёс зүйтэй байх шаардлагын талаарх олон улсын хэм хэмжээ.....	8
1.2. Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт ба Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн уялдаа	9
1.3. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний тайлбар.....	11
БҮЛЭГ 2. ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ	18
2.1. Хууль биелүүлэх, хууль хэрэглэх.....	19
2.2. Шүүгч хэрэг маргааныг заавал шийдвэрлэх	22
2.3. Шүүгч хэргийн нэг талтай харилцах.....	24
2.4. Шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг хадгалах	27
2.5. Мэргэжлийн шаардлага хангах, хичээл зүтгэл гаргах	28
2.6. Тэгш хандах.....	30
2.7. Шүүгчийн нэр хүндийг урвуулан ашиглахгүй байх, албан үүргээ чухалчлах.....	33
2.8. Шүүгчийн үйл ажиллагааг гаднын нөлөөнөөс хамгаалах.....	36
2.9. Нууцыг задруулахгүй байх	42
2.10. Хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргааны талаар мэдээлэх.....	44
БҮЛЭГ 3. ШҮҮГЧИЙН НИЙТИЙН АЛБАНД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ БА ШҮҮГЧИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ.....	49
3.1. Ашиг сонирхлын зөрчил	50
3.2. Хөрөнгө орлогын мэдүүлэг	53
3.3. Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан	55
3.4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үндэслэл, журам	57
3.5. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зам	61
3.6. Бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах	63
3.7. Шүүгчийн үнэмлэх, тэмдэг хэрэглэх	65
3.8. Бусдын зан байдлын талаар тодорхойлох.....	66
БҮЛЭГ 4. ШҮҮГЧИЙН АЛБАН ҮҮРГЭЭС БУСАД ХУВИЙН АМЬДРАЛД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ.....	765
4.1. Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаа	76
4.2. Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны хөлс.....	80

4.3. Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл хүлээн авах хязгаарлалт.....	82
4.4. Шүүгчийн улс төрийн үйл ажиллагааны хязгаарлалт.....	85
4.5. Итгэл үнэмшлээ илэрхийлэхэд баримтлах хязгаарлалт.....	88
4.6. Эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах хязгаарлалт.....	90

БҮЛЭГ 5. ШҮҮГЧИЙН НИЙГМИЙН ХАРИЛЦААНД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ 95

5.1. Ялгаварлах үзэл гаргахгүй байх.....	95
5.2. Байгаль орчны талаарх хандлага.....	98
5.3. Зохисгүй байдал гаргахгүй байх.....	100
5.4. Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглах....	103

БҮЛЭГ 6. ШҮҮГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, ОНОШЛОГООНЫ ТАЛААРХ СЭТГЭЛ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТОЙМ..... 108

6.1. Ёс суртахууны хөгжлийн талаарх сэтгэл судлалын үзэл.....	109
6.2. Шүүгчийн зан төлөв, оношлогоо.....	110
6.3. Шүүгчийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг сэтгэл зүйн хүчин зүйлс.....	114

ТЭМДЭГЛЭЛ	116
------------------------	------------

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ОЛОН УЛСЫН
НИЙТЛЭГ СТАНДАРТ**

*Л.Галбаатар, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын
хүрээлэнгийн судлаач-багш*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ 1. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ СТАНДАРТ

Зорилго: Энэхүү хэсэгт шүүгчийн ёс зүйтэй байх шаардлагын талаарх олон улсын хэм хэмжээ; шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт ба Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн уялдаа болон шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний тайлбарын талаарх цэгцтэй ойлголт өгч, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сонгох, хэрэглэх ур чадвар олгоно.

Нэр томьёо: Бангалорын зарчим, ёс зүйн дүрэм, тайлбар.

Дэд сэдэв:

- *Шүүгчийн ёс зүйтэй байх шаардлагын талаарх олон улсын хэм хэмжээ;*
- *Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт ба Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн уялдаа;*
- *Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний тайлбар.*

1.1. Шүүгчийн ёс зүйтэй байх шаардлагын талаарх олон улсын хэм хэмжээ

НҮБ-ын 1985 оны “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд”-ын 17-20 дахь хэсэгт “Шүүгчийн сахилга, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах”-тай холбоотой зарчмыг тусгажээ.¹ Ингэхдээ шүүгчийн ёс зүйтэй холбоотой нөхцөлийг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- 17.“Шүүгчийн шүүн таслах үйл ажиллагааны ур чадвар болон мэргэжлийн ур чадварын эсрэг гомдлыг зохих журмын дагуу шударга, шуурхай хянан шийдвэрлэнэ. Шүүгч нь түүний эсрэг гомдлыг шударга хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй. Шүүгч өөрөө хүссэнээс бусад тохиолдолд гомдлыг анхлан хянан шалгах үйл ажиллагаа нууц байна”,
- 18.“Шүүгчийг зөвхөн албан үүргээ гүйцэтгэх чадваргүй буюу зан байдлын хувьд тохиромжгүй гэх үндэслэлээр бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх буюу огцруулна”,
- 19.“Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулахтай холбоотой бүх хянан шийдвэрлэх ажиллагааг шүүгчийн ёс зүйг тогтоосон стандартын дагуу тодорхойлно”,
- 20.“Хөндлөнгийн бие даасан хяналтын дагуу шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах

¹ OHCHR | Basic Principles on the Independence Of the Judiciary

<http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/IndependenceJudiciary.aspx>

шийдвэрийг гаргана. Энэ зарчим нь дээд шүүхийн шийдвэр, хууль тогтоох байгууллагын импичмент буюу түүнтэй төстэй хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэхгүй байж болно”.

Энэ ёсоор, шүүгч ёс зүйтэй байх, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, тийнхүү мөрдөөгүй буюу ёс зүйгүй болох нь хөндлөнгийн хяналтаар тогтоогдсон нөхцөлд шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, огцруулах зарчмыг НҮБ-ын 1985 оны “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд”-ын холбогдох хэсэгт зохицуулжээ. Энэхүү зарчим нь НҮБ-ын бүх гишүүн орны хувьд баримтлах олон улсын заншлын хэм хэмжээ юм.

1.2. Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт ба Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн уялдаа

А. Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт

Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт бол “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд” юм.² Учир нь, тус зарчмыг 2000 оны 4 дүгээр сард Венад болсон НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 10 дугаар чуулган, Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх шүүхийн ажлын хэсгийн³ оролцоотойгоор бэлтгэж, энэ хүрээнд шүүгчийн ёс зүйн олон улсын болон үндэсний 32 хэм хэмжээг судалжээ.

Үүний дараа 2001 оны 2 дугаар сард Бангалорт болсон Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх шүүхийн ажлын хэсгийн 2 дахь хурлаар Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмын төслийг дахин хянаж, зөвшөөрчээ. Энэхүү ажлын хэсэгт НҮБ-ын тусгай илтгэгч, НҮБ-ын Хүний эрхийн хорооны тэргүүн, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын төлөөлөл оролцжээ.

Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмыг нийтлэг эрх зүйн болон иргэнлэг эрх зүйн тогтолцоотой орны шүүгчид аль аль нь өргөн хүрээнд хэлэлцсэн бөгөөд хэд хэдэн шүүх эрх мэдлийн олон улсын хурлуудад нэгэн адил хэлэлцсэн байна. Мөн 2002 оны 6 дугаар сард Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн ажлын хэсгээс тус зарчмыг хянажээ. Түүнчлэн, АНУ-ын Хуульчдын холбооны санаачилгаар Бангалорын зарчмыг Төв болон Зүүн Европын орнуудын хэлээр орчуулж, шүүгчид хянажээ.

² The Bangalore Principles of Judicial Conduct, 2002

http://www.unodc.org/pdf/crime/corruption/judicial_group/Bangalore_principles.pdf

³ Бангладеш, Энэтхэг, Непал, Нигер, ӨАБНУ, Танзани, Угандагийн шүүхийн ерөнхий шүүгчид, Олон улсын шүүхийн дэд ерөнхийлөгч, Австралийн дээд шүүхийн шүүгч, болон Шүүгч, хуульчийн хараат бус байдлын тухай НҮБ-ын тусгай илтгэгч нарын бүрэлдэхүүнтэй

Үүнээс хойш 2002 оны 11 дүгээр сард Гааг хотноо болсон иргэний эрх зүйн тогтолцоотой орны ерөнхий шүүгчид, тэдгээрийн төлөөллийн дугуй ширээний уулзалтаар Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмыг эцэслэн хянаж бэлтгэсэн байна.

Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын оршил хэсэгт дурдсанаар шүүхийн тогтолцоо болон шүүгчийн ёс зүй, үнэнч шударга байдалд итгэх олон нийтийн итгэл нь өнөөгийн ардчилсан нийгмийн амин сүнс болж байна.⁴


2004 оны 4 дүгээр сард Шүүгч, хуульчдын бие даасан байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч доктор Леандро Деспуй Хүний эрхийн комиссын 6 дахь чуулганы тайланд танилцуулсан тайландаа “... Зарим оронд олон нийтийн зүгээс шүүхийг авлигажсан байгууллага гэж үзэх хандлагатай буй нь шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг алдагдуулах ноцтой асуудал юм. Энэ асуудлын шийдэлд шүүгчийн ёс зүйн дүрмүүд нэн чухал ач холбогдолтой. Европын Хүний эрхийн шүүхийн онцолсноор, шүүгчид шударга байдлын бодит шалгуур үзүүлэлтийг хангахаас гадна бодит байдалд тийнхүү шударга гэж харагдаж байх ёстой. Тиймээс эрх зүйн хоёр гол уламжлал (заншлын эрх зүй болон иргэнлэг эрх зүй)-ын төлөөлөл өөрсдөө хамтран бэлтгэж, Хүний эрхийн комиссын 59 дүгээр чуулганаас сайшаасан Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудыг түгээж, түүнийг хэрэгжүүлэх яагаад чухал болохыг эндээс харж болно.” гэж тэмдэглэжээ.

Ийнхүү НҮБ-ын тусгай илтгэгчийн зүгээс, Бангалорын зарчмуудыг бүх хууль зүйн сургууль, шүүгч, хуульчдын мэргэжлийн холбоодод орчуулан хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлэхийг зөвлөжээ.

Б. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд ба Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн уялдаа

Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд нь оршил хэсгээс гадна дараах дэд хэсэгтэй. Үүнд:

- Үнэт зүйл 1. Бие даасан байдал;
- Үнэт зүйл 2. Хараат бус байдал;
- Үнэт зүйл 3. Шударга байдал;
- Үнэт зүйл 4. Зохистой байдал;
- Үнэт зүйл 5. Тэгш эрх;
- Үнэт зүйл 6. Ур чадвар ба хичээнгүй байдал.



⁴ The Bangalore Principles of Judicial Conduct, 2002

http://www.unodc.org/pdf/crime/corruption/judicial_group/Bangalore_principles.pdf

Дээрх зургаан үнэт зүйл тус бүр нэг зарчимтай бөгөөд тэрхүү зарчмыг хэрэглэх нөхцөл бүхий нийт 41 хэсэгтэй. Эдгээр 41 хэсэг нь дараах 6 зарчмыг хэрэгжүүлэхэд зориулагдсан тусгайлсан хэм хэмжээ юм.

- Зарчим 1. Шүүхийн бие даасан байдал нь эрх зүйт ёс болон шударга шүүхийн суурь баталгааны урьдчилсан, зайлшгүй нөхцөл юм. Тиймээс шүүгч нь шүүхийг хувь хүний болон байгууллагын төвшинд бие даасан байх нөхцөлийг хангах, үлгэр жишээ үзүүлэх ёстой.
- Зарчим 2. Хараат бус байдлыг хангах нь шүүхээс чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх үндсэн шинж мөн. Энэ нь дан ганц шүүхийн шийдвэрт бус мөн шүүхийн шийдвэрийг гаргах үйл явцад хамаарна.
- Зарчим 3. Шударга байдал нь шүүхээс чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх үндсэн шинж мөн.
- Зарчим 4. Зүй зохистой байдал, түүний илрэл нь шүүгчийн бүх үйл ажиллагааны хэрэгжилтэд зайлшгүй шаардлагатай.
- Зарчим 5. Шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй байх нөхцөлийг хангах нь шүүхийн зохих үйл ажиллагааны зайлшгүй шинж мөн.
- Зарчим 6. Ур чадвар, хичээнгүй байдал нь шүүхийн зохих үйл ажиллагааны урьдчилсан нөхцөл мөн.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014.02.28-ны өдрийн 1/08 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдаж 2014.03.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байгаа “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийг дээрх Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын дийлэнх хэсгийн агуулга, зохицуулалтад нийцүүлсэн гэж үзэж болох юм. Үүнийг “зохисгүй байдал” гэдэгт хууль, хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, энэ дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж тодорхойлсноос харж болно.

1.3. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний тайлбар

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм болон Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсруулахад үндэс болгосон⁵ Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд нь үндсэн дөрвөн хэсэгтэй, 11 нүүр бүхий “цомхон” баримт бичиг⁶ бөгөөд түүнийг

⁵ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, 2013, <http://www.legalinfo.mn/uploads/huulichdiin%20bvrtgel/tusluud/5.pdf>

⁶ The Bangalore Principles of Judicial Conduct, 2002
http://www.unodc.org/pdf/crime/corruption/judicial_group/Bangalore_principles.pdf

тайлбарласан “Тайлбар” бүтээл нь 175 нүүр бүхий томоохон бүтээлд тооцогддог.⁷

Учир нь НҮБ-ын дэмжлэг, зохион байгуулалтаар эрх зүйн бүлүүдийг төлөөлөх олон улсын хэмжээний эрдэмтэн, судлаач, шүүгчдийн оролцоотой хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд улс орнуудын шүүгчийн ёс зүйн 24 дүрэм, шүүгчийн ёс зүйн асуудлаарх бүс нутгийн болон олон улсын хэмжээний 8 дүрэм, зарчим, стандартыг үндэслэн “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбар”-ыг туурвиж, нийтэлсэн байна.⁸

Энэхүү тайлбарыг бэлтгэхийн тулд олон тооны эх сурвалж ашиглан, санаа сэдэл авсан. Үүнд олон улсын баримт бичгүүд, шүүгчийн ёс зүйн талаарх үндэсний дүрмүүд, тэдгээрийн тайлбар, олон улс, бүс нутгийн болон үндэсний шүүхийн шийдвэрүүд, шүүгчийн ёс зүйн зөвлөлдөх хорооны дүгнэлтүүд, хэлэлцүүлгийн материалууд хамаарна. Тус тайлбарыг бүрэн эхээр нь хавсралтаас үзнэ үү.

Зарим судлаачийн тэмдэглэснээр, ардчилал хөгжсөн орнуудад хуульчийн мэргэжлийн дүрмийн заалт тус бүрийн утга санааг тодруулсан тайлбар гаргадаг. Ийнхүү тайлбарлахдаа бусад орны туршлага, эрдэмтдийн бүтээл, онол, хийсвэр болон бодитой жишээг ашигладаг. Дүрмийн ийм тайлбар гаргаснаар хуульчид, эрх зүйчид, хуулийн оюутнууд хуульчийн мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээний агуулгыг зөв ойлгох, өөрийгөө төлөвшүүлэх, өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхэд тустай. Дүрмийн талаар сургалт явуулж, тайлбар, гарын авлага бэлдэж хуульчдад хүргэх ажил тогтмол хийгдвэл дүрэмд орсон үнэт зүйл, зарчмууд биеллээ олно.⁹

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Улсын дээд шүүхээр хянагдан гарсан Шүүхийн ёс зүйн хорооны хүчин төгөлдөр магадлалаар 3 шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахдаа¹⁰ Монгол Улсын

⁷ United Nations Office on Drugs and Crime. Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct. September 2007.

https://www.unodc.org/documents/corruption/publications_unodc_commentary-e.pdf

⁸ United Nations Office on Drugs and Crime. Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct. September 2007. p. 5-22

https://www.unodc.org/documents/corruption/publications_unodc_commentary-e.pdf

Ташрамд хэлэхэд “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм” эмхэтгэлд орсон “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын монгол хэл дээрх орчуулгад тус зарчмуудын “Үнэт зүйл 5. Тэгш байдал” гэсэн хэсгийг дутуу хэвлэж, “Үнэт зүйл 6. Эрх хэмжээ ба хичээл зүтгэл”, “Хэрэгжилт”, “Тодорхойлолт” гэсэн хэсгүүдийг бүхэлд нь хэвлээгүй байна.

⁹ О.Мөнхсайхан. Мэргэжлийн дүрмийн заавал биелэгдэх шинжийг хангасан /ярилцлага/. 2013.10.17 <http://www.news.mn/r/159387>

¹⁰ Үүнээс 2 шүүгчид сануулах, 1 шүүгчид цалинг тодорхой хугацаагаар бууруулах болон огцруулах сахилгын шийтгэл ногдуулсан.

шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн зарим заалтыг тайлбарласан байна.¹¹

Хүснэгт 1. Шүүхийн ёс зүйн хорооноос хүчин төгөлдөр магадлалдаа тайлбарласан Шүүгчийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн заалт

№	Зүйл, заалт	Утга
Шүүгчийн ёс зүйн дүрмийн заалт		
1	1.4 дүгээр зүйлийн 2	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй ¹²
2	2.3 дугаар зүйлийн 1	Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ ¹³
3	3.3 дугаар зүйлийн 3	Шүүгч ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ согтуурах, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, эсхүл ийм байдалтай ажилдаа ирэхийг хориглоно ¹⁴

¹¹ Шүүхийн ёс зүйн хорооноос Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн зарим заалтыг тайлбарлахдаа заалтын дугаарыг буруу бичих дутагдал байгааг дурдах нь зүйтэй байна. Тухайлбал, Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 5.17 дахь заалтыг 5.1.7 гэх, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тайлбарлахдаа 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг гэж бичсэн байна.

¹² 1.4 дүгээр зүйлийн 2-т заасан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэх утгыг “... Энэ заалт нь шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчмыг тунхагласан хэрэг. Тиймээс шүүхийн шийдвэрийн агуулгад үнэлэлт, дүгнэлт өгөх эрх хэмжээ Шүүхийн ёс зүйн хороонд байхгүй” тайлбарлажээ.

Шүүхийн ёс зүйн хорооны 2016.05.20-ны өдрийн 34 дүгээр магадлалын 11 дэх тал

¹³ 2.3 дугаар зүйлийн 1-д заасан “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гэх утгыг “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Үнэт зүйл 4. Зохистой байдал” гэх хэсэгт тулгуурлан “... шүүгч хүн шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан эсхүл тийнхүү ойлгогдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийсэн бол зохисгүй байдал гаргасан гэж үздэг. Зохисгүй гэж ойлгогдсон эсэхийг хэмжих шалгуур бол шүүгчийн явуулсан үйл ажиллагаа нь хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн эсхүл шүүгчийн үнэнч, төвийг сахисан, шүүгчийн зан төлөвт нийцэхгүй гэсэн ойлголтыг ухаалаг бие хүнд төрүүлэх үү гэсэн асуулт юм.... Шүүгчийн зохисгүй үйл ажиллагаа эсхүл зохисгүй харагдах үйл ажиллагаа нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хамгийн ихээр эвддэг. Зохисгүй байдлаас зайлсхийх зарчим нь шүүгчийн мэргэжлийн болон хувийн амьдралд аль алинд нь үйлчилдэг. Шүүгч хүн шүүх танхимд болон шүүхээс гадуур шүүхийн тогтолцоо нь хараат бус, төвийг сахисан, үндэслэл бүхий шийдвэр, үйл ажиллагаагаар хэрэгждэг гэсэн ойлголтыг бий болгох, хадгалахын төлөө хичээх хэрэгтэй. Энэ зорилгод хүрэхийн тулд шүүгч нь ямагт шүүх танхимд байгаа мэт зан үйлээ авч явах шаардлагатай болдог. Энгийн иргэний хувьд хэрэгжвэл хэтэрхий дарамттай, хүнд мэт санагдаж болох олон нийтийн хяналтанд байдаг тул жирийн иргэний хувьд бэрхшээлтэй байж болох хувийн эрхийг хязгаарласан хэм хэмжээг өөрөө өөртөө тогтоож мөрдөх ёстой бөгөөд эдгээр хязгаарлалтыг өөрөө сайн дураараа сахин хэрэгжүүлнэ” гэж тайлбарлажээ.

Шүүхийн ёс зүйн хорооны 2015.03.17-ны өдрийн 22 дугаар магадлалын 5 дахь тал

¹⁴ Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3-т заасан “Шүүгч ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ согтуурах, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, эсхүл ийм байдалтай ажилдаа ирэхийг хориглоно” гэх утгыг тухайн тохиолдолтой уялдуулан “... энэ заалтаас үзэхэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ шүүгч ажлын

4	5.1 дүгээр зүйлийн 3	Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй ¹⁵
Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн заалт		
5	5.7	Нийт гишүүдийн хуралдаанаас гомдлыг хянан хэлэлцэх хуралдааны тогтоол, гомдлыг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана ¹⁶

Харин Улсын дээд шүүхээс зарим зүйл, заалтыг Шүүхийн ёс зүйн хорооны тайлбарласнаас өөрөөр тайлбарлаж байгааг анхаарахгүй өнгөрч

болон ажлын бус цагаар шүүхийн байранд ирж болохгүй. Хэрэв шүүгч архи хэрэглэсэн үедээ ажлын байранд (шүүх дээр) ирвэл тухайн шүүгч согтуугаар шүүхийн шийдвэрээ бичдэг, шүүгчийн үүргээ гүйцэтгэдэг гэсэн ойлголтыг төрүүлнэ. Архи хэрэглэсэн (согтуу) хүн зөв шийдвэр гаргах чадвараа алддаг тул олон нийт тухайн шүүгч төдийгүй шүүхийн шударга, төвийг сахисан, зарчимч, мэргэжлийн шаардлага хангасан байдалд эргэлзэхэд хүрнэ” гэж тайлбарлажээ.

Шүүхийн ёс зүйн хорооны 2015.03.17-ны өдрийн 22 дугаар магадлалын 4 дэх тал

¹⁵ 5.1 дүгээр зүйлийн 3-т заасан “Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй” гэх утгыг “... Шүүгчийн ёс зүйн зөрчил гарсан тухай гомдлыг хянан шийдвэрлэхэд хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэх эсэх асуудлыг хууль болон дүрэмд өөр өөрөөр зохицуулсан байх бөгөөд бие биетэйгээ зөрчилдсөн эдгээр зохицуулалтуудаас аль нэгийг нь сонгож хэрэглэхдээ хууль зүйн нийтлэг зарчмыг баримтлах ёстой.¹⁵ Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөж хэрэгждэг хууль зүйн үндсэн зарчмуудын нэг нь дээд эрэмбийн хууль зүйн хэм хэмжээ нь доод эрэмбийн хэм хэмжээгээс давуу хүчин чадалтай, дээд эрэмбийн хэм хэмжээнд доод эрэмбийн хэм хэмжээ нь нийцсэн байх ёстой гэсэн зарчим юм (Жишээ нь, Үндсэн хуулийн 51.3, 66.4). Энэ зарчмын дагуу Шүүгчийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрэмд тогтоосон хөөн хэлэлцэх хугацаанууд нь зөвхөн шүүгчийн ёс зүйн шаардлагыг хангасан хүн шүүгчээр ажиллах болон шүүгчийн ёс зүйн зөрчил гарсан тухай гомдлыг Шүүхийн ёс зүйн хороо заавал хянан шийдвэрлэх тухай Үндсэн хууль болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн заалтуудыг зөрчсөн байх тул Шүүхийн ёс зүйн хороо нь эдгээр хөөн хэлэлцэх хугацаанд захирагдах үүрэггүй байна. Иймд шүүгчийн ёс зүйн зөрчилд хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэх тухай хуульд заагаагүй байхад дүрмээр 6 сар зэрэг хэт богино хугацаа тогтоосныг хэрэгжүүлбэл хууль зөрчигдөх, шүүгчид хариуцлага тооцох механизмыг сулруулж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг унагах сөрөг үр дагавар нийгэмд бий болно” гэж тайлбарлажээ.

Шүүхийн ёс зүйн хорооны 2016.05.20-ны өдрийн 34 дүгээр магадлалын 9 дэх тал

¹⁶ Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 5.7-д “Нийт гишүүдийн хуралдаанаас гомдлыг хянан хэлэлцэх хуралдааны тогтоол, гомдлыг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана” гэх утгыг “...Шүүхийн ёс зүйн хорооны хуралдаан зөвхөн анхны гомдлын хүрээнд буй ёс зүйн асуудлыг шийдвэрлэнэ гэж явцууруулан ойлгож болохгүй. Учир нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1-д “Ёс зүйн хороо сахилгын хэргийг 30 хоногийн дотор нийт гишүүний олонхын ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ” гэж заасан. Тиймээс, Шүүхийн ёс зүйн хорооны бүрэн эрхийг зөвхөн гомдлын хүрээгээр хязгаарлаж болохгүй, харин сахилгын хэргийн хүрээнд авч үзэх нь илүү зохистой. ... Иргэнээс Шүүхийн ёс зүйн хороонд анх гомдол ирүүлэх үед шүүгч дурдсан зөрчлийг гаргаагүй байсан ч ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу Шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах явцад шүүгч дурдсан ёс зүйн зөрчлийг гаргасан бол Шүүхийн ёс зүйн хороо ёс зүйн зөрчлийг заавал шийдвэрлэх чиг үүргийнхээ дагуу шалгаж шийдвэр гаргах бүрэн эрхтэй. ...” гэж тайлбарлажээ.

Шүүхийн ёс зүйн хорооны 2016.05.20-ны өдрийн 34 дүгээр магадлалын 10 дахь тал

болмооргүй санагдана. Хүснэгт 2-т үзүүлснээс дараах дүгнэлт хийж болохоор байна. Үүнд:

- Шүүгчийн ёс зүйн зөрчлийг зөвхөн гомдлын хүрээнд шалгах эсэх талаар харилцан адилгүй тайлбар хийсэн байна. Энэ хүрээнд талууд гомдолд заагаагүй асуудал ба гомдлыг тайлбарласан эсэхийг ялгах шаардлагатай байна.
- Ёс зүйн зөрчил тус бүрийг ялган түүнд тодорхой заалтыг дахин хэрэглэж болохоор байна.
- Ёс зүйн зөрчил гаргасан, зөрчлийг илрүүлсэн хугацаа болон хөөн хэлэлцэх хугацаа хэзээ тасалдсан болохыг Шүүхийн ёс зүйн хорооноос тухай бүр тогтоож байх нь зүйтэй байна.
- Шүүгчийн ёс зүйн хорооны Ажлын албанаас Шүүгчийн ёс зүйн хорооны хуралдааны товыг гүйцэт, хоёрдмол утгагүйгээр мэдэгдсэн эсэхэд хяналт тавьж байх нь чухал байна.

Хүснэгт 2. Улсын дээд шүүх ба Шүүхийн ёс зүйн хороо Шүүгчийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн заалтыг өөрөөр тайлбарлаж буй байдал

№	Шүүхийн ёс зүйн хорооны тайлбар	Улсын Дээд шүүхийн тайлбар
1	Иргэнээс Шүүхийн ёс зүйн хороонд анх гомдол ирүүлэх үед шүүгч дурдсан зөрчлийг гаргаагүй байсан ч ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу Шүүхийн ёс зүйн хороонд тайлбар гаргах явцад шүүгч дурдсан ёс зүйн зөрчлийг гаргасан бол Шүүхийн ёс зүйн хороо ёс зүйн зөрчлийг заавал шийдвэрлэх чиг үүргийнхээ дагуу шалгаж шийдвэр гаргах бүрэн эрхтэй. ...” гэж тайлбарлажээ. ¹⁷	... гомдол гаргагчаас гомдлын үндэслэлээ нэмж, маргасан ба энэ хүрээнд Шүүхийн ёс зүйн хороо зөрчлийг хянан шийдвэрлэсэн нь “гомдолд заагаагүй үндэслэлээр ШЕЗХ өөрөө бусад зөрчлийг илрүүлж, сахилгын шийтгэл оногдуулсан” гэж үзэх үндэслэл болохгүй. ... Шүүгчийн гаргасан тайлбарыг үндэслэн түүний зан байдал, ёс зүйг тодорхойлсон Шүүгчийн ёс зүйн хорооны дүгнэлтийг буруу гэж үзэхгүй. ¹⁸ Шүүгчийн ёс зүйн хороо нь гомдолд дурдаагүй асуудлаар шүүгчийг шалгаж, зөрчил илрүүлэн, уг зөрчилд холбогдуулан сахилгын хэрэг үүсгэж, улмаар сахилгын арга хэмжээ оногдуулсан нь Ёс зүйн хорооны гишүүний бүрэн эрхийн талаар Шүүхийн захиргааны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-д “гомдол, хүсэлтийн дагуу шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах” гэж заасантай нийцэхгүй байна. ¹⁹ ... Шүүгчийн ёс зүйн дүрмийн тодорхой заалтыг

¹⁷ Шүүхийн ёс зүйн хорооны 2016.05.20-ны өдрийн 34 дүгээр магадлалын 10 дахь тал
¹⁸ Улсын Дээд шүүхийн 2016.10.12-ны өдрийн “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 297 дугаар тогтоолын 4 дэх тал
¹⁹ Улсын Дээд шүүхийн 2015.01.12-ны өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 11 дүгээр тогтоолын 5 дахь тал

		давтан хэрэглэсэн байдал нь нэг зөрчилд давхар хариуцлага оногдуулах ойлголт биш ²⁰
2	Шүүхийн ёс зүйн хороо нь Шүүгчийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрэмд тогтоосон хөөн хэлэлцэх хугацаанд захирагдах үүрэггүй байна. ²¹	... Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тасалдах зохицуулалтыг шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэхэд хэрэглэнэ. ²² Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг Шүүгчийн ёс зүйн дүрэм хэрэгжиж эхэлсэн 2014.03.01-ний өдрөөс өмнөх хугацаанд хамаарах зөрчил гаргасан гэх асуудалд хэрэглэнэ. ²³ “Зөрчил гаргаснаас хойш 6 сар өнгөрсөн” гэсэн нь зөрчил гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор уг зөрчил илрээгүй, мэдэгдээгүй өнгөрсөн байхыг ойлгоно. ²⁴

Иймд шүүхийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийг оролцогч талууд нэг мөр ойлгож хэрэглэхийн тулд ёс зүйн дүрмийн тайлбар бүтээл гаргах, Шүүхийн ёс зүйн хороо болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс магадлалдаа шүүгчийн ёс зүйн дүрмийн заалтыг тогтмол тайлбарлаж байх шаардлагатай байна. Энэ хүрээнд “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбар”-ыг монгол хэл дээр орчуулж, сургалтад хэрэглэх нь зүйтэй байна.

ХЯНАЛТЫН АСУУЛТ

- Хуульч болон шүүгчийн чиг үүрэг, онцлогийн талаар НҮБ-аас ямар баримт бичиг гаргасан бэ?
- Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг олон улсын хэмжээнд ямар баримт бичигт тодорхойлсон бэ?
- Шүүгчийн ёс зүйн дүрмийн заалтыг тайлбарлах нь ямар ач холбогдолтой вэ?
- Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудыг хэн, хэзээ, ямар хугацаанд боловсруулсан бэ?
- Шүүгчийн ёс зүйн дүрэмтэй ямар улс орнууд байдаг вэ?
- Шүүгчийн ёс зүйн дүрмийг ихэвчлэн ямар субъект баталдаг вэ?

²⁰ Улсын Дээд шүүхийн 2016.10.12-ны өдрийн “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 297 дугаар тогтоолын 4 дэх тал.

²¹ Шүүхийн ёс зүйн хорооны 2016.05.20-ны өдрийн 34 дүгээр магадлалын 9 дэх тал

²² Улсын Дээд шүүхийн 2016.10.12-ны өдрийн “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 297 дугаар тогтоолын 4 дэх тал.

²³ Улсын Дээд шүүхийн 2016.02.22-ны өдрийн 51 дүгээр тогтоолын 4 дэх тал

²⁴ Улсын Дээд шүүхийн 2015.06.08-ны өдрийн “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 145 дугаар тогтоолын 4 дэх тал

- Шүүхийн хараат бус, шүүгчийн бие даасан байдлыг хангах асуудлаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, заншлын хэмжээ нь шүүгчийн ёс зүйн дүрэмтэй хэрхэн уялдах вэ?
- Шүүгчийн ёс зүйн дүрэмгүй улс орны онцлог юу вэ?

АНХААРАХ АСУУДАЛ

Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний талаарх үзэл баримтлал, онолын ойлголтыг Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчимд бүрэн тусгасан бөгөөд Монгол Улсын шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг ойлгож хэрэглэх, тайлбарлахад Бангалорын зарчим, түүний тайлбарыг хэрэглэх нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

1. Шүүгчийн ёс зүйн дүрэм
2. Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм
3. Улсын Дээд шүүхийн 2016.10.12-ны өдрийн “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 297 дугаар тогтоол
4. Улсын Дээд шүүхийн 2015.01.12-ны өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулсан Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 11 дүгээр тогтоол
5. Улсын Дээд шүүхийн 2016.10.12-ны өдрийн “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 297 дугаар тогтоол
6. Улсын Дээд шүүхийн 2016.02.22-ны өдрийн 51 дүгээр тогтоол
7. Улсын Дээд шүүхийн 2015.06.08-ны өдрийн “Шүүхийн ёс зүйн хорооны магадлалын тухай” 145 дугаар тогтоол
8. Шүүхийн ёс зүйн хорооны 2016.05.20-ны өдрийн 34 дүгээр магадлал
9. Шүүхийн ёс зүйн хорооны 2015.03.17-ны өдрийн 22 дугаар магадлал
10. OHCHR | Basic Principles on the Independence Of the Judiciary
11. The Bangalore Principles of Judicial Conduct, 2002
12. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, 2013
<http://www.legalinfo.mn/uploads/huulichdiin%20bvrtgel/tusluud/5.pdf>
13. United Nations Office on Drugs and Crime. Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct. September 2007.
14. О.Мөнхсайхан. Мэргэжлийн дүрмийн заавал биелэгдэх шинжийг хангасан /ярилцлага/. 2013.10.17 <http://www.news.mn/r/159387>

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ

- О.Номуулин, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч*
- Ц.Мөнхтулга, Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч*
- А.Сарангэрэл, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч*
- П.Баярцэцэг, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн Шүүхийн сургалт хариуцсан ахлах референт*

БҮЛЭГ 2. ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ

Зорилго: Шүүх эрх мэдэл бие даасан, шүүгч хараат бус, зарчимч, төвийг сахисан байх зарчим, түүний агуулга, хэрэгжилтийг онолын үүднээс системтэй танин мэдэж мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах чадварт суралцуулах.

Нэр томьёо:

- Шүүх эрх мэдэл
- Бие даасан байдал
- Зарчимч байдал
- Төвийг сахих байдал
- Зохистой байдал
- Үнэнч шударга байх
- Хичээл зүтгэл гаргах
- Мэргэжлийн шаардлага хангах

Дэд сэдэв:

- *Хуулийг биелүүлэх, хууль хэрэглэх*
- *Хэрэг маргааныг заавал шийдвэрлэх*
- *Хэргийн нэг талтай харилцах*
- *Шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг хадгалах*
- *Мэргэжлийн шаардлага хангах, хичээл зүтгэл гаргах*
- *Тэгш хандах*
- *Шүүгчийн нэр хүндийг урвуулан ашиглахгүй байх*
- *Шүүгчийн үйл ажиллагааг гаднын нөлөөнөөс хамгаалах*
- *Нууцыг задруулахгүй байх*
- *Хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргааны талаар мэдээлэх*

2.1. Хууль биелүүлэх, хууль хэрэглэх

Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль болон шударга ёсонд захирагдаж хуулийг хэрэглэнэ, хуулийг биелүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”,

Шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйл. Шүүх хууль дээдлэх, гагцхүү хуульд захирагдах

7.1. Хууль дээдлэх нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

7.2. Шүүхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг гагцхүү хуулиар зохицуулна.

7.3. Шүүх хүчин төгөлдөр болсон, албан ёсоор нийтлэгдсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

7.4. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж шүүх үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, уг хууль, Монгол Улсын олон улсын гэрээний талаарх саналаа Улсын дээд шүүхэд гаргана.

Ийнхүү манай улсын тулгуур суурь хууль болох Үндсэн хууль, Шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг Шүүхийн тухай хуульд шүүгч нь "хууль дээдэлж хуулийг хэрэглэх" үндсийг тодорхойлж өгчээ.

Шүүгч хууль хэрэглэнэ гэдэг нь тайлбарлахын нэр юм. Энэ явцад мэдээж эрх зүйн үр дагавар үүсгэнэ. Үүнийг хэрэг маргааныг шийдвэрлэх гэж ойлгож болно. Товчхондоо тухайн үйл баримт хуулийн ямар зүйл заалтад нийцэж ямар үр дагавар үүсгэхийг тодорхойлно гэсэн үг юм.

Шүүгч хуулийг тайлбарладаг өөр нэг чухал шаардлага нь хууль болон хууль тогтоогч нартай холбоотой. Амьдралд тохиолдож болох бүх тохиолдлыг хуулиар зохицуулах боломжгүй. Амьдралын нэг талыг бодоод хууль тогтооход нөгөө талд нь өөр зүйл үүсч бий болж байдаг. Нөгөө талаас хууль тогтоогч нарын хувьд тэдний мэдлэг чадвар 100 хувь төгс зүйл байдаггүй учраас санаатай, санамсаргүй алдаа гаргах, алсын хараагүй хууль бичих гэх мэт олон алдаа дутагдлыг тоочиж болно.

Шүүгч дээр өгүүлсэн шаардлагын дагуу хуулийг тайлбарлан хэрэглэхдээ тодорхой арга, дүрэм, зарчмын дагуу хууль тогтоогчийн санаа бодлыг алдагдуулахгүй байх, эрх зүйн суурь өөрчлөлт хийхгүй байх, хүний үндсэн болон салшгүй эрхийг дордуулахгүй байх, ухаалаг байх, үрэлгэн байдал гаргахааргүй байх гэх мэт зарчмыг баримталдаг.

Бидний өдөр тутам ярьдаг нэг "жижүүрийн" гэмээр хэллэг бий. Тэр бол "Шүүгч-хуульч мэргэжлийн ноён оргил мөн" гэх үг юм. Энэ үгийг хуульч болгон хэлдэг. Шүүгчийн ухаан чадал, чанар чансаа, өөр хэлж болох бүх аугаа зүйлийн охь, оргил нь хууль тайлбарлах чадвартай холбоотой. Үүний улмаас шүүгчийг жирийн нэг төрийн албан хаагч бус шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч, "шүүгч бол шүүгч" гэж үздэг¹.

Иймд Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” гэж заасан нь шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчмыг тунхагласан байна.

Энэ зарчим нь шүүгч аливаа хэрэг маргааныг буруу шийдвэрлээд хариуцлага хүлээнэ гэсэн айдасгүйгээр хууль зүйн хувьд хамгийн зөв гэсэн үндэслэлийнхээ дагуу хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх боломжийг шүүгчид олгодог учир нэг талаас шүүгчийн хараат бус байдлын баталгаа болдог, нөгөө талаас хуульд захирагдах зарчмыг ягштал баримтлахыг шүүгчид үүрэг болгодог.

Түүнчлэн, Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1-д “хууль дээдлэх” зарчмыг хувийн зан чанар болгон төлөвшүүлэхийг шүүгчид үүрэг болгоод зогсохгүй 3.3-т “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй” гэж тодорхой заасан байна.

Энэ нь шүүгч аливаа хэрэг маргааныг дур зоргоороо биш, зөвхөн хуулийг хэрэглэж, хууль зүйн үндэслэлээр, хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэйг тодорхойлсон гэж үзэж болно.

Шүүгчийн хууль буруу хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй байх зарчим болон хуульд захирагдах зарчим хоёрын зохицлыг хангах амаргүй байдаг байна. Өөрөөр хэлбэл эхний зарчмыг хэт баривал шүүгчийн хараат бус байдал нэрийн дор хуульд захирагдалгүй шийдвэр гаргадаг шүүгчийн хариуцлагагүй байдлыг дэвэргэх бол удаах зарчмыг хэтэрхий баримталбал шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй. Харин “хууль биелүүлнэ” гэдэг нь шүүгч жирийн иргэний адилаар хуулийг дагаж мөрдөн биелүүлнэ гэсэн ойлголт. Гэхдээ жирийн иргэний биелүүлдэг бүх үүргийг илүү манлайлан биелүүлэх үүрэгтэй. Үүнийг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3-т “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд ийнхүү ойлгогдохоос сэргийлнэ” гэж ерөнхий байдлаар зохицуулж өгсөн байна.

Өөрөөр хэлбэл шүүгч зөвхөн мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ бус шүүгчийн албан үүргээс бусад хувийн амьдралдаа зохисгүй байдал гаргахгүй байх үүрэгтэй.

Мөн дараах 2 нөхцөлийн аль нэг хангагдсанаас бусад тохиолдолд шүүгчийн хууль хэрэглэсэн алдаанд хариуцлага хүлээлгэхгүй.

1/ Үндсэн хуулиар илэрхий хамгаалсан үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн /хууль зүйн туслалцаа авах эрхээр огт хангахгүй байх г.м/

2/ Хэн ч маргахгүй хуулийн тодорхой заалтыг ноцтой буюу удаа дараа зөрчсөн / давж заалдах гомдол гаргах эрхийг нь эдлүүлэхгүй байх г.м /

Тохиолдол 1: Иргэн Б-ийн нэхэмжлэлтэй С компанид холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болжээ. Уг шийдвэрт тайлбар гаргуулахаар нэхэмжлэгч тал хүсэлт гаргасны дагуу хэргийг шийдвэрлэсэн шүүгч А шүүхийн шийдвэрт тайлбар хийсэн албан бичгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлсэн бөгөөд тэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхэлсэн болохыг мэдэж байсан байна. Гэтэл В компани Шүүхийн ёс зүйн хороонд хандаж гомдол гаргасан ба гомдолдоо “Шүүгч А шүүхийн шийдвэрт тусгагдаагүй тайлбарыг бичгээр өгсний улмаас манай компанийн эрх ноцтой зөрчигдлөө” гэжээ. Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх Тухай хуулийн /ИХШХШТХ/ 121 дүгээр зүйлийн 121.1-д “Шаардлагатай тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгч хэргийн оролцогчийн хүсэлтээр гагцхүү уг шийдвэрийг биелүүлж эхлэхээс өмнө түүний хууль зүйн үндэслэлийг аман болон бичгийн хэлбэрээр тайлбарлаж болно” гэж заасан.

Асуулт: Шүүгч А ёс зүйн зөрчил гаргасан уу? Эсхүл мэргэжлийн алдаа гэж үзэх үү?

Тохиолдол 2: Шүүгч А ихэд хартай бөгөөд эхнэрээ байнга зоддог нэгэн байжээ. Эхнэр нь ямар нэгэн байдлаар гомдол гаргадаггүй хүлцэнгүй нэгэн байдаг бөгөөд түүнийг эхнэрээ зодохыг нь удаа дараа харсан хөрш айлын эмэгтэй Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргасан байна. Тэрээр ямар нэгэн хэргийн оролцогч биш.

Асуулт: Шүүгч А-ийн үйлдэл ёс зүйн зөрчил мөн үү?

Тохиолдол 3: Шүүгч А-ийн машиныг амралтын өдрөөр саатуулж согтуурлын зэрэг тодорхойлох багажаар шалгахад тэрээр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн болох нь тогтоогджээ. Шүүгч А-ийн гаргасан дээрх зөрчилд Зөрчлийн тухай хуулиар захиргааны арга хэмжээ авсан. Гэтэл замын цагдаагийн байцаагч Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гарган шүүгч А-д сахилгын хариуцлага хүлээлгэхийг хүссэн байна.

Асуулт: Шүүгч А-д давхар хариуцлага ногдуулах уу? Ёс зүйн зөрчил гэж үзэх үү?

2.2. Шүүгч хэрэг маргааныг заавал шийдвэрлэх

Шүүгч томилогдсон өдрөөсөө хойш 30 хоногийн дотор хамт олон болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийн өмнө “Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж хэрэг, маргааныг хэнээс ч

хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч хуульд заасан хариуцлага хүлээнэ.” гэж Төрийн сүлдэнд тангараг өргөнө.

Ийнхүү шүүгч тангараг өргөсөн тохиолдолд хуульд заасан журмаар өөрт нь хуваарилагдан ирсэн хэрэг маргааныг заавал шийдвэрлэх үүрэгтэй.

Дээрх үүргийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 15.8-д “Хуульд эсхүл энэ дүрмийн 16.1-16.3 дугаар зүйлд заасны дагуу татгалзсанаас бусад тохиолдолд шүүгч хэрэг маргааныг заавал шийдвэрлэх үүрэгтэй” гэж баталгаажуулжээ.

Шүүгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд заасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй.

Эдгээр шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үндэслэлүүдийн талаар тусгайлсан сэдэв орох тул дэлгэрүүлэх шаардлагагүй бөгөөд харин яагаад Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр шүүгч хэрэг маргааныг заавал шийдвэрлэх үүргийг тусгайлан баталгаажуулж заасан нь энэ сэдвийн хүрээнд бидний ойлгож авах чухал асуудал болно.

Өөрөөр хэлбэл хууль, дүрэмд заасан татгалзах үндэслэл байхгүй тохиолдолд шүүгч тухайн хэрэг маргааныг заавал шийдвэрлэх, хууль, тогтоомжид заагдаагүй үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах эрхгүйг тодорхойлсон бөгөөд энэхүү хэм хэмжээг зөрчсөн зөрчил шүүгчийн ёс зүйн зөрчилд хамаарна гэж ойлгоно.

Тодруулбал, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр шүүгчид хүлээлгэсэн дээрх үүрэг Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3-т заасан Шүүгчийн баримтлах зарчмын “үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах” зарчимтай уялдах бөгөөд мөн дүрмийн 3.1-д заасан “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа, хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ” гэсэн шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйд хамаарахаар байгаа юм.

Хэргийг шийдвэрлэхээс татгалзан гарахад үндэслэлтэй нөхцөлийг байнга харгалзан үзнэ. Judge shopping²- хийж болохгүй. Танил талд байнгын

харилцаатай одоо найз нөхөд, ахын хэмжээнд харилцаатай байхыг ойлгох бөгөөд хэрэг хуваарилахаас эхэлнэ. Хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдолд татгалзахгүй байх ёстой. Хуульд заасан татгалзах шалгуур нь объектив шалгуур юм. Хэрэв хэрэг хуваарилах, татгалзах 2 байхгүй бол шударга ёс байхгүй. Тухайлбал, өөрийн нөхөр нь намын удирдах албан тушаалтан байсан уг намтай холбоотой асуудлыг шүүгч шийдсэн эсхүл нөхөр нь зээл авсан компанийн хэргийг шүүгч эхнэр нь шийдсэн зэрэг тохиолдлуудыг дурдаж болно. Нэг талаас хэргээ заавал шийдвэрлэх, нөгөө талаас ашиг сонирхлын зөрчлийн тэнцвэрийг олох хэрэгтэй. Өмгөөлөгчөөр нөхөрлөлд ажиллаж байсан шүүгчийн хувьд ажиллаж байх үед өмгөөлөгчөөр явж байсан, өөрөө оролцож байсан хэргийг шийдвэрлэхгүй бөгөөд гарсны дараа өөрөө оролцоогүй хэрэгт татгалзахгүй. Мөн шүүгч ажиллаж байсан нөхөрлөлөөсөө харилцаагаа татгалзсан байх ёстой.

Тохиолдол 4: Шүүгч А-д нэн ээдрээтэй, олон хавтас бүхий хэрэг хуваарилагдан иржээ. Тухайн жил шүүгч А-ийн нэлээд хэрэг дээд шатны шүүхээс хүчингүй болж буцсан бөгөөд дээрх хэргийг унших болон шийдвэр гаргахад их ярвигтай санагдсан байна. Иймд уг хэргийн гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаа хүнийг зүс таних шалтгаанаар, хуульд заасан “хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал” гэх үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарчээ.

Асуулт: Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан уу?

2.3. Шүүгч хэргийн нэг талтай харилцах

Аливаа мэргэжлийн ёс зүй нь тухайн мэргэжлийн өөрийн үүргээс урган гардаг. Өөрөөр хэлбэл ажлын онцлогоос үүсдэг гэж ойлгож болно. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэж тунхагласан бөгөөд энэхүү шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүхийн нэр хүнд гагцхүү “шүүгч”-тэй холбоотой билээ. Тэгвэл шүүгчийн нэр хүндийг гагцхүү түүний ёс зүйгээр тодорхойлох бөгөөд өөрөөр хэлбэл шүүгчийн нэр хүндийг ариун байлгах гол нөхцөл нь шүүгч хүн ёс зүйн хэм хэмжээгээ сахин биелүүлэх явдал мөн. Шүүгчийн ёс зүй бол шүүгч албан ажил болон хувийн амьдралдаа өөрийгөө хэрхэн авч явбал зохих, нийгмийн хүндэтгэл, итгэлийг хүлээн авч, түүнийг хадгалж явахын тулд шүүгчийн хариуцлагыг ухамсарлан хэрэгжүүлэхтэй холбоотой ойлголт юм.

Тодорхой хэргийн мэтгэлцэн маргалдаж байгаа 2 талын заргаа авсан тал нь баярласнаа илэрхийлэх нь таагүй уур амьсгал бүрдүүлдэг учир гол төлөв дуугүй өнгөрдөг бол заргаа алдсан тал нь шүүгчийг муулах, гүтгэх, сэжиглэх, хардах үүднээс муугаар ярьдаг нь шүүгчийн ажлын онцлог байдаг.

Тэгвэл хэргийг хэрхэн шийдвэрлэснээс хамаарахгүйгээр, харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч хэргийн оролцогчидтой харилцах харилцаанаас хамаарч шүүгчийг сэжиглэх, хардах, хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэхэд эргэлзээ төрөх үндэслэл бий болдог байна.

Шүүгч хэргийн аль ч оролцогчидтой харилцахдаа алагчлалгүйгээр тэгш, хүндэтгэлтэй хандаж шүүгчийн зүгээс хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг өөрийн ажил хэрэг, үг яриагаар төрүүлж чадахуйц сэтгэл зүй, мэдлэг, харилцааны соёлыг эзэмшсэн байх үүрэгтэй бөгөөд шүүхэд ажиллаж байгаа хэн бүхнээс ийнхүү харилцахыг шаардах эрхтэй.

Шүүгч хэргийн оролцогчидтой харилцах харилцааны хамгийн чухалд тооцогдох харилцааны хэлбэр нь “Шүүгч хэргийн нэг талтай харилцах” явдал юм.

2012 онд батлагдсан “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.17-д “хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах”-ыг шүүгчид хориглосон зохицуулалт анх удаа орсон бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах стандартыг тогтоож өгсөн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр шүүгч хэрэг маргааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах асуудлыг илүү дэлгэрэнгүй зохицуулж өгчээ.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 15.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Дор дурдсанаас бусад тохиолдолд шүүгч өөрийн шийдвэрлэх хэрэг маргааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах, тийм санаачилга гаргах, зөвшөөрөхийг хориглоно”,

1.1-д “Нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцсанаар нөгөө тал хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд давуу байдал олж авахгүй гэдэгт шүүгч үндэслэлтэйгээр итгэж байгаа бөгөөд нөгөө талтай харилцсан харилцааны агуулгыг бүх талуудад даруй мэдэгдэж хариу өгөх боломж олгосон тохиолдолд тухайн хэрэг, маргааны агуулгатай холбогдолгүй захиргааны, шүүх хуралдааны бэлтгэл хангах, тов тогтоох зэрэг асуудлаар нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцаж болно.

Үндэслэлтэйгээр итгэх гэж тодорхой нөхцөл байдалд хуульч хувийн бодит итгэл дээр тулгуурлан мэргэжлийн үйл ажиллагаа явуулж, үүнийгээ үндэслэлтэйгээр тайлбарлахыг ойлгож болно.

Энэ зохицуулалт нь шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар хэргийн нэг талтай уулзах зайлшгүй шаардлагатай байгаа тохиолдолд эхний ээлжинд тухайн этгээдтэй уулзсанаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд давуу байдал олж авахгүй гэдэгт бодит

итгэл үнэмшилтэй байх ёстой бөгөөд ийнхүү итгэл үнэмшил байгаа тохиолдолд харилцах гэж байгаа тухайгаа бусад оролцогчдод мэдэгдээд, хариу өгөх ердийн боломжит хугацаа өнгөрсний дараа хэргийн нэг талтай уулзана гэж ойлгогдож байна.

Мэдээлэлтэй зөвшөөрөл гэж хуульчаас санал болгосон үйл ажиллагаанаас үүсч болох эрсдэл, хууль зүйн үр дагавар болон бусад хувилбарын талаар хангалттай мэдээлэл, тайлбар өгснөөр үйлчлүүлэгч тухайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн илэрхийлэл.

Тохиолдол 5: Шүүгч А-д хуваарилагдан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа Доржийн нэхэмжлэлтэй Алимаад холбогдох хэрэгт шүүх хуралдааны тов тогтоох зайлшгүй шаардлагаар талуудтай уулзахаар цаг товлосон боловч нэхэмжлэгч ирээгүй бөгөөд хариуцагч Алимаа ирсэн байв. Хариуцагч Алимаагийн хувьд шүүгч А-тай 1 дүгээр ангид хамт суралцаж байгаад шилжин явсан сурагч болохыг тэр 2 хэн аль нь мэдэж, анх хараад бие биеэ таньсан ч үг дуугараагүй, таньсан байдлаа хэн хэн нь харуулаагүй. Нэгэнт уулзахаар товлосон байсан тул шүүгч А нэхэмжлэгчтэй утсаар ярьж хариуцагчтай уулзаад хуралдааны тов тогтоох тухайгаа хэлэхэд нэхэмжлэгч тэр даруй зөвшөөрч, өөрөө очих боломжгүйгээ илэрхийлсэн. Харин шүүгч “Алимаа надтай уулзахдаа өөрийнхөө хэн болохыг хэлчихвэл би таньсан дүр үзүүлэх үү яасан нь дээр вэ” гэж эргэлзэж байсан.

Асуулт: Шүүгч хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцаж болох уу?

Тохиолдол 6: Нэхэмжлэгч Дорж үндсэн зээл 10 сая төгрөг, түүний хүү 5 сая төгрөг, нийт 15 сая төгрөгийг хариуцагч Алимаагаас шаардсан ба хариуцагч нь үндсэн зээлийг төлөхийг зөвшөөрч хүүг багасгах хүсэлтэй байжээ. Шүүгч А талуудыг эвлэрүүлэх боломжтой гэж үзээд хариуцагч Алимаад эвлэрэн хэлэлцэх боломж, үр дагаврыг ойлгуулснаар нэхэмжлэгч болон түүний хуульчтай уулзсан.

Асуулт: Энэ тохиолдолд хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцаж болох уу? Нэхэмжлэгч нь хариуцагчийн хүсэлтийг хүлээн авч эвлэрэхийг хүсээгүй тохиолдолд шүүгчид ямар үүрэг үүсэх вэ?

Тохиолдол 7: Шүүгчийн утсанд танихгүй дугаарын утаснаас дуудлага ирэхээр нь авахад өөрт нь хянагдаж байгаа хэргийн нэхэмжлэгч байжээ. Тэрээр өөрийнхөө амьдралын гачигдалтай байдлыг тоочиж шүүх хурлаа хурдан хугацаанд хийлгэхийг хүсэхэд шүүгч түүнийг ихээр өрөвдөж хурлыг аль болох ойрын хугацаанд хийхээ илэрхийлсэн байна.

Асуулт: Энэ тохиолдолд шүүгч ямар үйлдэл хийвэл ёс зүйн зөрчилд тооцогдохгүй вэ?

2.4. Шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг хадгалах

Шүүгчийн ёс зүйн дүрмийн Нийтлэг үндэслэлд “Шүүгчийн ёс зүй, хариуцлагатай байдлыг бэхжүүлж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх” нь энэхүү дүрмийн зорилго болох тухай зохицуулсан.

Мөн Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын 1.6-д “Шүүгч шүүхийн стандартыг хэрэгжүүлэхдээ бусдад үлгэр дууриал болохуйц байж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэн шүүхийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ.”³, 2.2-д “Шүүгч нь өөрийн үйлдлийг шүүхийн танхимд ба шүүх ажиллагаанаас бусад цагт нийгэмд итгэл төрүүлэхүйц, хуулийн мэргэжлийг хүндэтгэн хэргийн холбогдогчдод шүүгч болон шүүхийн байгууллагын хараат бус байдлыг өөрийн үйлдлээр илэрхийлэн бэхжүүлнэ.”, 3.2-д “Шүүгч өөрийн үйл ажиллагаа, зан байдлаар бусдын шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой ажиллана.” гэж шүүгч өөрийн үйл ажиллагаагаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, хангахад чухал үүрэг, оролцоотой байхыг зохицуулжээ.

Түүнчлэн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн Хуульчийн баримтлах нийтлэг зарчмын 1.4.3-т “Хуульч шударга ёсны тогтолцоо, хуулийн засаглал, бие даасан, төвийг сахисан, шударга шүүхийг төгөлдөржүүлэх, олон нийтэд хүртээмжтэй болгохын төлөө хичээн ажиллана.” гэж заасан байна.

Шүүгч нь шүүхийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулахад хамгийн тохиромжтой байр суурь дээр ажиллаж байгаа хуульч. Иймээс шүүгч шүүхийг олон нийттэй холбоход чиглэсэн зохист үйл ажиллагаанд оролцож байх нь хэд хэдэн ач холбогдолтой. Өгүүлэл, нийтлэл хэвлүүлэх, сургалт явуулах зэрэг олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд шүүгч оролцсоноор тэдгээрт илүү мэдрэмжтэй хандах боломжийг шүүгчид олгодог. Нөгөө талаас, шүүхийн ажлын ачаалал мөн чанарыг ойлгох олон нийтийн ойлголт нэмэгдэж шүүхийг дэмжих дэмжлэг ч өсөх ач холбогдолтой.

Эргэцүүлэл, үндэслэл сайтай шийдвэр гаргахын төлөө уйгагүй ажиллаж шүүгчийн үүргээ сайтар гүйцэтгэхэд шаардагдах цаг хугацааг зарцуулдаг байхын зэрэгцээ олон нийтэд шүүхийг сайн ойлгуулахыг хичээх нь зүйтэй.

Шүүгч хэрэг маргааныг төвийг сахисан маргаан шийдвэрлэгчийн хувиар эцэслэн хянадагтай холбоотойгоор түүнийг олон нийт төвийг сахисан, шударга ёсны баталгаа гэж үздэг.

Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэхтэй холбоотой авч үздэг нэг онцгой тохиолдол бол олон нийт, нийгмийн тодорхой гишүүдээс шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэрийг шүүмжлэхэд шүүгчийн үзүүлэх хариу үйлдэл юм. Шүүгч хүн ямар ч тохиолдолд энэ төрлийн шүүмж, “хатгалга”-д хариу тайлбар тавих, зөвтгөх гэж оролдох нь зохисгүй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар давж заалдах, эсхүл шийдвэрт нь дүн шинжилгээ хийх, шүүмж бичих орон зайг нийгмийн бусад гишүүдэд үлдээх нь оновчтой бөгөөд ухаалаг шийдэл болох юм. Цаашилбал, шүүхийн өмнөөс төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах, асуудал шийдвэрлүүлэх зэргийг олон нийт “лобби” гэсэн агуулгаар харах боломжтой тул энэ төрлийн харилцаанд оролцохгүй байх нь оновчтой.

Хүний амьдралын, бизнесийн, улс орны хамгийн чухал маргаантай асуудлыг шийдвэрлэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй шүүгч нар олон нийтийн итгэлийг хүлээхүйц өндөр ёс зүйтэй байх шаардлагатай. Шүүгчийн ёс зүйн зөрчил олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг ихээр унагадаг учраас тэвчишгүй байх ёстой.

2.5. Мэргэжлийн шаардлага хангах, хичээл зүтгэл гаргах

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.6-д Хуульч мэргэжлийн шаардлага хангасан байх гэдэгт:

- Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадвартай байж, нямбай, хариуцлагатай ажиллах
- Хуульч нь мэргэжлийн өндөр төвшинд үйл ажиллагаа явуулахын төлөө мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж, өөрийгөө байнга хөгжүүлэх үүрэгтэй бөгөөд хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, эрдэм шинжилгээний бүтээлийг судалж байвал зохих
- Хуульч нь мэргэжлийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах

Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг хангаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дөрвөөс дээш жил мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй бол тухайн хуульч мэргэжлийн шаардлага хангасан эсэхэд эргэлзэх үндэслэл болно.

Хичээл зүтгэл

Шүүгчийн хичээл зүтгэл нь хэрэг маргаанд бүхий л талаас нь төвийг сахисан байдлаар бүрэн дүгнэлт хийж, шуурхай шийдвэрлэснээр илэрнэ.⁴ Хичээл зүтгэл гэдэг бол яг таг тодорхойлолт өгөх боломжгүй, харьцангуй утгатай нэр томъёо. Өдөр тутмын ажилдаа нухацтай хандаж, уйгагүй

гүйцэтгэж байгаа олон арван жишээнүүд бол хичээл зүтгэлийн ердийн илрэлүүд. Харьцангуй нэр томъёо учраас хичээл зүтгэлийн утга нь өөр өөр нөхцөл байдалд хэрхэн хэрэглэгдэж байгаагаас хамаардаг. Шүүгчийн хувьд “хичээл зүтгэл” гэдэг нь шүүгчийн үүргээ идэвх, зүтгэлтэй гүйцэтгэх буюу албан үүргийн дагуу оногдсон ажлаа амжуулахын тулд тууштай чармайх гэж тодорхойлж болно. Хэдийгээр хичээл зүтгэл нь хөдөлмөрч чанартай яг адилхан биш боловч байнгын чармайлт, анхаарал, шаргуу, цөхрөлтгүй, хянуур, уйгагүй, цуцашгүй занг багтаадаг.

Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын 6.3-т “Өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, шүүн таслах үйл ажиллагаа явуулахад шаардлагатай **хувийн зан чанараа сайжруулахад ямагт анхаарах үүрэгтэй** ба шүүх байгууллага, шүүгч нарын дунд зохион байгуулагдах сургалтад хамрагдах эрхтэй.”, 6.4-т “Олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц болон хүний эрхийн хэм хэмжээг тогтоосон бусад баримт бичгүүд, холбогдох өөрчлөлтүүдийн талаар тогтмол мэдээлэлтэй байх”, 6.5-т “Шүүхийн шийдвэр гаргах, шүүн таслах үйл ажиллагааг мэргэжлийн төвшинд, шударгаар, зохих хугацаанд хийж гүйцэтгэнэ.” гэж шүүгчийн хичээл зүтгэл гаргах зарчмыг дэлгэрэнгүй авч үзсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдэх хэрэг, маргааны тоо өндөр байгаа нь хичээл зүтгэлтэй хүнийг шүүгчээр сонгохын чухлыг илтгэж байна. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.7 дугаар зүйлд хичээл зүтгэл гаргах үүргийг бүх хуульчдад хүлээлгэсэн нь шүүгчид ч нэгэн адил хамаарах юм. ХМҮАБД-ийн 1.7-д хичээл зүтгэл гэдгийг “хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллах”-ыг хэлнэ гэж тодорхойлсон. Шүүгч хичээл зүтгэлтэй ажиллахын тулд хэд хэдэн дадлыг эзэмшсэн байх хэрэгтэй гэдэг нь энэ тодорхойлолтоос харагдаж байна. Ажилдаа үнэнч байх, чин сэтгэлээсээ хандах нь хичээл зүтгэлийн нэг тал бөгөөд энэ нь ажлаа гүйцэтгэхийн тулд хангалттай, зарим тохиолдолд илүү цаг зарцуулах эрмэлзэлтэй байна гэсэн үг. Хичээл зүтгэл нь хүчин чармайлт гаргах буюу хийх ёстой ажлаа тууштай, тогтвортой хийхийг шаарддаг. Ажлаа товлосон хугацаанд нь амжуулж гүйцэтгэдэг байх, ажлын цагийн хуваарь, дэг журмыг чанд сахих чадвар ч энд багтаж байгаа бөгөөд үүнийг чамбай байх гэдэг. Шуурхай ажиллах шаардлага шүүгчийн өмнө байнга тулгарч байдаг бөгөөд ажлын бэлтгэл бол энэ шаардлагыг хангахад нөлөөлж байдаг чухал хүчин зүйлүүдийн нэг мөн. Ажлын урьдчилсан бэлтгэл нь шуурхай ажиллагаанд нөлөөлөөд зогсохгүй асуудалд нухацтай хандаж, ул суурьтай дүгнэлт, шийдвэр гаргахад ч нөлөөлдөг. Хичээл зүтгэлийн хүрээнд яригдаж байгаа эдгээр шаардлага амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байна гэдэг нь

шүүгч шүүх хуралдааныг товлосон цагтаа нээж байна уу гэсэн энгийн зүйлээс хамаардаг. Шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг хадгалахын тулд шүүгч шүүх хуралдаанаа цагт нь нээдэг байх хэрэгтэй. Энэ мэтчилэн аливаа асуудалд шүүгч нягт нямбай хандаж, нарийн зүйл бүрт анхаарал хандуулж аливаа ажлыг бүрэн хийдэг байх ёстой.

Хичээл зүтгэлийн өөр нэг чухал тал бол шийдэмгий чанар бөгөөд энэ нь анхан шатны төдийгүй давах шатны шүүгчдэд чухал юм. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг урагш явуулахын тулд шүүгч нь эргэлзээ тээнэгэлзэлгүй, итгэл төгс шийдвэрт хүрэх эрмэлзэл, чадвартай байх ёстой.

Хичээл зүтгэлтэй шүүгч гэдэг бол сайн зохион байгуулагч мөн. Энэ бол цагийг зөв хуваарилах, асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлэх, шүүхийн ажилтнуудыг дээд зэргийн үр ашигтай ажиллуулах арга, чадвар сайтай байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, захиргааны бүх үүргээ зохих ёсоор гүйцэтгэдэг байх хэрэгтэй.

Хичээл зүтгэлийн ач холбогдлыг АНУ-ын Иллинойс Мужийн Дээд шүүх дараах байдлаар тодорхойлсон байдаг: “Шүүгч шүүгчийн үүргээ гүйцэтгэхдээ чамбай байх хэрэгтэй. Маргагч талууд, тангарагтны шүүгчид, өмгөөлөгчдийн хэн хэнийх нь хувьд цаг хугацаа бол үнэтэй зүйл. Тэрээр өөртөө чамбай зан, хичээл зүтгэлийг дадал болгон төлөвшүүлээгүй бол шүүхийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байдлыг үүсгэдэг.”⁵ Хичээл зүтгэл хэр их гаргах нь ажлын ачаалал, материаллаг болон оюун санааны нөөц чадавх, цаг хугацаа зэрэг олон хүчин зүйлсээр нөхцөлддөг. Энэ хүрээнд хичээл зүтгэл ба зохион байгуулалт, шийдмэг зан чанар, шүүгчийн албан үүргээ чухалчлах, мэдлэг, мэргэшил, чадвараа дээшлүүлж байх үүргийг авч үзнэ.

2.6. Тэгш хандах

Хүн бүр тэгш эрхтэй, гэхдээ бүх зүйлд биш

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрх, хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Тэгш эрх гэдэг бол хүн бүрд яг адил буюу эрх тэгш хандах зарчим мөн. Хүмүүс авьяас билэг, ур чадвар, гадаад байдал, дуртай зүйл зэрэг ихэнх шинжээрээ хэзээ ч яг адил байдаггүй. Тэгэхээр ямар утгаараа хүмүүс тэгш эрхтэй байх вэ? Хүмүүст хэзээ ямар үед эрх тэгш хандах нь зүйтэй вэ? гэдэг л гол асуудал. Тэгш эрхийн үндсэн төрлүүд нь ёс суртахууны, хууль зүйн, улс төрийн, эрх тэгш боломжоор хангагдах, аливаа үр шимийг эрх тэгш хүртэх зэрэг ба эхний гурван тэгш эрхийг хүн заавал эдэлнэ.

Дэлхийн түүхийн дийлэнх хугацаанд тэгш эрх гэдэг ойлголт ёс суртахууны зарчмын хувьд үгүйсгэгдэж, эсвэл бодит байдалд үл нийцэх зүйл хэмээн гадуурхагдаж байсан. Баяд ноёд, язгууртнууд болон тариачид, харц ардын хооронд ялгаатай хууль үйлчилж байсан бөгөөд хүмүүст ялгаатай хандах нь хэвийн үзэгдэл байжээ. МЭӨ 4-р зуунд анх Аристотель “Аливаа асуудлын хувьд түүнд холбогдох бүхий л талаар адил тэгш хүмүүст ялгаатай хандаж болохгүй” хэмээн өгүүлсэн байдаг. Хүн төрөлх чанарын хувьд эрх тэгш боловч улс төрийн засаглалын үед тэр нь өөрчлөгддөг. Тиймээс хүн төрөлх чанарын хувьд амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчтэй байх эрх бүх хүмүүст адил заяах ёстой гэж үзсэн. Энэ зарчимд тулгуурлан Америкийн Эрх Чөлөөний Тунхаглалд “хүн бүр эрх тэгш заяагдсан” хэмээн тодорхойлсон нь бий.

XIX зуун бол тэгш эрхийг хэрэгжүүлэхийн тулд боолчлолыг устгах, хуулийн өмнө эрх тэгш байх, иргэн бүр саналаа өгөх эрхтэй байх замаар улс төрийн тэгш эрхийг хангах зэрэг зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд тэмцэж байсан үе. Гэсэн ч олон оронд одоог хүртэл эмэгтэйчүүд санал өгөх эрхгүй, хар ба өнгөт арьстнуудыг улс төр, өмчийн тэгш эрх, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах нь түгээмэл байдаг.

XX зуунд социализм, коммунизмын сэргэлттэй холбоотойгоор тэгш эрхийг “материаллаг тэгш эрх” буюу үр дүнгийн тэгш эрхтэй холбон үзэх болсон. Мөн тэгш эрх тэгш боломжийн тухай ойлголт үндэслэгдсэн боловч аажимдаа үр дүнгийн тэгш байдалтай бараг ижил өөр ойлголтоор солигдсон юм.

Тэгш байдал бол өнгөрсөн болон одоо үеийн олон ард түмний туйлын хүслэн байсан ч аль ч нийгэмд тэгш биш байдал байсаар ирсэн. Тэгш биш байдал олон янзаар илэрч байдаг. Нас, хүйс, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг хүртэл тэгш биш байдлын үндэс болдог.

Манай улсын хувьд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй оролцоно хэмээн заажээ.

Шүүгчийн ёс зүйн дүрмээс

Хоёрдугаар бүлэг. Нийгмийн харилцаанд шүүгчийн баримтлах ёс зүй

2.1 дүгээр зүйл. Ялгаварлах үзэл гаргахгүй байх

1. Шүүгч нь хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлах, түүнчлэн тийм үйл ажиллагаанд дэмжиж оролцох эсхүл дээрх үйл ажиллагаа явуулдаг байгууллагад гишүүн байхыг хориглоно.
2. Шүүгч нь өмчийн аливаа төрөл, хэлбэрийг алагчилж болохгүй.

Гуравдугаар бүлэг. Шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүй

3.2 дугаар зүйл. Хэргийн оролцогчтой харилцах

1. Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна.

Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын Үнэт зүйлийн 5-д: Шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх нөхцөлийг хангах нь шүүхийн зохистой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай.

5.1 Арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн гарал, хөгжлийн бэрхшээл, нас, гэр бүлийн байдал, бэлгийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн бусад эх сурвалжаас үүссэн нийгмийн олон талт байдал, ялгааг шүүгч ойлгож мэддэг байвал зохино.

5.2. Шүүгч нь өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэж байхдаа үг хэл, үйлдлээрээ хэн нэгэн хүн, хэсэг бүлгийг ялгаварлан гадуурхах, үл тэвчих байдлын холбоотой болон холбогдолгүй асуудал гаргахгүй байх.

5.3. Шүүгч нь өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ хэргийн оролцогчид, гэрч, хуульч, өмгөөлөгч, шүүхийн ажилтан, хамтран зүтгэгч зэрэг хүн бүрийг журамд нийцсэн, зохистой байдлаар, ялгаварлалгүйгээр шүүнэ.

5.4. Шүүх байгууллагын ажилтан, болон бусад этгээд шүүхэд ажиллаж, оролцож байгаа хэн бүхнээс хүнийг ялгаварлах, гадуурхах зэрэг үйлдэл гаргахыг таслан зогсоохыг шаардах эрхтэй.

5.5. Хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдолд шүүхийн өмнө хуульч, өмгөөлөгч үг хэл, үйлдлээрээ хэн нэгнийг гадуурхах, ялгаварлах үйлдэл гаргахыг шүүгч нь залруулах үүрэгтэй.

Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл-Шүүгчдийн биеэ авч явах байдал, төвч байх зан байдлыг мэргэжлийн үүднээс зохицуулах зарчим болон дүрмийн тухай /2002 №3/

А. Шүүгчид шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ шударга, impartiality /шударгаар асуудалд хандах, бусдын нөлөөнд үл автах, аль нэг талыг баримтлахгүй/ байх

22. Шүүх эрх мэдэлд олон нийтийн зүгээс итгэх итгэл ба хүндэтгэл нь шүүх ажиллагаа үр дүнтэй байгаагийн баталгаа болж өгдөг. Шүүгчдийн

эрхэлж байгаа ажил, мэргэжлийнхээ салбарт *impartiality* байдлаар хандаж байгаа эсэхээс олон нийтийн ойлголт, шүүхэд *итгэх итгэл* хамаарч байдаг.

23. Тиймээс шүүгч нар ажил үүргээ хэрэгжүүлэхдээ *impartiality* байдлыг баримталж, урьдаас хоосон сэжиг төрүүлэхгүй ажиллах шаардлагатай.

24. Шүүгчид оролцогч талуудын эрх тэгш байдлыг хангах зарчмыг хүндэтгэж ямар ч алдаанаас болон ялгаварлан гадуурхахаас зайлсхийж, талуудын өрсөлдөх чадварыг дэмжих, үүргээ зохих ёсоор биелүүлэх ёстой.

25. Шүүх тогтолцооны үр ашигтай байдал нь шүүгчдээс мэргэжлийн өндөр төвшний мэдлэгийг шаарддаг. Шүүгчид энэ шаардлагыг хангахын тулд тэднийг хамруулах гэж сургалт, давтан сургалтад хамрагдаж байх нь зүйтэй.

26. Шүүгчид өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ боломжит хугацаанд асуудлыг шийдвэрлэж байх шаардлагатай.

Тохиолдол 8: Шүүгч Д.Б нь Сонгуулийн тухай хуулийг зөрчсөн гомдол хүлээн аваад нөгөө талд шүүх хуралдааны тов мэдэгдэлгүй хурал хийж шийтгэвэр гаргасан.

Асуулт: Эрх зөрчигдсэн үү? Тийм бол ямар ямар эрх

2.7. Шүүгчийн нэр хүндийг урвуулан ашиглахгүй байх, албан үүргээ чухалчлах

Шүүгчийн ёс зүйн дүрмээс

3.3 дугаар зүйл. Албаны чиг үүрэгтээ хандах

1. Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй.
2. Хэргийн оролцогчдын зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээр бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ.
3. Шүүгч ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ согтуурах, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, эсхүл ийм байдалтай ажилдаа ирэхийг хориглоно.
4. Шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх явцад бусадтай аливаа хэлбэрээр харилцах, зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулахыг хориглоно.

5. *Шүүгч шүүх хуралдааны явцад гар утас хэрэглэх зэрэг хэрэгт хамааралгүй өөр бусад үйл ажиллагаа явуулах хориглоно.*
6. *Шүүгч өөрийн удирдлага дор ажиллаж байгаа алба хаагчдад ажил мэргэжилдээ үнэнч байх, чин сэтгэлээсээ хандаж ажиллахыг шаардаж, өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ.*

Хуульчийн мэргэжлийн хариуцлагын дүрэм

15.3 дугаар зүйл. *Шүүгчийн нэр хүндийг урвуулан ашиглахгүй байх*

1. *Шүүгч хувийн ашиг сонирхлоо хангах зорилгоор шүүгчийн албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, эсхүл бусад этгээдэд тийнхүү ашиглахыг зөвшөөрөхийг хориглоно.*

Үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах, хичээл зүтгэл гаргах

Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх үүрэг нь шүүгчийн ёс зүйн бусад зарчмуудтай нягт уялдаатай. Өөрөөр хэлбэл, ёс зүйн нэг зарчмыг зөрчихөд л мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх зарчим хөндөгддөг. Шүүгч нь нийгмийн амьдралд энгийн иргэдийн адил үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг эрхтэй боловч улс төрийн итгэл үнэмшлээ илэрхийлэх, түүний үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх зэрэг тохиолдолд хязгаарлалттай байдаг. Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэхтэй холбоотой нийгмийн харилцаанд хоёр төрлийн хязгаар бий. Эхнийх нь шүүгчийн үг, үйлдэл, бусад илэрхийлэл шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хөсөрдүүлэх, бусдаас хараат бус байх, төвийг сахих зарчмыг алдагдуулах үр дагавартай байх, хоёрдугаарт шүүхийн болон шүүгч мэргэшлийн нэр хүнд алдагдах шинжтэй бол шүүгч энэ төрлийн харилцаанд оролцох, улс төрийн болон бусад элдэв хэлэлцүүлгийн сэдэв болохоос сэргийлэх ёстой.⁷

Хариуцлага гэдэг нь хоёр агуулгатай ойлголт. Нэг талаас хууль, дүрэм, журам, ёс суртахууны энгийн хэм хэмжээ зөрчсөн тохиолдолд түүний үр дагаварт ирэх нөлөөллийг хэлэх бол нөгөө талаас аливаа асуудалд хичээл зүтгэлтэй, анхааралтай, түргэн шалмаг, үр дүнтэй хандахыг бас хэлнэ. Шүүгчийн ёс зүйн олон улсын зарчим, жишгээс харахад хичээл зүтгэл гаргах (Diligence) гэсэн нэр томъёо нь шүүгчийн хариуцлагатай байдалтай түлхүү холбогддог. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын 6 дахь үнэт зүйлийг “мэргэжлийн шаардлага ба хичээл зүтгэл” гэж нэрлэсэн бөгөөд “мэргэжлийн шаардлага хангасан байх болон хичээл зүтгэл гаргах нь шүүгчийн албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэхэд зайлшгүй” хэмээх зарчмыг хүлээн зөвшөөрсөн.

Чадамжтай байх

Зарчим:

Чадвар, чадамжтай, няхуур байх нь шүүх байгууллагын үйл ажиллагааны чухал хэсэг мөн.

6.1. Шүүн таслах үйл ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал байна.

6.2. Шүүгч нь өөрийн мэргэжлийн ур чадварыг шүүн таслах үйл ажиллагаанд бүрэн зориулах ба үүнд шүүн таслах, шийдвэр гаргах үүрэг хариуцлага багтах төдийгүй, шүүхийн байгууллагатай холбоотой бүхий л үйл ажиллагаа хамаарна.

6.3. Өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, шүүн таслах үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хувийн зан чанараа сайжруулахад ямагт анхаарах үүрэгтэй ба шүүх байгууллага, шүүгч нарын дунд зохион байгуулагдах сургалтад хамрагдах эрхтэй.

6.4. Олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц болон хүний эрхийн хэм хэмжээг тогтоосон бусад баримт бичгүүд, холбогдох өөрчлөлтүүдийн талаар тогтмол мэдээлэлтэй байх,

6.5. Шүүхийн шийдвэр гаргах, шүүн таслах үйл ажиллагааг мэргэжлийн төвшинд, шударгаар, зохих хугацаанд хийж гүйцэтгэнэ.

6.6. Шүүх хурлыг дэг журмын дагуу явуулах ба хэргийн холбогдогчид, иргэдийн төлөөлөгч, гэрч, хуульч, өмгөөлөгч болон бусад мэргэжлийн хувьд харьцаж байгаа этгээдүүдтэй эелдэг, тэгш, хүндэтгэлтэйгээр хандаж, тэвчээртэй, ёс зүйтэй, энгийн харьцана. Шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдүүдэд шүүхийн дэг журамд захирагдахыг зөвлөнө.

6.7. Шүүгчийн ёс зүйд харшилсан аливаа үйл ажиллагаа, үйлдэл гаргахыг хориглоно.

Тохиолдол 9: Нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулсан мэтээр О шүүгчийн туслах нь хариуцагчийн өмнөөс гарын үсэг зурсан, өөрийн туслахын гаргасан зөрчлийг мэдсэн атлаа холбогдох арга хэмжээг аваагүй, зохих ёсоор шийдвэрлүүлээгүй, зохигчдын эвлэрлийг батлах ажиллагаанд шүүгч өөрөө хуульд заасны дагуу зохих ёсоор хяналт тавиагүй, гомдол гаргагчийн төлбөрийн тооцоог нягталж шалгалгүй шийдвэрлэсэн.

Асуулт: Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан уу? Хэлэлцэнэ үү.

Тохиолдол 10: Шүүгч М нь ИХШХШТХ-ийн 119.3, 96.2, 163.3-д заасны дагуу давж заалдах гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ гэснийг тус зөрчиж, албаны үүрэгтэй хайнга хандсан болох нь хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдсон.

Асуулт: Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан уу? Хэлэлцэнэ үү.

Тохиолдол 11: Шүүгч Д нь А банкнаас зээл хүсэж хандахад анкетаас нь шүүгч гэдгийг нь мэдээд Та шүүгч юм чинь бусдад тавьдаг нийтлэг шаардлагаа багасгалаа гэсэн /барьцаа хөрөнгө шаардахаа больсон/. Шүүгч эдийн засагчид хандан үгүй ээ бусдын адил л байя, материалаа бүрдүүлж өгье гэхэд шаардлагагүй гээд зээлийг олгосон. Шүүгч зээлээ барьцаагүйгээр авч хэрэглэсэн

Асуулт: Шүүгчийн нэр хүндийг урвуулан ашигласан уу? Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх үүрэг зөрчигдсөн үү? Хэлэлцэнэ үү.

Тохиолдол 12: Шүүгч багшлах, эрдэм шинжилгээний ажил хийх хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд энэ төрлийн ажил үүрэг эрхэлж болох боловч эдгээр ажил нь албан үүрэгт нь харшлах, эдгээр ажлын хэт ачааллын улмаас хэрэг маргаанаа хугацаанд нь шийдвэрлэж чадахгүйд хүрэх зэрэг нь хичээл зүтгэл гаргах албан үүргээ чухалчлах үүргийн зөрчилд тооцогдох уу?

Асуулт: Мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх үүрэг зөрчигдсөн үү? Хэлэлцэнэ үү.

Тохиолдол 13: Шүүгч Э нь ... аймаг дахь банкинд холбогдох хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх явцад түүний нөхөр хугацаа хэтэрсэн /2010-2014 онд/ зээлийн үлдэгдэл болох нийт 56,000,000 төгрөгийг төлсөн нь нотлох баримтаар нотлогдсон. Шүүгч Э нь 2014 оны хөрөнгө орлогын их хэмжээний өөрчлөлтөд өөрийн нөхрийн 56,000,000 төгрөгийн зээл төлөлтийн талаар бүртгүүлээгүй байх бөгөөд ийнхүү бүртгүүлээгүй гэдгээ тайлбартаа хүлээн зөвшөөрсөн.

Асуулт: Шүүгч ёс зүйн ямар зармуудыг зөрчсөн бэ? Хэлэлцэнэ үү.

2.8. Шүүгчийн үйл ажиллагааг гаднын нөлөөнөөс хамгаалах

Шүүгчийн үйл ажиллагааг гаднын нөлөөнөөс хамгаалах асуудал Шүүгчийн хараат бус зарчимтай холбоотойгоор гарч ирдэг ойлголт өөрөөр хэлбэл, шүүгчийн хараат бус зарчимд хамаарна⁸.

Шүүгчийн үйл ажиллагаа буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх гаднын нөлөө гэдэгт нэг талаас шүүгчийг томилдог этгээд, гэр бүл, найз нөхөд, хамт олон, танил тал, ерөнхий шүүгч, бусад шүүгч, хэргийн

оролцогч, бусад төрийн бол төрийн бус байгууллага, албан тушаалтан зэрэг хөндлөнгийн этгээдээс аливаа хэлбэрээр шүүгчид гаднаас нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүй хамаарна. Энэ үйлдлийг шүүгчийн хараат бус байдалд зүй бусаар халдах оролдлого гэж хэлж болно.

Нөгөө талаас нийгэм, эдийн засаг, улс төр, санхүү, төсөв, гэр бүл, танил тал, бусад ерөнхий шүүгч, шүүгч зэрэг бусад этгээдийн аливаа нөлөөлөлд шүүгч өөрөө автахгүй байх, хараат бус байх шүүгчийн үүрэгтэй холбоотойгоор гаднын нөлөө уялдаж гарч ирдэг.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм⁹-д шүүгч өөрөө нийгэм, эдийн засаг, улс төр, санхүү, төсөв, гэр бүл, танил тал, ерөнхий шүүгч, бусад шүүгч зэрэг ашиг сонирхлын нөлөөнд автахгүй байх үүргийг 7 заалтаар тодорхойлон заажээ. Харин Шүүгчдийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүгчид гаднаас нөлөөлөхийг бусад этгээдэд хориглож, үүрэгжүүлсэн болон шүүгч өөрөө гаднын нөлөөнд автахгүй байхыг шүүгчид өөрт үүрэгжүүлсэн заалтыг оруулжээ.

Нөлөөллийн мэдүүлгийн зорилго нь гаднын нөлөөнөөс шүүгчийг хамгаалах арга хэрэгсэл юм. Нөлөөллийн мэдүүлгээр шүүгчид нөлөөлөх гэж оролддог этгээдүүдэд хариуцлага тооцох байдлаар дамжуулан шүүгчид гаднын нөлөөллийг багасгах, шүүгчийг хүндэтгэх, шүүгчийг үйл ажиллагаагаа хэвийн явуулахад чухал нөлөө үзүүлнэ.

Дээрх эх сурвалжаас үзэхэд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд шүүгч өөрөө нөлөөнд автахгүй байх үүргийг нэлээд өргөн утгаар нь оруулсан байхад эдгээр үүргээс зарим заалтыг Шүүгчийн ёс зүйн дүрэмд оруулсан байна. Доорх хүснэгтээс шүүгчид гаднаас нөлөөлөх болон шүүгч өөрөө гаднын нөлөөнд автахгүй байх үүргийг хэрхэн зохицуулсныг харж болно.

1. Шүүгчид гаднаас /хөндлөнгийн этгээд/ нөлөөлөхийг хориглосон хэм хэмжээний талаар:

1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль		Агуулга
1.	21 дүгээр зүйл. Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох	21.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

<p>2.</p>	<p>22 дугаар зүйл.Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх</p>	<p>22.1.Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээр хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүн нөлөөллийн мэдүүлгийг хөтөлнө.</p> <p>22.2.Энэ хуулийн 22.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.</p> <p>22.3.Шүүгч нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар хэрэг үүсгэсэн даруйд тухайн хэргийн оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.</p> <p>22.4.Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгч нөлөөллийн мэдүүлгийг хэргийн материалд хавсарган, хувийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.</p> <p>22.5.Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 22.3-т заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан тухайн этгээдийн үйлдэл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.</p> <p>22.6.Нөлөөллийн мэдүүлгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн саналтай эрх бүхий байгууллага, албан тушаалтан заавал танилцах бөгөөд уг саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хариуг Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлнэ.</p> <p>22.7.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 22.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн санал хүсэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авч, Шүүхийн ерөнхий зөвлөлд хариу мэдэгдэнэ.</p> <p>22.8.Шүүхийн ерөнхий зөвлөл нь эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хариуг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүрд нь мэдээлнэ.</p>
<p>3.</p>	<p>27 дугаар зүйл.Шүүгчид хориглох зүйл</p>	<p>27.1.Шүүгчид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтаас гадна дараах зүйлийг хориглоно:</p> <p>27.1.6.шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хуульд зааснаас бусад хэлбэрээр оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;</p> <p>27.1.18.шүүгч нь хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг</p>

	хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоох;
2.Шүүхийн тухай хууль	Агуулга
27 дугаар зүйл. Шүүхийн улс төр, хууль зүйн баталгаа	27.1.Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно.
3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Агуулга
12 дугаар зүйл.Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох	12.1.Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

2.Шүүгч өөрөө гаднын нөлөөнд автахгүй байх

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм	Шүүгчийн ёс зүйн дүрэм
15.6 дугаар зүйл. Шүүгчийн үйл ажиллагааг гаднын нөлөөнөөс хамгаалах 1.Шүүгч нийгэм, улс төр, эдийн засагт үүссэн нөхцөл байдал эсхүл олон нийтийн дургүйцэл, шүүмжлэлд автаж хэрэг, маргааныг шийдвэрлэж болохгүй.	-
2.Шүүгч нь үйл ажиллагаа явуулахдаа гэр бүл, нийгэм, улс төр, санхүүгийн зэрэг ашиг сонирхлын аливаа нөлөөлөлд автаж болохгүй.	-
3.Шүүгч аливаа этгээд өөрт нь нөлөөлөх байр суурьтай гэсэн ойлголт төрүүлэх, эсхүл бусад этгээдийн зүгээс тийм ойлголт төрүүлсэн талаар мэдсэн бол залруулах арга хэмжээ авна.	-
4.Шүүгч нь бусад шүүгчид хэрэг, маргаан шийдвэрлэхтэй холбоотой заавар, чиглэл өгч болохгүй.	3.1 дүгээр зүйл. Бие даасан, хараат бус байдлыг хадгалах 3.1.3.Шүүгч нь бусад шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

<p>5.Шүүгч хэрэг, маргаан шийдвэрлэхдээ дээд шатны эсхүл бусад шүүх, шүүгчээс заавар, чиглэл авах, эсхүл тийм заавар, чиглэлд захирагдаж болохгүй</p>	-
<p>6.Шүүгч нь тухайн хэрэг, маргааныг хараат бусаар шийдвэрлэх үүргээ зөрчихгүйгээр бусад шүүгчтэй санал солилцож болно. Энэ заалтын бусад шүүгч гэдэгт тухайн шүүгчийн шийдвэрийг давж заалдах эсхүл хяналтын журмаар хянан шийдвэрлэх шүүгч хамаарахгүй.</p>	<p>3.1.5.Шүүгч нь хэргийг хараат бусаар хянан шийдвэрлэх үүргээ зөрчихгүйгээр бусадтай хууль хэрэглээний талаар санал солилцож болно.</p>
<p>7.Тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхтэй нь холбогдуулан биечлэн уулзах, утсаар ярих, биет болон цахим шуудан явуулах зэргээр шүүгчид хөндлөнгөөс нөлөөлсөн эсхүл нөлөөлөхөөр завдсан этгээдийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.</p>	<p>3.2 дугаар зүйл. Хэргийн оролцогчтой харилцах 3.2.4.Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдалд, гэм буруугийн талаар ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана.</p>
<p>Бангалорын зарчим Үнэт зүйл 1: Хараат бус байдал</p>	-
<p>1.1.Шүүгч нь албан үүргээ хараат бусаар, үйл баримтын талаар өөрийн үнэлэлт дүгнэлтэд тулгуурлан, хуулийг ухамсартайгаар ойлгож, хэргийн оролцогч, маргааны талуудын шууд ба шууд бус аливаа нөлөө, зүй бус урамшуулал, дарамт шахалт, заналхийлэл, саадгүйгээр хэрэгжүүлнэ.</p>	-
<p>1.2.Шүүгч нь иргэд, олон нийт болон хянан шийдвэрлэх гэж буй маргааны талуудаас хараат бус байна.</p>	-
<p>1.3.Шүүгч нь төрийн гүйцэтгэх болон хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн зүй бус харилцаа холбоо нөлөөнөөс ангид байх төдийгүй тэднээс үл хамаарах хөндлөнгийн байр суурьтай байна.</p>	-
<p>1.4.Шүүгч албан үүргээ гүйцэтгэж, шийдвэр гаргахдаа бусад шүүгч, шүүхийн ажилтнуудаас хараат бус байна.</p>	-

1.5.Шүүгч шүүхийн байгууллагын болон үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах, түүхийг бэхжүүлэхийн тулд шүүгчийн албан үүргээ хэрэгжүүлэх ажиллагааг хамгаалж, дэмжлэг үзүүлнэ.	-
---	---

Тохиолдол 14: 3 настай охин Б-ийн амь насыг бүрэлгэсэн үйлдэлд түүний төрсөн эцэг Ц, хойд ээж Д нарыг буруутгажээ. Уг хэргийн улмаас олон нийтийн зүгээс хүүхдийн хүчирхийллийн эсрэг цуглаан зохион байгуулж, олон нийтийн дургүйцэл, шүүмжлэл нэлээд гарч, шүүх дээр уг хэргийг хянан шийдвэрлэх үйл явцыг нээлттэй явуулахыг шаардаж, хүүхдийн амь нас хөнөөсөн этгээдүүдийг олон нийтэд жигшүүлэх арга хэмжээ авах, ялын дээд хэмжээ өгөхийг шүүхээс шаардсан мэдэгдэл хүргүүлж, шүүх иргэдийн итгэлийг хамгаалж чадаж байгааг харуулах асуудал гэж шаардлагадаа дурджээ. Энэ тохиолдолд шүүгчээс хүүхдийн хүчирхийллийн эсрэг хувь нэмэр оруулах зорилгоор хурлыг нээлттэй явуулах шийдвэр гаргаж, шүүх хуралдааны үед шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалж байгаа, шүүгдэгч нар хүүхдийн хүчирхийлэл үйлдэгч нар тул дээд хэмжээний ял оноох нь зүйтэй гэсэн үндэслэл хэлжээ.

Асуулт: Шүүгчийг гаднын нөлөөнд автсан гэж үзэх үү?, энэ үйлдэлд шүүгчид ёс зүйн зөрчил оногдуулах уу?

Тохиолдол 15: Улсын дээд шүүх /УДШ/-ийн танхимын тэргүүн шүүгч Ю-д анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн оролцогч Т-ээс анхан шатны шүүхийн шүүгч хэргийг хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэлгүйгээр удаашруулж байна, нөгөө талын шүүх хуралдаан хойшлуулах хүсэлтийг байнга хүлээн авч хурлыг 20 удаа хойшлууллаа. Анхан шатны шүүхийн шүүгчид арга хэмжээ авч өгнө үү гэсэн гомдол гаргажээ. УДШ-ийн шүүгчээс анхан шатны шүүхийн шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулж, тус хэргийг хурдан шийдвэрлэ гэсэн агуулга бүхий бичгийг хүргүүлж, хувийг гомдол гаргасан этгээдэд хүргүүлжээ.

Асуулт: УДШ-ийн танхимын тэргүүн шүүгч анхан шатны шүүгчид нөлөөлсөн үү, түүний үйлдэл ёс зүйн зөрчил мөн?

Тохиолдол 16: Хуульчдын холбооноос зохион байгуулсан иргэний эрх зүйн хууль тогтоомжийг сайжруулах сэдэвт хэлэлцүүлэгт анхан шат, давж заалдах шат, дээд шатны шүүгч нар бүгд оролцжээ. Уг хэлэлцүүлгийн үеэр УДШ-ийн шүүгч нараас ижил төстэй хэргийг өөр өөрөөр шүүгч нар шийдвэрлэж байгааг шүүмжилж, цаашид ижил төстэй хэргийг нэг адил шийдвэрлэж байх нь зүйтэй гэсэн зөвлөмж өгчээ.

Асуулт: УДШ-ийн шүүгч нарын зөвлөмж анхан болон давж заалдах шатны шүүгч нарт нөлөөлсөн үйлдэл мөн үү?

Тохиолдол 17: УИХ-ын гишүүнээс шүүгч нар ашигт малтмалын маргаан шийдвэрлэхдээ эвлэрүүлэн шийдвэрлэдэг, олон жилийн өмнөх болсон маргааныг хөөн хэлэлцэх хугацаа сэргээх үндэслэлгүй байхад сэргээн шийдвэрлэдэг талаар олон нийтийн бүх хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлжээ.

Асуулт: УИХ-ын гишүүний үйлдэл шүүгчид нөлөөлсөн үйлдэл мөн үү?

Тохиолдол 18: Хэргийн оролцогч Г нь шүүх хуралдааны явцад шүүгч А-г чам шиг ийм шүүгч байхаар манай улс яаж хөгжих вэ дээ, боловсролгүй, шүүгч хүний шинжгүй, адгийн тэнэг амьтан гэж доромжилжээ. Шүүгч А нөлөөллийн мэдүүлэг бөглөжээ.

Асуулт: Хэргийн оролцогч Г нь шүүгч А-д нөлөөлсөн үү? Шүүгч А-гийн нөлөөллийн мэдүүлэг бөглөсөн нь хэргийн оролцогч Г-ийн үйлдлийг таслан зогсоох зөв арга хэрэгсэл мөн үү?

2.9. Нууцыг задруулахгүй байх

Хуулиар хамгаалагдсан төрийн, албаны, хувь хүний болон байгууллагын нууцыг шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон бусад шүүхийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа олж мэдсэн бол түүнийг задруулах, өөрт болон бусдад ашигтай байдал бий болгох зорилгоор ашиглах, ашиглуулах Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Шүүгчийн ёс зүйн дүрэм¹⁰-ээр хоригложээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа болон архивт хадгалагдаж байгаа хавтас хэргүүдийг шүүгч хэргийн оролцогчоос бусад этгээдэд танилцуулахыг хориглодог.

Монгол Улсын шүүхийн нууцад дараах зүйл хамаардаг¹¹:

- Зөвлөлдөх тасалгаанд шүүгчийн гаргасан санал;
- Бусад байгууллагаас ирүүлсэн нууц баримт бичиг;
- Төрийн, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр, магадлал, тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэл;
- Хэрэглэгчийн нэр, нууц үг;
- Програмын өгөгдлийн сан;
- Компьютерт боловсруулсан нууц мэдээ, мэдээлэл, баримт бичиг;
- Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад мэдсэн төрийн нууц, байгууллагын болон хувь хүний нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлс;

- Шүүгчийн мэргэшлийн үнэлгээний дүн;
- Шүүгчийн хувийн хэрэг;
- Тухайн шүүгчийн цалингийн нийт хэмжээ;
- Шүүхийн барилга байгууламжийн схем зураг.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм	Шүүгчийн ёс зүйн дүрэм
<p>1.10 дугаар зүйл. Нууц хадгалах</p> <p>1. Хуульч мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, эсхүл хувь хүний нууцыг чанд хадгална.</p>	<p>4.6 дугаар зүйл. Нууцыг задруулахгүй байх</p> <p>1. Шүүгч албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа олж мэдсэн болон өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах, эсхүл өөр зорилгоор ашиглахыг хориглоно.</p> <p>2. Шүүгч бусдын нууцыг задруулахгүй байх талаар өөрөөс шалтгаалах бүх арга хэмжээг авна.</p>

Тохиолдол 19: Шүүгч Д нь Л ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг даргад холбогдох газрын маргааныг шийдвэрлэх явцдаа Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн хотын төв хэсэгт байршилтай Л ХХК-ийн 1 га газрын эзэмших эрхийг хүчингүй болгосон шийдвэр гаргажээ. Шүүгч Д нь уг шийдвэр эцэслэн шийдвэрлэгдсэний дараа бизнес эрхэлдэг өөрийн ах М-д би саяхан таны үйлчилгээний төв барих гэж хайгаад байсан газартай адил хотын төвд байршилтай газрыг эрхийг хүчингүй болгосон. Та яаралтай газар эзэмших хүсэлтээ Нийслэлийн Засаг даргад гарга, би газартай холбоотой бүхий л мэдээллийг танд өгье гэжээ.

Асуулт: Шүүгч нууц задруулсан үйлдэл хийсэн үү, түүний үйлдэлд ёс зүйн хариуцлага хүлээлгэх үү?

Тохиолдол 20: Шүүгч М нь ажлын цагаар хэт их ачаалалтай байсан учир маргааш шийдвэрлэх хэргээ гэртээ уншихаар авч явжээ. Орой байсан тул такси барьж гэртээ хүргүүлсэн, таксид цүнхтэй хэргээ мартаад буужээ.

Асуулт: Шүүгчийн энэ үйлдлийг нууц задруулсан үндэслэлээр ёс зөрчилд тооцох уу?

Тохиолдол 21: Шүүгч Б нь өөрийн ажлын компьютерт паспорт хийгээгүй, шүүхийн ажилтан түүний компьютерээс нууцлалын зэрэглэлтэй шүүхийн шийдвэрийг авч хэргийн оролцогчид дамжуулан өгч, улмаар уг мэдээлэл нь олон нийтийн хэрэгслээр дамжуулагдсан байна.

Асуулт: Шүүгчид ёс зүй зөрчил гаргасан, түүнд хариуцлага хүлээлгэх үү?

Тохиолдол 22: Шүүгч О нь хавтаст хэрэгт байсан нууцын тэмдэг дарсан дугтуйтай нотлох баримтыг шүүх хуралдааны явцад хэргийн оролцогчдод нууц баримт гэдгийг сануулахгүйгээр танилцуулжээ.

Асуулт: Шүүгч О нууц бичиг баримтыг бусдад задруулсан зөрчил гаргасан уу?

2.10. Хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргааны талаар мэдээлэх

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.4.1-т “Шүүгч хуульд заасан журмын дагуу эцэслэн шийдвэрлэгдээгүй хэргийн талаар болон гарах шийдвэрийн тухайд саналаа урьдчилан илэрхийлэх, эсхүл хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр бусад шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны талаар эргэлзээ төрүүлэхүйц ойлголтыг олон нийтэд мэдээлэхийг хориглоно.”

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 15.11-т Шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны талаар мэдээлэх гэсэн зохицуулалт байх бөгөөд дор дурдсанаас бусад тохиолдолд шүүгч нь шүүхэд шийдвэрлэгдэх гэж байгаа эсхүл шийдвэрлэгдэх магадлалтай хэрэг, маргааны талаар олон нийтэд мэдээлэл хийхийг хориглоно:

- Хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэхэд саад болохгүй, эсхүл үр дүнд нөлөөлөхгүй хэмжээнд хичээл заах, судалгааны ажил хийх, өгүүлэл, ном бичих, илтгэл тавих зэргээр мэдээлэл хийх;
- Тодорхой хэрэг, маргаантай холбогдолгүйгээр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тайлбарлах;
- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл эсхүл бусад арга замаар өөрийнх нь үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан буруутгалд хариу өгөх;
- Өөрөө хувь хүнийхээ хувьд хэргийн оролцогчоор оролцож байгаа хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбар хийх.

Шүүгч шүүхэд хянан шийдвэрлэгдэх боломжтой хэрэг, маргаантай холбогдуулан албан үүргээ шударгаар, төвийг сахиж хэрэгжүүлэхэд харшлах аливаа амлалт өгөхийг хориглоно.

Шүүгч нь шүүхийн ажилтан эсхүл өөрийн удирдлага дахь бусад этгээд энэ зүйлийн 1-2 дахь хэсэгт хориглосон мэдээлэл, амлалт хийхээс татгалзахыг шаардана.

Шүүгч нь хэрэг, маргааны оролцогч гэдгийг мэдсээр байж түүнтэй олон нийтийн цахим сүлжээгээр харилцахыг хориглоно.

Энэ хүрээнд хэд хэдэн ёс зүйн зөрчил байж болох, ёс зүйн зөрчил хэмээн ойлгогдохуйц үйлдэл, үйл ажиллагаанууд байх боломжтой. Тухайлбал эцэслэн шийдвэрлэгдээгүй хэргийн талаар болон гарах шийдвэрийн талаар мэдээлэхтэй холбоотойгоор хянан шийдвэрлэж буй хэрэгтэй яг ижилхэн агуулгатай тохиолдлуудыг сургалт, хэлэлцүүлгийн үеэр хууль хэрэглээ, шийдлийн талаар санал бодлоо илэрхийлэх, хамтран

ажиллаж буй шүүгч болон туслахтайгаа шийдлийн талаар ярилцах зэрэг байх боломжтой. Хэргийн шийдэл болон, гэм бурууг шүүх хуралдааны үеэр шийдвэрлэх ёстой боловч ямар нэг байдлаар урьдчилсан дүгнэлт, шийдвэр, хандлагыг аливаа этгээдтэй хуваалцах, ярилцах, дурдах нь энэ төрлийн зөрчил болох магадлалтай.

Түүнчлэн эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн талаар болон шийдвэрлэсэн шүүгчийн талаар, тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар аливаа шүүмжлэл, санал дүгнэлтийг олон нийт болон хувь хүн, бусад этгээдтэй хуваалцах, ярилцах нь ч зарим тохиолдолд ёс зүйн зөрчилд тооцогдох боломжтой юм.

Тохиолдол 23: Шүүгч Нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулсан мэтээр О шүүгчийн туслах нь хариуцагчийн өмнөөс гарын үсэг зурсан, өөрийн туслахын гаргасан зөрчлийг мэдсэн атлаа холбогдох арга хэмжээг аваагүй, зохих ёсоор шийдвэрлүүлээгүй, зохигчдын эвлэрлийг батлах ажиллагаанд шүүгч өөрөө хуульд заасны дагуу зохих ёсоор хяналт тавиагүй, гомдол гаргагчийн төлбөрийн тооцоог нягталж шалгалгүй шийдвэрлэсэн.

Асуулт: Шүүгч ёс зүйн зөрчил гарсан уу?

Тохиолдол 24: Яллагдагч М нь авто тээврийн осол гаргаж, төрсөн охиноо алдсан бөгөөд өөрөө хүнд гэмтсэн байна. Түүний хэрэг прокуророос шүүхэд шилжиж Л шүүгчид хуваарилагдсан байна. Шүүгч Л нь тухайн өдөр ажил дээрээ байхгүй байсан ба түүний туслах шүүгчрүүгээ ярьж, ирсэн хэрэг болон яллагдагчийн хувийн байдлыг танилцуулсан боловч, ажил дээрээ ирээгүй. Үүний амралтын 2 өдөр өнгөрсөн ба ажлын эхний өдөр шүүгч Л ажилдаа ирээгүй байна. Яллагдагч М нь биеийн байдал тааруу, сэтгэл санааны хувьд маш хүнд байдалд байсан бөгөөд тухайн шүүхийн ерөнхий шүүгчийн туслахад хэлсний дагуу шүүгч тухайн өдрийн үдээс хойш ажил дээрээ ирсэн байна. Шүүгч Л ажил дээрээ ирсний яллагдагч М-д батлан даалтын таслах сэргийлэх арга хэмжээ авчээ. Гэвч хэдэн өдрийн дараа яллагдагч М-г цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар болсныг шүүхээс мэдэгдсэн. Ийнхүү мэдэгдэхдээ шүүхэд өдөр бүр бүртгүүлэх ёстой байсан гэж шүүгч хэлээд цагдан хорьж, захирамжид гомдол гаргах эрхгүй хэмээн бичсэн байна.

Асуулт: Шүүгч ёс зүйн зөрчил гарсан уу?

Тохиолдол 25: Шүүгч С нь өөрийн шүүхийн шүүгч Г-н шүүх хуралдааныг шүүхийн мэдээллийн хэсэгт үзэж байхдаа санаандгүй “Өө, энэ нөхрийг тэнсчихэж байгаа юм байхдаа” гэж хэлээд өрөө рүүгээ орсон байна. Энэ үед тухайн мэдээллийн төвд 2-3 иргэн байсан бөгөөд шүүгчийн хэлснийг бүгд сонссон байна.

Асуулт: Шүүгч ёс зүйн зөрчил гарсан уу?

ХЯНАЛТЫН АСУУЛТ

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бүгдийг тэвчээртэй, шударгаар сонсох үүрэг нь шүүх хэргийг цаг тухайд нь, шуурхай шийдвэрлэх үүрэгтэй зөрчилдөх ҮҮ?
- Шүүхээс өмгөөлөгч буюу өөрийгөө өмгөөлж буй хэргийн оролцогчдод, хойшлогдож болзошгүй шийдвэрийн талаар протоколоор ил тод мэдэгдэх үүрэгтэй юу?
- Шүүх хуралдааны танхим дахь хэргийн оролцогчийн үйл хөдлөл нэг шүүгчийн хувьд зохисгүй байдал гэж ойлгогдож буй ч, өөр нэг шүүгчийн хувьд зохистой гэж ойлгогдож болох уу?
- Шүүгч нь шүүх хуралдаанд оролцож буй хуульч бүдүүлэг харьцаа гаргасан ч, түүнийг нь хайхралгүйгээр шүүх хуралдааны танхимыг зохих арга хэлбэрээр зохион байгуулах үүрэгтэй юу?

ЭХ СУРВАЛЖ

1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012
2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012
3. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. 2013
4. Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм. 2014
5. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, 2013
6. Маршал Жак, Ёс зүйн соёлыг бий болгох аргачлал: хууль дүрмээс илүү ёс зүй, хариуцлагыг харгалзан үзэх нь, Хуульчийн ёс зүй гарын авлага (гарын авлага), УБ 2004, хуудас 10-22
7. Н.Лүндэндорж. “Jurisprudence-Эрх зүй судлал: Философи, онол.” 156. УБ., 2011
8. О.Мөнхсайхан. “Хуульчийн ёс зүйн сургалтын гарын авлага.” УБ., 2014
9. Л.Мөнхсайхан, Ж.Наранцацрал, М.Батсуурь. “Хуульчийн ёс зүй.” УБ., 2013.
10. Х.Тэмүүжин. Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур, үндэслэл, Хуульчийн ёс зүй (гарын авлага), УБ 2005, хуудас 6-9.
11. Моригива Ясүтомо. “Хуульчийн ёс зүй.” УБ., 2006.
12. Т.Мэндсайхан эмх. “Хуульчийн ёс зүй гарын авлага.” УБ., 2004.
13. Н.Лүндэндорж, Ч.Өнөрбаяр, М.Батсуурь. Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь. УБ: Нээлттэй нийгэм форум, 2012.
14. Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл, УБ 2004

15. Совд Г. Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (харьцуулсан эрх зүй), УБ 1999
16. О.Мөнхсайхан. “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2015) батлагдвал хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцооны үр нөлөөтэй, хараат бус, шударга байдал алдагдана.” Шүүх эрх мэдэл, дугаар 3 (2015):11-41.
17. Ц.Мандах, Э.Өлзийлхам, Ч.Бат-Уянга. “Шүүгчийн хариуцлагын тогтолцоо.” Судалгааны тайлангийн эмхэтгэл (2015) дотор. 14-70. УБ, 2016
18. Б.Ариунзаяа нар. “Шүүхийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагаа” Судалгааны тайлангийн эмхэтгэл (2015) дотор, 71-101. УБ, 2016
19. О.Мөнхсайхан, Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх. Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. УБ: Нээлттэй нийгэм форум, 2015
20. ABA, “Model Rules for Lawyer Disciplinary Enforcement,” 1989
21. ABA, “Model Rules of Professional Conduct,” 2013
22. Acquaviva Nais, Castagnet Florence and Evangelhelou Morgane, A Comparative Analysis of Disciplinary Systems for European Judges and Prosecutors, For the 7th edition of the THEMIS competition – 2012
23. American Bar Association, Model Rules on Disciplinary Enforcement adopted by the House of Representatives, 1994
24. Anja Seibert-Fohr. ed., Judicial Independence in Transition. Max Plank Institute. Heidelberg: Springer, 2012
25. Cynthia Gray. “The Line between Legal Error and Judicial Misconduct: Balancing Judicial Independence and Accountability.” Hofstra Law Review Vol. 32:1245 (2004): 1245-1280
26. Esterling K. M. “Judicial Accountability the Right Way: Official performance evaluations help the electorate as well as the bench,” in Judicature, Vol. 82, no. 5 (2006):215
27. European Network of Councils for the Judiciary (ENCJ), Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges. Report 2014-2015. Hague, 2015
28. Federation of Law Societies of Canada, “Model Code of Professional Conduct,” 2011
29. Guy Canivet. Mads Andenas and Duncan Fairgive, ed., Independence, Accountability and the Judiciary. British Institute of International Law and Comparative Law, 2006
30. Maya Goldstein Bolocan, Professional Legal Ethics: A Comparative Perspective (Central European and Eurasian Law Initiative, 2002), 11–76

31. Measures for the Effective Implementation of the Bangalore Principles of Judicial Conduct, Judicial Integrity Group, 2010
32. Rachel C. Schreck, "Lawyer Discipline: What Is Considered 'Effective Discipline?'" SSRN Scholarly Paper (Rochester, NY: Social Science Research Network, April 21, 2010), 29, <http://papers.ssrn.com/abstract=1631256>.
33. Vyas, Yash. "The Independence of the Judiciary: A Third World Perspective" Third World Legal Studies: Vol. 11, Article 6 (1992).

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ШҮҮГЧИЙН НИЙТИЙН АЛБАНД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ БА ШҮҮГЧИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

*Б.Энхтайван, Хөвсгөл аймаг дахь Захиргааны
хэргийн анхан шатны шүүхийн
Ерөнхий шүүгч*

*Б.Сугар, Өвөрхангай аймаг дахь
Захиргааны хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч*

СЭДЭВ 3. ШҮҮГЧИЙН НИЙТИЙН АЛБАНД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ БА ШҮҮГЧИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Зорилго: Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэг татгалзах үндэслэлүүд болон шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үндэслэл, журам, мөн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга замын талаар шүүгчдэд танин мэдүүлэх, мэдлэг мэдээлэл олгох, бодит тохиолдол шинжлүүлж олж авсан мэдлэгийг нь батжуулах, шүүгчийн ёс зүйн мэдлэг чадвар олгох, эзэмшүүлэх.

Нэр томьёо: Ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэг, татгалзал

Дэд сэдэв:

- *Ашиг сонирхлын зөрчил*
- *Хөрөнгө орлогын мэдүүлэг*
- *Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үндэслэл, журам*
- *Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зам*
- *Бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах*
- *Шүүгчийн үнэмлэх, тэмдэг хэрэглэх*
- *Бусдын зан байдлын талаар тодорхойлох.*

3.1. Ашиг сонирхлын зөрчил

Хүн бүрт өөрийн гэсэн хувийн амьдрал, хувийн үзэл бодол, итгэл үнэмшил, сурч боловсорсон сургууль, хамт олон, найз нөхөд, гэр бүл, хүмүүжсэн орчин нөхцөл бий. Тиймээс хүн бүрт өөрийн гэсэн хувийн сонирхол байдаг ажээ. Шүүгч та ч гэсэн бусдын л адил хүн. Та бидэнд ээж аав, ах дүүс, ангийн найз, багын андууд, нутаг усныхан, дуртай бас дургүй зүйлс байдаг.

Ажил үүргээ гүйцэтгэхдээ хувийн тэдгээр сонирхолдоо автаж албан үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл албан тушаалын эрх мэдлээ зүй бусаар хэрэгжүүлбэл шүүгчийн хувийн сонирхол, нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөхөд хүргэдэг. Харин зөрчилдсөн ашиг сонирхлыг зүй зохистой тодорхойлж, мэдээлж, үр нөлөөтэй, ил тод байдлаар зохицуулахгүй бол ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд гүйцэтгэсэн аливаа үйл ажиллагаа нь ёс зүйн алдаа, албан тушаалаа урвуулан ашигласан явдал болох боломжтой.

Ашиг сонирхлын зөрчлийг олон янзаар тодорхойлсон байдаг. Харин түгээмэл байдлаар албаны үүргээ гүйцэтгэхэд албаны болон хувийн

сонирхол зөрчилдөх буюу хувийн сонирхол нь албаны үүргээ гүйцэтгэхэд нь харшаар нөлөөлөхийг ашиг сонирхлын зөрчил гэж ойлгодог байна.

Ашиг сонирхлын зөрчлийн талаар сүүлийн жилүүдэд нийгэмд эрчимтэй хэлэлцүүлэг хийгдэж энэ талын хууль зүйн зохицуулалтууд олноор бий болжээ.

“Хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан²⁵ албаны үүргээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг ойлгоно²⁶.

“Хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ. Хувийн ашиг сонирхол /private interest/ гэдэгт ажилтанд байж болох хувийн, мэргэжлийн, бизнесийн сонирхлоос гадна түүний хувийн болон ажил төрлийн холбоотой хүмүүсийн сонирхлыг багтаан ойлгоно гэж судлаачид тэмдэглэдэг. Энд хамаатан садан, танил талыг нь хамруулж болно. Өөрөөр хэлбэл, хувийн ашиг сонирхол гэдэг нь тухайн ажилтанд ашиг хонжоо бий болгох, эсхүл хор хөнөөл учруулж болох хүмүүсийн, эсхүл бусдад ашиг хонжоотой, эсхүл давуутай байдал бий болгохыг зорьж байгаа тухайн ажилтны сонирхол юм. Ийм сонирхолд санхүүгийн бодит, эсхүл болзошгүй ашиг, алдагдал, өмч хөрөнгө, хувьцаа, төлөгдөөгүй зээл, эсхүл бэлэг сэлт, хангамж, үүний дотор ажил олгох, давхар ажил гүйцэтгэх явдал багтаж болно. Хувийн бусад сонирхол заавал хөрөнгө мөнгөтэй холбоотой бус боловч тухайн ажилтны санаа бодол, шийдвэрийг өөрчилж болох хувийн болон гэр бүлийн харилцаа, спорт, соёлын үйл ажиллагаа мөн адил хамаарч болно гэж үздэг.²⁷

“Нийтийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэсэн олон нийтийн итгэлийг хэлнэ.²⁸

“Ашиг сонирхлын зөрчил” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “**ашиг сонирхлын зөрчил**” гэж

²⁵ Шүүгч нь нийтийн албан тушаалтанд хамаарна.

²⁶ “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” Нийтийн албан тушаалтны гарын авлага.

Хоёрдугаар бүлэг. “Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?” 2014 он. УБ. 27 дахь тал.

²⁷ “Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага”. 2014 он. УБ. 20 дахь тал.

²⁸ “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” Нийтийн албан тушаалтны гарын авлага. Хоёрдугаар бүлэг. “Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?” 2014 он. УБ. 28-30 дахь тал.

нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг ойлгохоор хуульчлан заажээ.

“Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д “**ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал**” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг ойлгож байна.



Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “**ашиг хонжоо**” гэж эрх бүхий албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлэхээр байгаа нь ашиг сонирхлын зөрчлийн илрэх хэлбэрийг харуулсан хууль зүйн ойлголт юм. Харин авлига гэдгийг “итгэж олгосон эрх мэдлийг хувийн ашиг хонжоо олоход ашиглах”²⁹ гэж тодорхойлсон байна.

“Хувийн ашиг хонжоо” гэдгийг өргөн утгаар авч үздэг бөгөөд үүнд, өөрийн санхүүгийн болон нийгмийн сонирхлоос гадна, өөрийн ойр дотны гэр бүлийн гишүүд, улс төрийн нам, зарим тохиолдолд бие даасан байгууллага, эсвэл хүмүүнлэгийн байгууллагуудад ашиг хонжоо бий болгохыг хамруулж үздэг.³⁰

²⁹ Мөн тэнд.

³⁰ ⁶ “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаан дахь авлигаас урьдчилан сэргийлэх нь. Гарын авлага”. 2007 он. УБ. 5-6 дахь тал.

Дүгнэж үзвэл ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголтод төрийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх албаны чиг үүрэгтэй нь харшлахыг ойлгож байна. Иймээс ашиг сонирхлын зөрчлөөс байнга, бололцооныхоо хирээр зайлсхийж, өөрийн болон төрийн байгууллага, төрийн албан хаагч, төрийн албаны нэр хүндийг, шүүгчийн хувьд шүүх, шүүгчийн нэр хүндийг эрсдэлд оруулахгүй байх шаардлага шүүгчид тавигддаг.

3.2. Хөрөнгө орлогын мэдүүлэг

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй,

10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ гэж тус тус заажээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д Шүүгч нь авлигын эсрэг хууль болон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.1 дүгээр зүйлийн 1-д Шүүгч нь өөрийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид ХОМ гэх/-ээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв мэдүүлнэ.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 16.4 дүгээр зүйлийн 1-д Шүүгч нь өөрийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтмол, үнэн, зөв мэдүүлж, манлайлна гэж заасан байна.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмыг баталсан. Уг журмаар хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн мэдүүлэх талаар тайлбарласан байдаг. Тухайлбал уг журмын 4.4.2-т зааснаар шүүгч нь

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийнхээ “хөрөнгө, зээл” гэсэн хэсэгт “*өөрийн болон гэр бүлийн гишүүдийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлэх бөгөөд бусдаас зээлсэн бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, зээл, зээлийн хүүгийн дүн зориулалтыг бичнэ*” гэх зэргээр нарийвчилсан зохицуулалтуудыг оруулж өгсөн байдаг байна. Иймээс шүүгч бүр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журамтай уншиж танилцаж ойлгосон байх нь чухал юм.

Тохиолдол 26. Шүүгч Э гэр бүлийн гишүүнийхээ банкнаас зээлсэн их хэмжээний зээл, зээлийн хүү, зээлийн хугацаа зэргийг хөрөнгө орлогын мэдүүлэг /ХОМ/-д мэдүүлээгүй байна. Иргэн Г шүүгч Э-гийн ХОМ буруу бөглөсөн талаар Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргажээ. Гомдолдоо шүүгч Э нь ХОМ буруу мэдүүлж ёс зүйн зөрчил гаргасан, хуулийнхаа дагуу үнэн зөвөөр мэдүүлэх ёстой зээлээ мэдүүлээгүй тул шударгаар хэрэг маргаан шийддэг эсэхэд нь эргэлзэж байна. Гэр бүлийн гишүүн нь маш их өр зээлтэй мөртлөө тэрийгээ ХОМ-д мэдүүлээгүй байгаа нь ёс зүйн зөрчил үүнийг шалгаж арга хэмжээ авч өгнө үү гэжээ.

Асуулт. Шүүхийн ёс зүйн хороо гомдлыг хэрхэн шалгаж, шийдвэрлэх вэ?

Тохиолдол 26. Шүүгч А банкинд 23.5 сая төгрөгийн хадгаламжтай. Уг хадгаламжаа сүүлийн 5 жилийн хуримтлалаар бий болгосон ба үүнийгээ тухай тухайн онуудад нь ХОМ-д мэдүүлсэн. Тэрээр уг хадгаламжийнхаа мөнгөөр Ланд 105 жип машин худалдаж авсан. Иргэн Ш, М нар шүүгч А-гийн талаар гомдол гаргаж, шүүгч А нь гэнэт үнэтэй жип машинтай болсон, энэ шүүгчийг хардаж байна. Яагаад гэнэт ийм үнэтэй жип машинтай болов. ХОМ-ыг нь сайтад нийтлэгдсэнээс харахад унаа машингүй гэж мэдүүлсэн байна. Иймээс ХОМ-ыг буруу мэдүүлсэн байна, үнэтэй жип машинаа огт дурдаагүй нуусан байна. Үүнийг шалгаж шүүгчийн ёс зүйгээ зөрчсөн байгаа тул хариуцлага тооцно уу гэжээ.

Асуулт. Шүүгч А шүүгчийн ёс зүй зөрчсөн үү? ХОМ-д машинаа мэдүүлээгүй гэж үзэх үү, ХОМ буруу мэдүүлсэн гэж үзэх үү? Шүүгч А-гийн хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орсон гэж үзэх үү?

Тохиолдол 27: Шүүгч А, Б, В нарын талаар иргэн Г, Д нар гаргасан гомдолдоо “... *Сайт, сонин, ТВ-гээр мэдээ мэдээлэл их гарч байна. Бид бас тэр сайт, ТВ мэдээ, сонинуудыг судлахад А, Б, В нар нь Е банкинд 3-улаа өртэй, ялангуяа В бүр асар их өртэй атлаа бидэнд холбогдох Е банкны хэргийг шийдсэн, шийдэх шийдэхдээ бүр бидний эсрэг Е банкны талд*

шийдсэн. Ёс зүйн зөрчил гаргасан энэ 3 шүүгч Е банкны хэргийг шийдэх ёсгүй байсан гэж үзэж байна. Бид хэрэг шийдэгдсэний дараа л Е банктэй холбоотой, тус банкнаас удаа дараа их хэмжээний зээл авсан байгаа болохыг нь мэдсэн. Иймд шалгаж арга хэмжээ авч өгнө үү” гэжээ.

Асуулт: Энэ тохиолдлыг шинжилнэ үү, ёс зүйн зөрчил болох уу?

Тохиолдол 28: Шүүгч Р АНУ-д ажиллаж амьдардаг багын найзаасаа 2.000 долларын үнэтэй үзэг, зангиа, цүнх бэлгэнд авчээ. Шүүгч бэлэг авсан нь ёс зүйн зөрчил болох уу?

Асуулт: Ёс зүйн зөрчил гэж үзэх эсэх талаар шинжилнэ үү. Жич: Эрх бүхий албан тушаалтан гэж хэн бэ гэдгийг тодорхойлно уу /НАНБХАШЗАСЗУСТХ 16.4./.

Тохиолдол 29: Шүүгч М-ийн хүүгийн хурим болж хуримлагч хосод шүүгч М-ийн дотно найз нь шинэ 2 өрөө байр бэлэглэжээ. Иргэн Д үүнийг мэдээд Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргасан болно.

Асуулт. Шүүгч М ёс зүйн зөрчил гаргасан уу?

3.3. Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан

Ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан болдог түгээмэл 4 үндсэн хэлбэр байдаг гэж судлаачид, эрдэмтэд үздэг байна. Олон улсад уг 4 хэлбэрийг хамгийн түгээмэл шалтгаан гэж хүлээн зөвшөөрдөг байна. Тиймээс ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй гэж үздэг 4 үндсэн шалтгааны тухай ойлголтыг шүүгчид сайтар танин мэдсэн байх нь чухал юм. Үүнд:

1. Үндсэн ажлаас гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх,³¹

2. Албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд ер хэнд ч болов давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад ямарваа нэгэн давуу тал, ашигтай нөхцөл байдал, бэлэг сэлт, шан харамж авахгүй, хангамж эдлэхгүй байх,

³¹ Шүүгчид үндсэн ажлаас гадуур өөр ажил үүрэг эрхлэх боломжийг хуулиар хязгаарласан хэдий боловч багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэх боломж бий. Мөн Хуульчдын холбоо, түүний хороод тухайлбал Шүүгчдийн хороо, Мэргэжлийн хариуцлагын хороо, Ёс зүйн хороо, Шалгалтын хороо гм олон хороод болон Шүүгчдийн холбоонд харьяалагдаж улмаар тэдгээрт ямар нэгэн албан тушаал эрхлэх нь хэр зохимжтой вэ гэх мэт

3. Танил тал, ангийн андууд, найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс, ажиллаж байгаа болон ажиллаж байсан байгууллага, хамт олон, холбоо харилцаатай байсан, байгаа хүмүүс, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах,

4. Хууль бусаар албаны нэр барих, албан тушаалаа ашиглах боломж, таатай нөхцөл байдал бий болох зэргээр албан тушаал, шүүгчийн эрх мэдлээ ашиглах нөхцөл байдал үүсэх

Дээрх 4 нөхцөл байдал бий болоход ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлал өсч, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бодитойгоор бий болж байдаг ажээ.

Шүүгч нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй дээрх 4 тохиолдлын талаар мэддэг байх ёстой. Мөн уг 4 тохиолдлоос өөр бусад ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлыг ч гэсэн алдалгүй зөв тодорхойлж үнэлж дүгнэх чадвартай байх, ийм чадварт суралцах нь тухайн хувь шүүгчийн хуулиар хүлээсэн үүргээ бие даасан, зарчимч, төвийг сахих зарчмыг чанд баримтлан үнэнч шударгаар биелүүлж, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй хэрэгжүүлэх боломжийг олгож байдаг тул энэ талын буюу ашиг сонирхлын зөрчлийн талаар зөв цэгцтэй мэдлэг, мэдээлэл, ойлголттой байх нь аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэх, цаашлаад авлига, албан тушаалын эсрэг нөлөөлж болохуйц эрсдэлээс өөрийгөө хамгаалах зүй ёсны шаардлага болон тавигдаж байна.

Авлига гэдэг нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, нэг зүйлийн хоёр тал болох нь харагдаж байна. Ашиг сонирхлын зөрчил нь нэг талаас авлигын сүүдэр, шалтгаан болдог. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийг зарим судлаачид авлига гэж үзсэн байхад зарим судлаачдын судалгааны бүтээл, эх сурвалжид хараахан авлига биш харин авлига бий болох эрсдэл гэж үзсэн байна. Тухайлбал, Транспэрэнси Интэрнэйшнл байгууллагын тодорхойлсноор “авлига бол хувийн эрх ашгийн төлөө албаныхаа эрх мэдлийг урвуулан ашиглах”³² явдал гээд нийтийн албан тушаалтны албаны үүрэг болон хувийн сонирхол хоорондын мөргөлдөөн ч авлигад багтана гэжээ. Эндээс үүдээд авлига бол ашиг сонирхлын зөрчлийг агуулдаг гэж тодорхойлсон байна. Ашиг сонирхлын зөрчлийг авлига биш гэдэг байр суурьтай хэсэг ч ашиг сонирхлын зөрчлийг авлига болж хувирах боломжтой гэж үздэг. Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчилд орж хувьдаа буюу бусдад хувийн сонирхлоо хангахад нь

³² UNDP, Conflict of interest - Prevention, Correction, Sanction and Education. Comparative study. 2005, p.8.

нийтийн албаны эрх мэдлээ урвуулан, зүй бусаар ашигласнаар ашиг сонирхлын зөрчил нь авлига болж хувирдаг. Иймээс нийтийн албан тушаалтны хувийн сонирхол албан үүрэгтэй нь зөрчилдөхөд үүнийг зөв тодорхойлж, зөв удирдаж, үр ашигтай шийдвэрлэх ёстой. Шийдвэрлэхгүй үлдээвэл ашиг сонирхлын зөрчил нь авлига, төрийн нөөцийг урвуулан ашигласан хууль бус үйлдэл болдог байна.³³

3.4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үндэслэл, журам

Шүүгч нь хэрэг, маргааныг хувийн эсхүл аливаа бусад ашиг сонирхлын үүднээс бус, хууль болон нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхдээ хараат бус, зарчимч, шударга байж, төвийг сахих ёстой.

Шүүгч ямар нэг хувийн ашиг сонирхол эсхүл ялгаварлан гадуурхах хандлагагүйгээр хуулиар хүлээсэн шүүн таслах, хэрэг хянан шийдвэрлэх үүргээ биелүүлэх бөгөөд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх талаарх ямар нэгэн урьдчилсан хандлагаас чөлөөлөгдөж, түүнээс ямагт ангид байж шийдвэрээ гаргадаг байх үүрэг хүлээдэг.

Учир иймд шүүгчийн биелүүлэх ёстой хараат бус, зарчимч, шударга байх, төвийг сахих зарчимтай зөрчилдөх эсхүл тийнхүү ойлгогдох нөхцөл байдал бий болсон тохиолдол бүрт шүүгч тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд оролцож болохгүй.

Тухайлбал гол эх сурвалж болж буй хуулийн зохицуулалтыг жагсаавал:

Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”, 2 “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”,

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 “Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол оролцохоос татгалзах, эсхүл үе болзошгүй нөхцөл байдал үүсч болохыг шүүх ажиллагаанд оролцогчдод мэдэгдэж, тэдгээрийн татгалзан гаргах санал тавих боломжийг хангах үүрэгтэй”,

³³ “Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага”. 2017 он. УБ. 20-21 дэх тал.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйл. Татгалзан гарах үндэслэл

84.1. Дараахь үндэслэл байвал шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй:

84.1.1. урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийн оролцогч, бусад оролцогчийн хувиар оролцож байсан;

84.1.2. уг хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн гэр бүл, төрөл садан, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон;

84.1.3. хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;

84.1.4. анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх болсон;

84.1.5. ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон;

84.1.6. анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг тухайн шатны журмаар хянан шийдвэрлэхэд дахин оролцох болсон.

84.2. Энэ хуулийн 84.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч оролцож болохгүй үндэслэл

1. Шүүгч дараахь үндэслэл байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй:

1.1. оролцогчийн хувиар тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа, эсхүл оролцохоор бол;

1.2. тухайн хэргийн прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн бол;

1.3. өмнө нь тухайн хэрэгт прокурор, мөрдөгч, оролцогч, бусад оролцогч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцсон бол;

1.4. өөрөө шууд, эсхүл шууд бусаар энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн холбоотой шүүгч оролцож болохгүй.

3.Анхан шатны шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн уг хэргийг давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд орж болохгүй.

4.Шүүгч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3-т заасан үндэслэлийг мэдмэгц эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үүрэгтэй ба уг үүргээ биелүүлээгүй бол гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгоно.

10.2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл

1.Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

2.Энэ хуулийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан асуудлыг хянан шийдвэрлэсэн шүүгч анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн холбоотой шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйл.Татгалзан гарах үндэслэл

91.1.Шүүгч дараахь үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй:

91.1.1.урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн хувиар оролцсон;

91.1.2.уг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн гэр бүл, төрөл, садан бол, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон байвал;

91.1.3.хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;

91.1.4. ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол.

91.2. Энэ хуулийн 84 дүгээр зүйл, 91.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно гэж хуульд тодорхой зааж өгчээ.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 2 “*Хэргийн оролцогчийн зүгээс шүүгчийг татгалзахад хүргэх нөхцөл байдлыг өөрийн үг яриа, үйлдлээрээ бий болгохоос урьдчилан сэргийлж, зайлсхийнэ*” зэрэг болно. Гэхдээ эдгээр наад захын шаардлага стандарт болж байдаг.

Шүүгч хуулиар хүлээсэн шүүгчийн албаны чиг үүргээ бодитой, шударга, төвийг сахиж, хараат бусаар гүйцэтгэхэд нь саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана. Энэ ерөнхий зарчмаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах тохиолдлуудыг процессын хуулиудын дээрх дурьдсан зүйл заалтуудаар зохицуулж өгсөн байна. Үүнээс гадна Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах татгалзлын талаар процессын хуулиудад зааснаас илүү нарийвчлан дэлгэрүүлж зохицуулсан байдаг ба үүнийг бид бас зайлшгүй мэдэж байх ёстой юм.

Өөрөөр хэлбэл шүүгч нь тухайн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ашиг сонирхлын зөрчилтэй байдал илэрвэл хэрхэх, татгалзах эсэх талаар процессын хуулиудад ерөнхий байдлаар хуульчлан зохицуулсан байдаг бол Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд илүү нарийвчлан зохицуулсан байдаг. Тодруулбал хамгийн илэрхий татгалзлын хэлбэрүүдийг хуульд тусгасан байдаг ажээ.

Иймээс тухайн шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах бодитой нөхцөл, шүүгчийн ашиг сонирхлын зөрчилт байдал бий болсон эсэхийг шийдвэрлэх, дүгнэн шинжлэх ур чадвар, дадал зүйтэй байхын тулд гагцхүү процессын хуулиуд бус холбогдох бусад хууль эрхийн акт болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд уг харилцааг хэрхэн зохицуулсан байдаг болохыг судалж мэдсэн байх ёстой.

АНУ-ийн Виржиниа мужид Хуульчдад ёс зүйн зөвлөгөө өгдөг хороо ажилладаг байна. Шүүгчид өөрт нь тухайн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах ёстой эсэх, шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үнэхээр үүссэн эсэх, шүүгчийн ёс зүйн зөрчил болох эсэх талаар эргэлзээ төрж, өөрөө түүнийгээ шийдвэрлэж тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд энэ асуудлыг шийдвэрлэдэг дээрх хороонд хандах

боломж байдаг ажээ. Комисс нь эрдэмтэн, судлаачид, онолчид, хуульчийн ёс зүйгээр мэргэшсэн хуульчид, практикийн нарийн мэргэшсэн хуульчид буюу ёс зүйгээр мэргэшсэн шүүгч, өмгөөлөгч, профессор зэргээс бүрддэг.

3.5. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга зам

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчийн ёс зүйн сургалтыг “шүүгчийн үндсэн сургалт” байх ёстой гэж үзэж, энэхүү шүүгчийн ёс зүйн сургалтыг бүх шүүхүүдэд хүрч, шүүгч бүрт хүртээмжтэй хэлбэрээр заахаар төлөвлөн ажиллаж байна. Энэ нь шүүгчдэд ашиг сонирхлын зөрчилт нөхцөл байдал үүсэх, бий болохоос урьдчилан сэргийлэхээс урьдчилан сэргийлж байгаа нэг хэлбэр юм.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ямар арга замууд байгаа болохыг судалж үзэхэд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх доорх арга замууд байж болохоор холбогдох ном, эх сурвалж, хууль эрхийн акт, судлаачдын бүтээлүүдэд тусгагджээ:

1. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм, стандартыг тогтоож, мөрдүүлэх, хөгжүүлэх, олон улсын сайн туршлагыг нутагшуулах:

- Шүүгчийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж, эрхийн актаар тогтоосон шүүгчийн дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг олж авах, уншиж судлах, үйл ажиллагаандаа нэг мөр баримтлах, тэдгээрийг эх сурвалжийн хэмжээнд ашиглах чадвар дадал эзэмших,
- Шүүгчийн ёс зүйтэй холбоотой ойлгохгүй зүйл байвал хамт олонтойгоо ярилцах, шүүгчийн ёс зүйгээр мэргэшсэн шүүгч, судлаач, багшаас тусламж хүсэх, асууж тодруулах, тэдэнтэй ярилцах, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, холбогдох ном, сонин, сэтгүүл, судалгаа, кэйс тохиолдлуудыг уншиж судлах, танилцах, ёс зүйн хорооны болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шийдвэрийн эмхэтгэлийг судалж танин мэдэх,

2. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдвэл зохих мэдлэг мэдээлэлтэй байж хувийн зохион байгуулалттай байх, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс ямагт зайлсхийх:

- Шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүгчийн бие авч яваа байдал болон харилцаа, хандлага олон нийтийн хараа хяналт дор хэрэгждэг. Ийм орчин нөхцөлд ажиллаж амьдарч байгаа гэдгийг ямагт санаж, өөрийн

хувийн зан чанараа шүүгчийн ёс зүйд нийцүүлэх, шүүгчийн ёс зүйг чанд сахиж хувийн зан чанар болгох,

- Хэрэв хэн нэгэн таны эсрэг худал мэдээ мэдээлэл, гүтгэлэг, үндэслэлгүй үг яриа, гомдол, санал гаргавал түүнийг нь няцаахад ямагт бэлэн байхаар чиг үүргээ ил тод хэрэгжүүлэх, биеэ зөв авч явах, өөрөөсөө шалтгаалах ёс зүйн дүрэм журмыг чанд мөрдөх,

3. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрхэн тэрхүү нөхцөл байдлаас гарахаа мэддэг байх:

- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах,
- Эрх бүхий албан тушаалтанд болон хэргийн оролцогчдод энэ тухайгаа мэдэгдэх,

4. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах арга хэмжээ авах:

- Ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар өөрт ямар нэгэн эргэлзээ төрвөл уг эргэлзээг сайтар судалж, хууль тогтоомжийн хүрээнд судалгаа хийж мухарлах, шийдвэрлэх,
- Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, нөлөөллийн мэдүүлэг хөдлөх шаардлага үнэхээр бодитой бий болсон эсэхэд өөрөө өөртөө хариу өгөх, шийдвэрлэх,

5. Давхар ажил эрхлэлтийн хориг хязгаарыг мэддэг байх:

- Судалгаа шинжилгээний ажил эрхлэх болон багшлах боломж шүүгчид хуулиар олгогдсон байдаг.³⁴ Гэхдээ уг ажлыг хийхдээ зайлшгүй мэдэх ёстой субъектүүдэд мэдэгдэж, тэд зөвшөөрч байгаа эсэхийг сайтар судлах, ашиг сонирхлын зөрчил бий болж болзошгүй эсэхийг тодруулах,
- Хэрэв давхар ажил эрхлэх нь таны үндсэн ажил болох шүүн таслах ажлаа хэвийн үргэлжлүүлэхэд ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил бий болгох эсэх,

6. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй бодит тохиолдол бий болсон эсэхийг тодорхойлох, бичгээр зөвлөмж өгөх /Манай улсад одоогоор ийм зохицуулалт бий болоогүй байна болно. Өмнө нь дурдагдсан АНУ-ийн Виржиниа муж улсын жишээ гэх мэт/³⁵

³⁴ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.15 “шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах”-ыг хориглоно.

³⁵ АНУ зэрэг хөгжингүй улс орнуудад энэ тогтолцоо бий болсон байдаг. Хуульчийн ёс зүй, шүүгчийн ёс зүйгээр мэргэшсэн шүүгч, өмгөөлөгч, багш судлаач, эрдэмтдээс бүрдсэн

7. Нөлөөллийн мэдүүлэг. Шүүгчийг эрсдэлээс хамгаалах хамгийн сайн хамгаалалт гэж үздэг байна. Манай одоогоор төгс төлөвшөөгүй хууль эрх зүйн ойлголт бүрдэж практик тогтож эхэлж байна.

Албан тушаалтан, эрх мэдэл, нөлөө, хөрөнгө чинээтэй болон хэний ч зүгээс бай шүүгчид албан үүргээ гүйцэтгэхэд нь хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг эрх бүхий байгууллагад мэдэгдэх замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлдэг. Албан тушаалтан өөрийн албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээлгэхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.³⁶

3.6. Бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах

Шүүгчийн бие хамгаалах тусгай хэрэгсэл гэдэгт нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хийн шүршүүр, цахилгаан бороохойг тусгай хэрэгсэл багтана. Тусгай хэрэгслийг шүүгч биеэ хамгаалах зорилгоор ажлын болон ажлын бус цагаар байнга биедээ авч явж болно. Шүүгч амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч шүршүүрийг хэрэглэхдээ дараах зүйлийг мөрдлөг болгоно.

1. Гэнэтийн аюул занал учирсан үед шуурхай байдлыг хангах зорилгоор болон агаарын хэм -10 аас дээш зааж буй тохиолдолд бортог дотор шингэн царцаж үйлчилгээ үзүүлэх нөлөө багасаж болзошгүй тул гар цүнхэндээ бус аль болох биедээ авч явах
2. Шүршүүрийн толгой дарагдахаас сэргийлэх зорилгоор хэвтээ байдлаар халаасандаа хийж аливаа эд зүйлээс тусад нь авч явах
3. Довтлогч нүүр, нүдний хэсэг рүү чиглүүлж 1 метрээс багагүй 2 метрээс ихгүй зайд шүрших
4. Шүршсэн тохиолдолд өөрт нөлөөлөх эрсдэлтэй тул нэн даруй холдох
5. Шүршүүрийг 3 секундээс илүү хугацаагаар шүршихгүй байх
6. Шүршүүрийг битүү өрөө тасалгаа болон гадна орчинд салхины эсрэг тал руу шүршихгүй байх

Цахилгаан бороохойг хэрэглэхдээ дараах зүйлийг мөрдлөг болгоно:

комисс хараат бусаар ажиллах ба ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үндэслэл бодитой бий болсон эсэх талаар судалж эргэлзсэн шүүгчдэд бичгээр зөвлөмж өгдөг гэх мэт

³⁶ Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд таниулах ажлын гарын авлага. 53-55 дахь тал.

1. Цахилгаан бороохойг довтлогч этгээдийн биед хувцасны гадна талаас хүргэн нэг байрлалд таван секундээс илүүгүй хугацаагаар гүйдлээр цохиулж ажиллуулах бөгөөд түүгээр гуядаж, ороолгохгүй байх
2. Довтлогч этгээдийн нүүр, биеийн ил хэсэгт цахилгаан бороохойг хүргэж, гүйдлээр цохиулахгүй байх

Тусгай хэрэгсэл хэрэглэхгүй байх тохиолдол. Дараах тохиолдолд тусгай хэрэгсэл хэрэглэхгүй байх үүрэгтэй:

1. Хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд;
2. Хөгжлийн бэрхшээлтэй болон гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд;
3. Довтлогч этгээдийн үйлдэл түүний санаачилгаар зогссон үед болон тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа довтолгоо таслан зогсоогдсон тохиолдолд;

Тусгай хэрэгсэл хадгалах

Тусгай хэрэгслийг дараах нөхцөлд хадгална:

1. Биедээ авч яваагүй үед нарны гэрлээс хол, цоожтой шүүгээнд байлгах;
2. Хоол хүнс болон галд амархан авалцах, шатаж, тэсрэх эд зүйлээс тусд нь байлгах;
3. Хүүхдээс хол байлгах.

Шүүгч тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад дамжуулах, хэрэглүүлэхгүй байх үүрэгтэй. Шүүгч тусгай хэрэгсэл хэрэглэснээс довтлогч этгээдийн бие болон эрүүл мэндэд хохирол учруулсан бол харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж болно.

№	Зүйл заалт	Утга
1	Шүүгчийн ёс зүйн дүрэм 4.7 дугаар зүйл	Шүүгч амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалах зорилгоор олгосон бие хамгаалах тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах зэргээр тогтоосон журмыг зөрчихгүй байх үүрэгтэй.
2	Шүүгчийн бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх, хадгалах заавар 2.1 дүгээр зүйл	Тусгай хэрэгслийг шүүгч бие хамгаалах зорилгоор ажлын болон ажлын бус цагаар биедээ авч явж болно

Тохиолдол 30: Шүүгч Н ээлжийн амралтаараа амралтад амарч байхад нь өмнө нь шийтгүүлж байсан С түүнтэй тааралдаж, “Шүүгч таны ач буянаар наранд 5 жил амьдарлаа” гэх мэтчилэн үгээр дайрахад нь шүүгч биедээ авч явсан нулимс асгаруулагчаар шүршсэн байна.

Асуулт: Шүүгч Н биеэ халдлагаа хамгаалсан үйлдэл нь тогтоосон журмыг зөрчсөн үү?

Тохиолдол 31: Шүүгчийн өрөөнд хариуцагч С орж ирэн танил талдаа үйлчилж шийдвэр гаргалаа таныг ална гэж заналхийлэн дайрахад нь цахилгаан бороохой хэрэглэж хөл, гарыг нь гүйдлээр цохиулж өөрийгөө хамгаалжээ. Хариуцагч С нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байсан ажээ.

Асуулт: Шүүгчийн үйлдэлд дүгнэлт хийх

3.7. Шүүгчийн үнэмлэх, тэмдэг хэрэглэх

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.8 дугаар зүйлд шүүгч албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоос бусад тохиолдолд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглан өөртөө давуу байдал бий болгох, бусдад ашиглуулах, албан үүрэгтэй холбоогүй иргэний үүрэг, хувийн шинж чанартай хэрэгцээнд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглах, барьцаа болгон үлдээхийг хориглосон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны Шүүгчид үнэмлэх олгох, хэрэглэх, хүчингүйд тооцох тухай журам Шүүгч нь албан үүргээ гүйцэтгэж явахдаа шүүгчийн үнэмлэхээ биедээ байнга авч явна. Үнэмлэхийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж цэвэр нямбай гэмтээхгүй хэрэглэж хадгалах үүргийг хүлээнэ. Шүүгч нь шүүн таслах ажиллагааг явуулахтай холбоотой болон хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор албан тушаалтантай харилцахдаа үнэмлэхээ үзүүлж өөрийгөө танилцуулна.

Хүчингүйд тооцож олгох журам:

- Гэмтсэн үнэмлэх

Шинээр үнэмлэх хийлгэхтэй холбоотой зардлыг нөхөн төлсөн баримтыг хавсаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүсэлтийн хамт хүргүүлнэ. Гэмтээсэн, үрэгдүүлсэн, нөхөн олгосон тухай баримтыг шүүгчийн хувийн хэрэгт хадгална. Үнэмлэхийг нөхөн олгосон тохиолдолд гарсан зардлыг 3 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дансанд шүүгч тушаана.

Хориглох зүйл:

1. Албан байгууллагын харуул, жижүүрт үлдээх
2. Барьцаанд тавих, үлдээх

3. Албаны бус үйл ажиллагаа болон хувийн ашиг сонирхлоор хэрэгжүүлэх зорилгоор ашиглах
4. Бусдад шилжүүлэх
5. Хуурамчаар дуурайлган үйлдэх
6. Хэлбэр загварыг өөрчлөх
7. Засварлах

Тохиолдол 32: Шүүгч Н хот хоорондын зорчигч тээврийн газарт Ө аймаг явахаар бүртгүүлэхээр очтол иргэний үнэмлэхээ гэртээ орхисон тул шүүгчийн үнэмлэхээ үзүүлж оочир дараалалгүй үйлчилгээ үзүүлэхийг шаарджээ.

Асуулт: Шүүгч Н-ийн үйлдэл ёс зүйн зөрчил мөн үү?

Тохиолдол 33: Шүүгч Х нь шүүхийн үзлэг хийхээр замын хөдөлгөөнд оролцож, машин барьж явахдаа, замын цагдаа бичиг баримтыг нь шаардахад шүүгчийн үнэмлэхээ, жолооны үнэмлэхийн хамт үзүүлсэн байна.

Асуулт: Шүүгч Х ёс зүйн дүрэмд заасан заалтыг зөрчсөн үү?

3.8. Бусдын зан байдлын талаар тодорхойлох

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.3 дугаар зүйл “Бусдын зан байдлын талаар тодорхойлох”. Мөн зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь шүүхэд гэрчээр дуудагдсан, Хуульчдын холбооноос даалгасны дагуу хуульчийн талаар, эсхүл өөрийн удирдлага дахь ажилтны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд бусад хүний зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар тодорхойлохыг хориглоно” гэж заасан байдаг.

Тохиолдол 34: Шүүгч Б-гээс шүүгчид нэр дэвшигч Х, ерөнхий шүүгчид нэр дэвшигч А нарын талаар зан байдал, ёс зүй, ур чадварын талаар тодорхойлолт хийж өгөхийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн мэргэжлийн хорооноос тус тус хүчээ. Шүүгч Б хүссэн тодорхойлолтыг нь гаргаж өгсөн ба Х, А нар шүүгч Б-г шүүгчийн ёс зүйг зөрчсөн. Учир нь ямар тохиолдолд шүүгч тодорхойлолт хийж өгч болохыг заасан хориг хязгаарыг давсан, зөрчсөн гэж гомдол гаргажээ.

Асуулт: Шүүгч Б ёс зүйн зөрчил гаргасан уу?

Тохиолдол 35: Иргэн С нь ХХК-ийн захирал ба шүүх хуралдаанд гэрчээр оролцсон. Иргэн С-ын талаар шүүх хуралдаан даргалагч Р-с тодорхойлолт авахаар мэдэгдэх хуудас шүүхээс ирүүлжээ. Шүүгч Р тодорхойлолт өгч иргэн С-ын зан байдлын талаар тайлбар өгчээ.

Асуулт: Шүүгч Р шүүгчийн ёс зүй зөрчсөн үү?

Тохиолдол 36: Иргэн А нь шүүгч Л-д холбогдуулан Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргажээ. Шүүгч Л нь гомдолтой танилцаад Шүүхийн ёс зүйн хороонд гаргасан тайлбартаа "... иргэн А-гийн нэхэмжлэлийн шаардлага болон хүсэлтийг нь хангаж шийдвэрлээгүй нь төлөө надад холбогдуулан ёс зүйн зөрчил гаргасан гэж гомдол гаргажээ. Иргэн А нь өөрөө их танхай балмад зан авиртай, шүүхийг илтэд үл хүндэтгэдэг ба олонд нэртэй их заргач хүн байгаа юм. Хүн болгонтой л хэрүүл зарга хийж явдаг муу энергитэй хүн шүү дээ. Идсэн эрүү хувхайрч Идүүлсэн бут ургана гэгчийн үлгэр болох байх. Жингийн цуваа явж л байдаг Жингэр нохой ... гэж үг бий шүү. Иймд А-гийн гомдлыг хэрэгсэхгүй болгох нь зүйд нийцнэ..." гэжээ.

Асуулт: Шүүгч Л нь иргэн А-гийн нэр төр, зан байдлын талаар тодорхойлж тайлбартаа бичсэн нь шүүгчийн ёс зүйн зөрчилд хамаарах уу?

Тохиолдол 37: Шүүгч олон жил хөрш амьдарсан хүн хэргийн оролцогч болохыг мэдэв. Хөршийнхөө нэрийг мэддэг, таарах болгондоо байнга мэндэлдэг. Хөрш нь мөн өөрийг нь хэн болох юу хийдэг болохыг нь мэддэг. Жилдээ ганц 2 удаа нэгнийхээрээ орж шатар тавьдаг. Үүнийг нь хэргийн 1 оролцогч мэддэг тул үүнээс улбаалж хэргийн бусад оролцогчид мэдсэн. Шүүгч өөрөө татгалзахгүй би хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэдэг.

Асуулт: Хэргийн оролцогчид шүүгчээс татгалзах уу?

Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил, татгалзал нь нарийн түвэгтэй ойлголт болохыг энэ жишээ, тохиолдлоос харж болно.

Онолын хувьд татгалзал нь нэгдүгээрт заавал татгалзах нөхцөл, хоёрдугаарт тодорхой байх гэсэн шаардлагыг тайлбаргүй хангасан байх ёстой гэж үздэг байна.

Татгалзах нөхцөлийг ерөнхий татгалзах нөхцөл болон бусад гэж хуваан авч үздэг.

Ерөнхий нөхцөлийг хуульд заасан энгийн буюу наад захын шаардлага байдаг бол бусад нөхцөл нь илүү нарийвчилсан зохицуулалт шаарддаг.

Татгалзал тодорхой байх гэдэгт татгалзал хэргийн оролцогч талуудад тодорхой ойлгомжтой байх ёстой тухай ойлголт хамаарна. Тухайлбал шүүгч өөрөө татгалзаж болзошгүй нөхцөл байдал байгаа болохыг хэргийн оролцогч талуудад мэдэгдэх, татгалзах боломж олгох, татгалзах үндэслэлээ хэргийн оролцогч талуудад мэдэгдэх, тэдэнд энэ талаар тайлбар өгөх, авах боломжоор хангах г.м.

Манай улсын тухайд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 49-52, Иргэний хэрэг шүүхэд хянан

шийдвэрлэх тухай хуулийн 91-93, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53¹, 64-66 дугаар зүйлүүдэд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах, татгалзан гаргах, тэдгээрийн үндэслэл, татгалзлыг шийдвэрлэх арга замыг хуульчлан зохицуулсан. Эдгээр хуулийн зохицуулалт нь шүүгчдийн өдөр тутам хэрэглэдэг хууль хэрэглээний асуудал юм.

Шүүгч хуулиа барьж татгалзлын асуудлыг шийдвэрлэнэ. Хуульчийн мэргэжлийн дүрэмд ингэж заасан гэж татгалзлын асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байж болох хэдий ч цаашдын хандлага, эрх зүйн хөгжил, судалгаанаас харахад илүү нарийн зохицуулалт руу явж байгаа хандлага ажиглагдаж байна.

Тодруулж хэлбэл шүүхийн тухай багц хууль батлагдсан, Монголын Хуульчдын Холбоо байгуулагдаж Хуульчийн мэргэжлийн дүрэм гарсан, тэдгээрийн зохицуулалт зэргээс харахад зохицуулалт нь илүү нарийн түвэгтэй болж шүүгчээс ёс зүйн болон мэргэшлийн маш өндөр түвшний ур чадвар шаардах болсон.

Тухайлбал: Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх нь Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг зарчим төдийгүй мэргэжлийн шаардлага хангасан байх, хичээл зүтгэл гаргах нь хувь хуульч ялангуяа шүүгчийн хүлээх үүрэг болохыг Хуульчийн мэргэжлийн дүрэм тодорхой зааж өгсөн.

Монголын хуульчдын холбооны анхдугаар Их хурлаас 2013 онд баталсан Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм батлагдсан цаг үеэс буюу сүүлийн жилүүдэд л яригдаж, хэлэлцэгдэж бий болсон зохицуулалтууд гэдгээс ямар хурдацтай хууль зүйн зохицуулалт, эрх зүй хөгжиж байгаа нь харагдана.

Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил маш өргөн хүрээг хамарч байдаг нарийн түвэгтэй асуудал тул татгалзал тэр хэрээрээ мөн ярвигтай байдаг болохыг бид Виржиниа мужийн жишээнээс мэдэх болсон.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах тухайд доорх 3 нөхцөл зайлшгүй дурьдагдана. Үүнд:

Хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах ерөнхий нөхцөл.

Шүүгч хуулиар хүлээсэн шүүгчийн үүргээ бодитой, шударга, төвийг сахиж гүйцэтгэхэд нь саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана.

Шүүгч дараах нөхцөл үүссэн тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

- (1) Шүүгч өөрөө эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээд тухайн маргаантай асуудалд эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг талтай хувийн ашиг сонирхлоор холбоотой гэдгийг мэдэж байгаа;
- (2) Тухайн хянан шийдвэрлэх ажиллагааны асуудлын талаар тодорхой үр дүнд хүрнэ, шийдвэр гаргана гэж олон нийтэд мэдээлсэн эсхүл олон нийтэд тийм ойлголт төрүүлсэн.

Хянан шийдвэрлэх ажиллагааны оролцооноос шалтгаалж татгалзах.

Шүүгч нь өөрөө эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нь дараах этгээдийн аль нэг гэдгийг мэдсэн бол тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

- (1) Хэрэг, маргааны оролцогч, эсхүл түүний шууд удирдах албан тушаалтан;
- (2) Хуульчаар оролцож байгаа;
- (3) Гэрчээр оролцох.

Урьд нь гүйцэтгэж байсан үүргээс хамаарч татгалзах.

Шүүгч урьд нь тухайн хэрэг, маргаантай холбогдуулан дараах үүргийн аль нэгийг гүйцэтгэж байсан бол хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

(1) хуульчаар оролцож байсан, эсхүл нэг өмгөөллийн нөхөрлөлд ажиллаж байсан бусад хуульч нь тухайн асуудалд голлох үүрэгтэй оролцсон;

(2) хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн албан хаагчийн хувиар оролцсон эсхүл тухайн асуудлын талаар төрийн албан хаагчийн хувьд байр сууриа олон нийтэд илэрхийлж байсан;

(3) гэрчийн мэдүүлэг өгч байсан;

(4) хянан шийдвэрлэхэд шүүгчээр оролцож байсан. Энэ тохиолдол маргаан дагуулах нь бий. Хуульчийн мэргэжлийн дүрмийн 16.3-ын 1.4 дэх заалтыг харна уу. Дээд шатны шүүх хянаад шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж байгаа тохиолдолд анх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан шүүгч нь тухайн хэргийг дахин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломж процессын хуулиар

байдаг. Харин Хуульчийн мэргэжлийн дүрэм ийм боломжгүй мэт. Мэдээж хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг баримтлах нь зүйн хэрэг.

Гэхдээ өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.26.1.1-д Хуульчийн мэргэжлийн дүрэмд захирагдах нь хуульчийн үүрэг, Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчих, зөрчихөөр завдах, мэдсээр байж бусдыг тийм үйлдэл хийхэд туслах, хатгахыг мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсгээр шууд хуульчлан хориглосон ба Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн бол 29 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээнэ. *ИХЭЗБТХ 29.1.3 - 4 & Шүүгч нь ШЭЗБТХ-ийн 4.1.4-т заасны дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байх ёстой!*

Шүүгч ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал бий болсон ч түүнийг үл хайхран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь тухайн шүүгчийг ёс зүйн хувьд зөрчил гаргасан гэж үзэхэд хүргэдэг тул үүнд шүүгчид их сэрэмжтэй, болгоомжтой хандах ёстой болдог.

Тохиолдол 38: Шүүгч Э-гийн эхнэр нь “ТТТ” ХХК-д урьд нь ажиллаж байжээ. “ТТТ” ХХК хэргийн оролцогч тул шүүгч Э тус ХХК-тай холбогдох маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд татгалзах уу?

Тохиолдол 39: “Ш” ХК 100.000.000 хувьцаатай, шүүгч Д нь “Ш” ХК-ийн хувьцааны 0.021 хувийг эзэмшдэг. Шүүгч Д нь “Ш” ХК гуравдагч этгээдээр оролцож байгаа хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болох уу?

Тохиолдол 40: АНУ-ын жишээ: Волл Стрийт компанийн 13 ширхэг хувьцааг эзэмшдэг шүүгч тус компанийн оролцсон хэргийг шийдвэрлэсэн. Энэ нь ёс зүйн зөрчилд хамаарах уу?

Асуулт. Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэх үү?

Тохиолдол 41: Шүүгч дахин хэлэлцүүлэхээр ирсэн хэрэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байтал хэргийн оролцогч шүүгчээс татгалзсан /мөн өөр хэрэгт шүүгч өөрөө татгалзсан/ ба үндэслэлээ өмнө нь буруу шийдсэн, шударгаар шийдэхэд эргэлзэж байна гэсэн. Хэрхэн шийдвэрлэх вэ?

Тохиолдол 42: Шүүгч А “М” намын нэхэмжлэлтэй хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа ба шүүгч А-гийн эхнэр “М” намын Е.Н.Б.д ажилтай. Энэ тохиолдлыг шинжилнэ үү?

Асуулт. Татгалзал яригдах уу? Шүүгчийн ёс зүйн зөрчил яригдах уу?

Тохиолдол 43: Гомдол гаргагчаас “Нэхэмжлэгч миний нэр бүхий иргэдээс их хэмжээний мөнгө төгрөг гаргуулахаар шүүхэд хандсан бөгөөд шүүгч Г нь иргэний хэрэг үүсгэн явуулсан ажиллагаанаас харахад нэхэмжлэлийн хувийг надад гардуулаагүй, миний дансны хуулгыг хэрхэн яаж гаргуулан нотлох баримт бүрдүүлсэн талаар нягтлалгүйгээр хэрэг үүсгэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан, 1 иргэний хэргийг хянаж байгаа мөртлөө түүний ахынхан гаргасан нэхэмжлэлтэй хэргийг давхар хянаж байгаа гэсэн үндэслэлээр шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан.

Мөн Санхүүгийн шинжээч томилуулж иргэний хэргийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан. Үүнийг шүүгч Г хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн. Уг захирамждаа хүсэлтэд огт дурдагдаагүй зүйлийг тусгасан ба захирамжид гомдол гаргах эрх олгоогүй, захирамж гарснаас хойш 10 хоногийн хугацаа өнгөрсний дараа захирамжийг надад гардуулсан.

Энэ бүх үндэслэлийг дурдсаар байтал Ерөнхий шүүгч миний шүүгч Г-гээс татгалзах хүсэлтэд татгалзан гаргах үндэслэл тогтоогдохгүй байна гэсэн хариу өгсөн.

Үүнээс хойш их удалгүй шүүгч Г нь намайг өөрийнхөө нэхэмжлэлтэй хэргийг шударгаар шийдвэрлэж чадахгүй гэж үзэж байгаа учраас гээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзсан.

Тэгтэл Ерөнхий шүүгч Г-гийн хүсэлтийг хангаж захирамж гаргасан. Шүүгч нарын үйлдэлд гомдолтой байгаа учир дээрх шүүгч нарт арга хэмжээ авч өгнө үү” гэжээ.

Асуулт: Шүүхийн ёс зүйн хороо Ерөнхий шүүгч болон шүүгч Г нарт сахилгын хэрэг үүсгэх үү?

Тохиолдол 44³⁷: Шүүхийн ёс зүйн хороонд хандаж иргэн М гаргасан гомдолдоо иргэн Б шүүгч В-гийн ажлын өрөөнд гартаа юм барьж орсон атлаа тэр зүйлээ орхиод гарсан. Өөрөөр хэлбэл тэрийг шүүгчид өгсөн, камерийн бичлэг (CD) болон түүнийг буулгасан зургаар энэ нь нотлогдоно гээд иргэн Б бол шүүгч В-гийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа /байсан/ хэргийн оролцогчийн хамаарал бүхий этгээд байгаа юм гэжээ.

³⁷ Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (2013-2016). УБ 2017 он. Монгол Улсын шүүхийн ёс зүйн хороо. 136-149 дэх тал.

Асуулт: Ёс зүйн зөрчил мөн эсэх, мөн бол яагаад, биш бол яагаад?, хэрэв ёс зүйн зөрчил мөн гэж үзэж байгаа бол хэрхэн шийдвэрлэх вэ?

Тохиолдол 45: Шүүгч Б-гийн эхнэрийнх нь төрсөн ах нь гуравдагч этгээд байсан. Шүүгч Б өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй, хуулиар ийм үүрэг шүүгчид хүлээлгэсэн байгаа. Ийм үндэслэл байна гэсээр байтал шүүгч Б өөрөө татгалзаагүй, бидэнд эхнэрийнхээ ахыг гэж мэдэгдээгүй. Энэ тухайд нь тусгайлан Ерөнхий шүүгчид нь асуудал тавьж шүүгч Б-гээс татгалзаж байгаа тул шийдвэрлэж өгөхийг хүссэн. Ерөнхий шүүгч асуудлыг шийдвэрлэж өгөөгүй тэр ч бүү хэл үг хэлэх боломж олгоогүй, “Чи зайл” гэж зандран зүй зохисгүй байдал гаргасанд гомдолтой байгаа тул хянан шийдвэрлэж өгнө үү. Үнэхээр ёс зүйгүй авирласанд гомдолтой байна.

Өгөгдөл: "Шүүгчийн ёс зүйн дүрэм" шинэчлэн батлаагүй гэсэн шалтгаар Шүүхийн ёс зүйн хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01 тоот “Гомдлын хэрэг шалгах ажиллагааг түдгэлзүүлэх”, 2014 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 03 тоот “Гомдлын хэрэг шалгах ажиллагааг сэргээх” тухай захирамж гарсан.

Асуулт: Шүүгч, Ерөнхий шүүгч нарт сахилгын хэрэг үүсгэж, сахилгын шийтгэл ногдуулсан нь үндэслэлтэй юу? Шүүх хэрхэн шийдвэрлэх вэ?

Тохиолдол 46: Шүүгч Х шүүхийн үзлэг явуулж хэргийн оролцогчдыг байлцуулан маргаан бүхий газарт хэмжилт хийх зэрэг ажиллагааг явуулж байх явцдаа нэхэмжлэгчид хандан та энэ талаар маргаад нэмэргүй юм биш үү. Иймэрхүү маргааныг өмнө нь шийдсэн шийдвэрүүд шүүх.мн сайтад байгаа та үзээрэй гэж хэлсэн байна. Маргааш нь шүүх хуралдаан дээр шүүгчээс татгалзах хүсэлт нэхэмжлэгчээс гаргажээ.

Асуулт: Нэхэмжлэгчийн татгалзал үндэслэлтэй юу? Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан уу?

Тохиолдол 47³⁸: Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоохын тулд түүнтэй холбоотой мэдээлэл хайж www.shuukh.mn сайтаас шүүгдэгчтэй холбоотой иргэний хэргийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг олж хуулбарлан авч үнэлж дүгнэжээ.

Асуулт: Шүүгчийн үйлдэл ёс зүйн зөрчил болох уу? Татгалзах, татгалзагдах нөхцөл энэ тохиолдолд яригдах уу?

³⁸ Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (2013-2016). УБ 2017 он. Монгол Улсын шүүхийн ёс зүйн хороо” . 186-209 дэх тал.

Тохиолдол 48: Амьдрал дээр шүүгчийг үндэслэлгүйгээр гүтгэх эсхүл ёс зүйн зөрчилд үл хамаарах асуудлаар гомдол гаргах явдал түгээмэл байна. Шүүхийн ёс зүйн хороонд ирсэн гомдлын дийлэнх нь үндэслэлгүй байдаг болохыг судалгааны тоо баримт харуулж байна. Шүүгч Б нь өөртэй нь холбогдуулж иргэн Д нь Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргасан тул сөрөг байдлаар хандаж энэ хүн гүжирдэж гүтгэсэн гэжээ. Тухайлбал гомдол гаргагч Д-г гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч, балмад этгээд зэргээр нэрлэж ихэд уурсжээ.

Асуулт: Энэ тохиолдолд шүүгч биеэ яаж авч явж уг асуудалд хэрхэн хандах ёстой вэ? Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах уу? Шүүгчийн ёс зүйн зөрчилтэй асуудал энэ тохиолдолд байгаа эсэхийг шинжилж дүгнэлт хийнэ үү.

Тохиолдол 49: Өмгөөлөгч байсан хүн шүүгч болов. Өмнө нь хамт өмгөөлөл хийж байсан хүн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор оролцов. Тэд 6 жилийн өмнөөс хамт ажиллахаа болсон байна.

Асуулт:

1. Зөрчил мөн үү, шүүгч энэ тохиолдолд хэрхэх вэ?
2. Хэрэв энэ 2 хүн хууль зүйн туслалцааны төвийн 2 өмгөөлөгчөөр хамт ажиллаж байсан бол ...?

ХЯНАЛТЫН АСУУЛТ

- Ашиг сонирхлын зөрчил гэдгийг тайлбарлаж бичнэ үү?
- Хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар хэлэлцэнэ үү?
- Шүүгчийн татгалзал, татгалзагдах боломж нөхцөлийн талаар тайлбар хийнэ үү?
- Ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаануудыг нэрлэнэ үү?
- Ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

АНХААРАХ АСУУДАЛ

Хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэм болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй, үүссэн гэж үзэж болох бүх нөхцөлийг заах боломжгүй, харин наад захын стандартуудыг л заадаг тул болзошгүй нөхцлүүдийг анхааруулах, кэйс бодлогоор батжуулах.

Татгалзах, татгалзлаа талуудад мэдэгдэх, татгалзах үндэслэлтэй бол энэ талаар маргааны талуудад мэдэгдэж тэдгээрийг шүүгчээс татгалзах боломжоор хангах, энэ нь зайлшгүй байх ёстой гэдгийг анхааруулах.

ЭХ СУРВАЛЖ

1. Үндсэн хууль.
2. Монгол Улсын шүүхийн тухай хууль
3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
7. Авлигын эсрэг хууль
8. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
9. Гэр бүлийн тухай хууль
10. Шүүгчийн ёс зүйн дүрэм
11. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм
12. Шүүгчийн бие хамгаалах тусгай хэрэгсэл, хадгалах заавар
13. Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (2013-2016). УБ 2017 он. Шүүхийн ёс зүйн хороо.
14. Шүүгчийн ёс зүй ба сахилга. Олон улсын бага хурал: Илтгэл, зөвлөмж, судалгаа. УБ 2017 он. Шүүхийн ёс зүйн хороо.
15. “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” Нийтийн албан тушаалтны гарын авлага. 2014 он. УБ.
16. Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээн таниулах ажлын гарын авлага. 2014 он. УБ.
17. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаан дахь авлигаас урьдчилан сэргийлэх нь”. Гарын авлага. 2007 он. УБ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ШҮҮГЧИЙН АЛБАН ҮҮРГЭЭС БУСАД ХУВИЙН АМЬДРАЛД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ

Д.Гансүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч асан, Монгол Улсын гавьяат хуульч

Л.Эрдэнэбат, Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч

Дэ.Энхцэцэг, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

Б.Отгон, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн Шүүхийн судалгаа хариуцсан ахлах референт

Л.Галбаатар, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш

СЭДЭВ 4. ШҮҮГЧИЙН АЛБАН ҮҮРГЭЭС БУСАД ХУВИЙН АМЬДРАЛД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ

Зорилго: Энэхүү хэсэгт шүүгчийн хувийн амьдралд баримтлах ёс зүй буюу албан үүргээс бусад үйл ажиллагааны хөлс, бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл хүлээн авах, шүүгчийн улс төрийн үйл ажиллагаа, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэхтэй холбоотой ёс зүйн шаардлагын талаарх үндэсний болон олон улсын зохицуулалт, тэрхүү зохицуулалтын тайлбарын талаарх цэгцтэй ойлголт өгч, шүүгчийн зүгээс хувийн амьдралдаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх ур чадвар олгоно.

Нэр томьёо: албан үүргээс бусад үйл ажиллагаа, хөлс, бэлэг, үйлчилгээ, улс төрийн үйл ажиллагаа, мэдүүлэх үүрэг, итгэл үнэмшил, эвлэлдэн нэгдэх.

Дэд сэдэв:

- *Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаа*
- *Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны хөлс*
- *Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл хүлээн авах хязгаарлалт*
- *Шүүгчийн улс төрийн үйл ажиллагааны хязгаарлалт*
- *Итгэл үнэмшлээ илэрхийлэхэд баримтлах хязгаарлалт*
- *Эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах хязгаарлалт*

4.1. Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаа

Шүүгчийн мэргэжлийн ёс зүйг зөвхөн шүүн таслах ажиллагааны хүрээнд хязгаарлах боломжгүй бөгөөд албаны ёс зүйг хувийн амьдрал дахь ёс зүйгээс хатуу зааглан ялгах нь тийм хялбар биш. Учир нь тухайн хүний хувийн амьдралын зан үйл шүүгчийн албаны үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой.

Шүүгч зөвхөн мэргэшил төдийхөн бус, харин амьдралын хэв маяг юм. Тухайлбал Шүүх олон нийтийн итгэлийг олох, үйлчлүүлэгчид ямагт итгэл төрүүлэхүйцээр бие авч явах шаардлага тулгардаг.³⁹ Шүүгч шүүн таслах ажиллагаанаас бусад орчинд ч гадаад байдал, үг яриа, үйлдэл, харилцаа, хандлагаа цэнэж хувь хүнийхээ хувьд буруу ойлголт төрүүлэх, алдаа дутагдал гаргахаас үргэлж сэргийлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл эмч, инженер, үсчин гэх мэт бусад мэргэжилтний хувьд ажил мэргэжлийн ёс зүй нь зөвхөн ажлын байранд үндсэн ажил үүргээ гүйцэтгэх үед л яригддаг бол шүүгчийн хувьд ажлын бус үед ч мэргэжлийн ёс зүйгээ байнга санан өөртөө

³⁹ Н.Лүндэндорж. Шүүх эрх мэдэл. УБ 2017. 163 дахь тал.

зүй зохистой амьдралын хэв маягийг хэвшүүлэх шаардлагатай байдгаараа онцлог.

Шүүгч албан үүргээс бусад нийгмийн амьдрал дахь бүхий л зан үйлдээ анхаарч, баримталбал зохих үзэл баримтлалыг шүүгчийн хувийн амьдралд баримтлах зарчим гэж өргөн хүрээнд тодорхойлж болно.

Шүүгчийн ёс зүйн шаардлагуудыг заавал биелэгдэх агуулгаар урьдчилан дүрэмчлэн зохицуулдаг. Гэвч шүүгчийн албан үүргээс гадуур хувийн амьдралын орон зай хэт өргөн бөгөөд тухайн цаг хугацаанд явагдах олон олон харилцааг урьдчилан харж, сэргийлж, нэг бүрчлэн зохицуулах боломжгүй билээ. Үүнтэй холбоотойгоор ёс зүйн дүрэм нь шүүгчийн албаны үйл ажиллагаа болон хувийн амьдралд баримтлах малгай зарчмуудыг санал болгодог онцлог бичилттэй. Ёс зүйтэй, шударга шүүгч байхын тулд зөвхөн хууль, дүрэмд захирагдах нь хангалтгүй бөгөөд ёс зүйн зарчим шаардлагуудыг бичмэл байдлаар хэлбэржсэн эсэхээс үл хамааран өргөн агуулгаар хүлээн авч ажил, амьдралдаа мөрдөх нь зүйтэй.

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд шүүгчийн албаны үүргээс гадуур баримтлах ёс зүйн шаардлагуудыг олон улсын болон үндэсний хэм хэмжээнд хэрхэн тодорхойлсныг зарим тайлбарын хамт хүргэж байна.

Шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын 4.2-т “Шүүгч нь олон нийтийн байнгын хяналтад байдаг тул жирийн хүний хувьд бэрхшээлтэй байж болох хувийн эрхийг хязгаарласан хэм хэмжээг өөртөө тогтоох ёстой бөгөөд үүнийг ямар нэг шахалт шаардлагагүйгээр, сайн дураараа өөрөө хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа, шүүгч нь шүүхийн өндөр нэр хүндэд нийцүүлэн биеэ авч явбал зохино” гэж заасан.

Энэ талаар “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбар”-ын 115-д “Шүүгч нь бүрэн эрхийн хугацаандаа бусдад үлгэр жишээ болохуйц амьдрах хэрэгтэй. Шүүхийн үйл ажиллагаа нь шүүгчийг олон нийтэд үйлчлэхдээ мэдрэмжтэй байх, өөрийгөө хянахыг шаарддаг. Учир нь олиггүй зан авир гаргах нь шүүн таслах үйл ажиллагааны явцад сөргөөр нөлөөлж, шүүхийн нэр хүндэд үл нийцнэ” гэж тодотгожээ.

Мөн тус тайлбарын 166-д “Шүүгч нь шүүхээс гадуурх, нийгмээс тусгаарлахгүй зохих үйл ажиллагаанд оролцож болно. Тиймээс, шүүгч нь хуулийн бус сэдвээр бичих, лекц унших, багшлах, ярих, урлаг, спортын болон бусад нийгэм, амралтын үйл ажиллагаанд оролцож болно. Гэхдээ эдгээр үйл ажиллагаа нь шүүгчийн албаны нэр хүндийг унагах, шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй байх ёстой. Чухамдаа, өөр

талбарт ажиллах нь шүүгч өөрийн мэдлэгийн хүрээгээ өргөжүүлэх, хууль зүйн мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд олж авсан мэдлэгээ тэлж, нийгэм дэх асуудлыг ойлгох бололцоо олгодог. Гэхдээ, шүүгч нийгэмтэй ойр байх ба албан үүргээ хараат бусаар, төвийг сахин хэрэгжүүлэх, тийнхүү харагдах хооронд бодит тэнцвэрийг тогтоох хэрэгтэй. Эцсийн дүндээ, шүүгчийн нийгмийн идэвхтэй амьдрал нь нийгмийн тодорхой орчинд, ухаалаг ажиглагчийн нүдэнд шүүгч хараат бус, төвийг сахих, тийнхүү харагдах нөхцөлд бодит эрсдэл гаргах эсэх асуулт үргэлж тавигддаг” гэжээ.

Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014 оны 1/08 –р тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.2 дугаар зүйлд “Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаа”-ны талаар тусгасан.

Үүнээс гадна, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 17.1 дүгээр зүйлд шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны талаар зохицуулсан. Ингэхдээ, шүүгчийн албан үүргээс бусад хориглосон үйл ажиллагааг тоочихгүйгээр, агуулгаар нь тусгажээ. Тодруулбал, тус дүрмийн 2 дахь хэсэгт шүүгч шүүгчийн албан үүргээс бусад дараах агуулга бүхий үйл ажиллагаанд оролцохыг хориглосон. Үүнд:

- Шүүгчийн үүргээ зохистой хэрэгжүүлэхэд саад болохуйц;
- Дээрх нөхцөл байдлын улмаас хэргийн оролцогчийн зүгээс шүүгчээс татгалзахад хүргэх;
- Шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулах;
- Хүч хэрэглэсэн мэт ойлгогдох.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.2 дугаар зүйлийн 2-т “*Шүүгч шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөхийг хориглоно*” гэж, 3-т “*Шүүгч нь шүүхийн байр, техник, тоног төхөөрөмж, санхүү, мэдээллийн хэрэгсэл, бичиг хэрэгсэл эсхүл бусад эх үүсвэрийг хувийн зорилгоор дур мэдэн ашиглаж болохгүй*” гэж заасан.

Энэ талаар “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбар”-ын 219-т “Шүүхийн ажилтан болон тоног төхөөрөмжийг зохисгүйгээр ашиглах нь, шүүхийн ажилтныг маш хүнд нөхцөл байдалд оруулж, шүүх эрх мэдлийг урвуулан ашиглаж буй явдал юм. Шүүхийн ажилтан нь шүүгчдэд тогтсон дэг жаягт нийцэхгүй зохисгүй, хэт хувийн үйлчилгээ үзүүлэх ёсгүй” гэжээ.

Мөн тус тайлбарын 147-д “Шүүхийн хэвлэмэл хуудсыг хэрэглэхдээ шүүхийн нэр хүндийг буруугаар ашиглах байдал гаргаж болохгүй. Ерөнхийдөө, шүүхийн хэвлэмэл хуудсыг шүүгчийн зүгээс албан ёсны зүйл

бичихийг хүсэх үед ашигладаг. Шүүхийн хэвлэмэл хуудсыг хувийн зүйл бичихдээ хэрэглэх бол анхааралтай байх хэрэгтэй. Тухайлбал, нөхцөл байдлаас хамааран, нийгмийн үйл явдлын дараа талархлын зурвас илгээхдээ тэрхүү хэвлэмэл хуудсыг хэрэглэхийг хориглохгүй. Гэхдээ шүүхийн хэвлэмэл хуудсыг захиа хүлээн авагчид нөлөөлөхийн тулд хэрэглэж, шүүгч албан тушаалдаа анхаарал хандуулахыг хүсч байна гэх ойлголт төрүүлэх нь зохисгүй. Тухайлбал, даатгалын бичиг баримттай холбоотой гомдол гаргахдаа шүүхийн хэвлэмэл хуудсыг хэрэглэх нь зохисгүй” гэжээ.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.2 дугаар зүйлийн 4-т *“Шүүгч нь шүүгчийн албан үүргээс бусад дараах агуулга бүхий үйл ажиллагаанд оролцохыг хориглоно: 4.1. Арилжааны аливаа хэлбэрийн зар сурталчилгаанд оролцох; 4.2. Хуулиар зөвшөөрснөөс бусад ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах”* гэж заасан.

Энэ талаар “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбар”-ын 153-т “Дотоод тогтсон дэг жаягаас хамааран, хуучин шүүгчийн хувьд, түүний холбогдох туршлагыг дурдсан мэдээлэл бүхий эвлэрүүлэн зуучлал, арбитрын үйлчилгээг санал болгосон зар сурталчилгаанд шүүгчийн дүрээр гарч болох юм. Гэхдээ нэгэнт шүүгчээр ажиллахаа больсон тул, түүний албан тушаалд ‘тэтгэвэртээ гарсан’, ‘асан’ гэх үгийг хэрэглэж, тодотгох хэрэгтэй. Хуучин шүүгчийн хувьд өндөр дээд албан тушаалын илэрхийлэл болох зэрэг, дэвийг дээр дурдсан зар сурталчилгаанд хэрэглэж болохгүй” гэжээ.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.2 дугаар зүйлийн 5-д *“Шүүгч нь өөрийн хамаарал бүхий этгээддээ хууль зүйн зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулах, хянах ажиллагаа явуулж болох боловч тэдгээрийн хуульчаар ажиллаж болохгүй”*, 6-д *“Шүүгч өөрийн болон гэр бүлийн гишүүн, албан байгууллагынх нь эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байхыг хориглоно”* гэж заасан.

Энэ талаар “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбар”-ын 174-т “Шүүгч нь хууль зүйн зөвлөгөө өгөх ёсгүй. Гэхдээ гэр бүлийн гишүүн, ойрын найз нөхдөдөө нөхөрсөг, албан бус, үнэ хөлсгүй хувийн зөвлөгөө санал болгож болох бөгөөд хууль зүйн зөвлөгөө өгөх ёсгүй гэдгээ тодорхой ойлгуулна. Хэрэв шаардлагатай бол, хууль зүйн зөвлөгөөг мэргэжлийн хүнээс авах хэрэгтэй”, 175-д “Шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах зэргээр шүүгч нь өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрхтэй. Гэхдээ шүүгч нь хувийнх нь нэхэмжлэл, гомдлыг шийдэхэд оролцохгүй байх талаар анхаарал тавина. Нэхэмжлэгч, гомдол гаргагчийн хувиар оролцох нь, шүүгч албаны давуу талаа ашиглаж байна гэх сэтгэгдэл төрүүлэх эрсдэлтэй

байдаг. Мөн шүүгчийн итгэл үнэмшилд шүүхийн хамт ажиллагсдынх нь дүгнэлт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байдаг” гэж тайлбарласныг анхаарч үзэх хэрэгтэй юм.

Тохиолдол:

Тохиолдол 50: Цаг хэмнэх болон эрүүл хооллох зорилгоор А шүүгч өөрийн туслах Б-тэй харилцан тохиролцож өдрийн хоолны өртөг зардлыг шүүгч, хоол бэлтгэж болгох, цэвэрлэх ажлыг туслах хариуцах болсон байна. Улмаар энэ маягаар өдөрт шүүгчийн өгсөн мөнгөөр туслах нь хүнс цуглуулан өрөөндөө хоол бэлтгэж хамт иддэг болов. Шүүгчийн ёс зүйн зөрчлийн асуудал хөндөгдөх үү?

Асуулт:

1. Удирдлагадаа байгаа хүнд албаны чиг үүргээс гадуур үүрэг даалгавар өгөх ёс зүйн шаардлага зөрчигдөх үү? Харилцан тохиролцоо байх боломжтой юу?
2. Шүүхийн тог цахилгааныг хувийн хэрэгцээнд ашигласан уу?

Тохиолдол 51: Шүүгчийн ганц хүү С нь нийгмийн идэвхтэй нэгэн. Төрөл бүрийн хурал, цуглаанд оролцож агуулга танилцуулахдаа шүүн таслах ажиллагаатай холбогдолтой нарийн мэдээллүүд дурддаг байсны дотор хаалттай шүүх хуралдаанаар хэлэлцсэн мэдээлэл хүртэл байв. Энэ нь шүүгч аавыг нь хардах сэдэл болж гомдлын дагуу хяналт шалгалт явуулахад шүүгчийн албан өрөөнөөс бус гэрийнх нь компьютерээс зарим мэдээлэл алдагдсан болохыг тогтоов. Энэ талаар шүүгч мэдээгүй байсан юм.

Асуулт: Шүүгчид ёс зүйн хариуцлага тооцох үндэслэлтэй юу? Эсхүл хувийн зохион байгуулалт муу байснаас ажлын хариуцлага алдсан үйлдэл үү?

4.2. Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны хөлс

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Аливаа хэрэг маргааныг эцэслэн шийддэг тул шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрөгдөхүйц, шударга, үнэн зөв байхыг олон нийтийн зүгээс хүсдэг, бас шаарддаг. Эндээс шүүхэд итгэх итгэлийг хадгалж, хамгаалах зайлшгүй шаардлага урган гарна. Шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрөгдөхүйц байхын нэг үндэс нь тухайн маргааныг шийдвэрлэх эрх бүхий шүүгч нь мэргэжлийн хувьд өндөр төвшинд бэлтгэгдсэн байхын зэрэгцээ хэрэг маргаан бүрт ач холбогдол өгч, хичээнгүйлэн ажиллах хүрээнд үндсэн үйл ажиллагаандаа хангалттай цаг зарцуулахаас шууд хамаарна. Тийм учраас шүүгчид хавсран эрхлэх ажил, албан тушаалын

хязгаарлалт зайлшгүй тавигддаг. Шүүгчийн давхар ажил эрхлэлтийн хязгаарлалтын гол шаардлага нь нэг талаас шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой бүрэн эрхийн хүрээнд шүүн таслах үндсэн үйл ажиллагаандаа өөрийн мэдлэг чадвар, цаг, боломжийг бүрэн зориулах, нөгөө талаас давхар эрхэлж буй ажил, албан тушаал нь тэрхүү үндсэн үйл ажиллагаанд нь агуулга, хэлбэрийн хувьд сөргөөр нөлөөлөхөөргүй байхад чиглэнэ.

Олон улсын заншлын хэм хэмжээ, шүүгчийн ёс зүйн нийтлэг стандартуудад шүүгчийн давхар ажил эрхлэлтийн хязгаарлалтын хүрээнд зөвшөөрөгддөг ажил, албан тушаал бол багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, хууль, эрх зүйн шинэчлэл болон мэргэжлийн хөгжлийг дэмжих ажилд гар бие оролцох, өөрийн байр суурийг илэрхийлэхийг зөвшөөрдөг. Нэгэнт хууль, дүрмийн хүрээнд зөвшөөрөгдсөн давхар ажил эрхлэлт, үйл ажиллагаа явуулсны төлөө зохих цалин хөлс, олговрыг авах эрхтэй. Харин цалин хөлс, төлбөр нь хэт өндөр үнэлгээтэй байх нь шүүгч давуу тал эдэлсэн гэх хардлагыг дагуулдаг тул ихэнх улсад үүнийг зохицуулсан байдаг. Давхар ажил эрхлэлтээс олсон орлогын хэмжээг зохицуулахаас гадна тэрхүү орлогын эх үүсвэрийг ил тод байлгах үүргийг шүүгч хүлээдэг байна.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.4 дүгээр зүйлийн 1-т “Шүүгчийн албан үүргээс бусад хууль болон энэ дүрмээр хориглоогүй үйл ажиллагааны хөлс нь бусдын нэгэн адил хэмжээтэй байна” гэж заасан.

Энэ талаар, Шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын тайлбарын 182-т “Шүүгч нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн буюу илтгэл тавьсны хөлс түүний гүйцэтгэсэн ажилтай нь дүйцсэн буюу бодитоор тогтоосон бол тэрхүү хөлсийг авч болохыг хориглоогүй. Шүүгч нь түүний гүйцэтгэсэн үйл ажиллагаа зөрчилдөөн үүсгэхгүй байх нөхцөлийг хангах ёстой. Шүүгч нь хувийн дэмжлэг үзүүлэх байдлаар шүүх дэх албан тушаалыг ашиглаж буй мэт харагдах ёсгүй бөгөөд шүүх дэх үүргийнхээ дийлэнх цаг хугацааг үнэ, хөлс бүхий илтгэл тавих, яриа хийх, бичгийн ажил хийхэд зарцуулж болохгүй. Түүнчлэн, төлбөрийн эх үүсвэр нь шүүгч хэрэг маргааныг төвийг сахин шийдвэрлэхэд зохисгүй нөлөөлөхүйц байх ёсгүй” гэж тодотгожээ.

Мөн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 17.10 дугаар зүйлд шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны хөлсний талаар зохицуулахдаа “Шүүгч өөрийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулахгүй тохиолдолд хууль болон энэ дүрмээр зөвшөөрсөн шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаанд хөлс авч болно” гэжээ.

Тохиолдол 52: Шүүгч Э багын сайн найз Г-ийн хувийн өмчлөлийн хууль зүйн дээд сургуульд цагаар хичээл заадаг. Ажлын ачааллаас хамааран хуваарьт хичээлээ алдаг оног зааж байсан тул суралцагчдаас гомдол гаргаж хяналт шалгалт явуулахад шүүгч гэрээгээр хүлээсэн хуваарьт хичээлийн 30 орчим хувьд нь ажиллаж түүнд тохирсон цалин хөлсөө авсан байв.

Асуулт:

1. Шүүгчийн хавсран эрхэлж буй ажил давхар ажил эрхлэлтийн хязгаарлалтад хамаарах уу?
2. Шүүгчийн үйлдэл ёс зүйн зөрчил мөн үү?

4.3. Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл хүлээн авах хязгаарлалт

Бусдаас бэлэг, өв хүлээн авах, зардлаа төлүүлэх, төлбөрөөс чөлөөлүүлэх зэрэг нь иргэд болон бусад ихэнх мэргэжилтний хувьд энгийн үзэгдэл бол шүүгчийн хувьд энэ асуудлыг нарийвчлан зохицуулдаг онцлогтой. Учир нь дээрх үйлдлүүд нь шүүгчийг албаны эрх мэдлийн тусламжтайгаар хөрөнгөжих, үндэслэлгүй давуу тал эдэлж байж болзошгүй хардлага дагуулах эрсдэлтэй тул нарийн зохицуулах шаардлага тулгардаг.

Шүүгч нь хувь хүнийхээ хувьд зөвхөн ойр дотнын хүнээсээ буюу гэр бүлийн гишүүдээс бэлэг, өв, зээл, бусад хууль ёсны орлого хүлээн авах эрхтэй бөгөөд гагцхүү үүнийг хууль, дүрэм, журамд заасны дагуу мэдүүлэх үүрэгтэй. Харин шүүгчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх явцад эсхүл шүүхийг төлөөлөн шүүгчийн хувиар оролцсон арга хэмжээний үед бусдаас бэлэг, дурсгал, шагнал, урамшил зэргийг хүлээн авах журмыг нарийвчлан зохицуулдаг байна.

Шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын 4.16-д “Шүүгч нь тодорхой арга хэмжээнд нийцүүлэн өгч байгаа жижиг бэлэг, шагнал, урамшуулал нь шүүгчийн шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх зорилготой байсан гэх ойлголт төрүүлэхээргүй, түүнчлэн аль нэг талд үйлчилсэн гэх байдал бий болгоогүй тохиолдолд жижиг бэлэг, шагнал, урамшууллыг хуульд заасан тохиолдолд хүлээн авч, хуулиар тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлнэ” гэж заасан.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.5 дугаар зүйлд “Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл хүлээн авах” нөхцөлийг гурван хэсэгт тусгасан.

Энэ талаарх анхаарах нөхцөлийг “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын тайлбарын 181-т “Шүүгчид буюу түүний гэрт байнга хамт амьдардаг гэр бүлийн гишүүнд хэт үнэтэй бэлэг өгөх нь шүүгчийн төвийг сахих байдал, шүүхийн албаны үнэнч шударга байдалд асуудал үүсгэж, шүүгчээс татгалзах нөхцөл болдог. Тиймээс ийм бэлгийг авч болохгүй. Шүүгч нь ийм бэлэг буюу бэлэг өгөх саналаас эелдгээр татгалзах боломжтой. Заримдаа ийм бэлгийн санал, талархал илэрхийлэх дүрэм, дэг жаяггүйгээр өөрөө аяндаа ирдэг. Хуулиар зөвшөөрсний дагуу шүүгч гэрлэлт, иргэний харьяаллын ёслолыг гүйцэтгэсний дараа эрүүл мэндийн клубын захиалгыг зориуд санал болговол, шүүгч нь албан үүргээ гүйцэтгэсэнтэй холбоотой хөлс, үйлчилгээ авч болохгүй нөхцөлийг тайлбарлаж, татгалзана. Нөгөө талаар, шил виски юм уу, шүүгчийн дуртай хөгжмийн нэг, хоёр компакт диск өгөх нь зөрчил болохгүй байж болно” гэжээ.

Мөн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 17.11 дүгээр зүйлд “Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл хүлээн авах, мэдүүлэх” нөхцөлийг зохицуулсан. Ингэхдээ хууль, дүрэмд хориглосноос бусад тохиолдолд шүүгч нь дараах зүйлсийг мэдүүлэхгүйгээр хүлээн авч болно гэжээ. Үүнд:

- Дурсгалын зүйл, гэрчилгээ, цом, ил захидал зэрэг үнэ багатай зүйлс;
- Олон нийттэй адил нөхцөлөөр авч болох санхүүгийн эсхүл худалдааны боломж, хямдрал, үйлчилгээ, зээл, уралдаан, тэмцээний шагнал, тэтгэлэг, хонжвор, сугалаа;
- Ном, сэтгүүл, дүрс, дуу бичлэг;
- Хуульд өөрөөр заагаагүй бол, шүүгчийг татгалзахад хүргэх этгээдээс өгсөн бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл.

Мөн Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 17.12 дугаар зүйлд “Зардлыг нөхөн төлүүлэх ба төлбөрөөс чөлөөлүүлэх” талаар зохицуулсан. Ингэхдээ, тус зүйлийн 1 дэх хэсэгт “хууль, дүрэмд хориглосноос бусад тохиолдолд шүүгч нь энэ дүрэмд зөвшөөрсөн шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаанд оролцохтой холбогдуулан аялал, хоол, байр, бусад зардлыг нөхөн төлүүлж, эсхүл бүртгэл, сургалтын төлбөр, түүнтэй төстэй төлбөрөөс чөлөөлүүлж болно” гэжээ. Түүнчлэн, тус зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгчийн аялал, хоол, байр эсхүл бусад зардалд өгөх нөхөн төлбөр нь шүүгчид өөрт нь болон шаардлагатай тохиолдолд түүний эхнэр буюу нөхөр, хамтран амьдрагч, зочинд зарцуулсан бодит зардлаар хязгаарлагдана”, 3 дахь хэсэгт “Өөрийн эсхүл эхнэр буюу нөхөр, хамтран амьдрагч, зочныхоо зардлыг нөхөн төлүүлэх эсхүл төлбөрөөс

чөлөөлөгдөхийг зөвшөөрсөн шүүгч нь энэ дүрмийн 17.13 дугаар зүйлд заасны дагуу энэ талаар мэдүүлнэ” гэж зохицуулжээ.

Түүнчлэн, “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын тайлбарын 179-т дараах зүйлийг хүлээн авахыг хориглодоггүй гэжээ. Үүнд:

1) Ерөнхийдөө шүүгчийн эргэн тойрон дахь, ажил хэргийн зорилгогүй нийтлэг зочломтгой байдал болон хоол, зууш гэх мэт бага хэмжээгээр хэрэглэгдэх зүйлс;

2) Гоёл чимэглэлийн ширээ, гэрчилгээ, цом, мэндчилгээний карт зэрэг зөвхөн танилцуулгын зорилготой багахан үнэ цэн бүхий эд зүйлс;

3) Банк, бусад санхүүгийн байгууллагаас шүүгчийн статустай нь холбоогүйгээр, холбогдох хүчин зүйлд тулгуурлаж, ердийн нөхцөлөөр олгосон зээл;

4) Шүүгчийн статустай нь хамааралгүй, бусад хүчин зүйлсэд тулгуурласан таатай хувь хэмжээ, арилжааны хямдрал зэрэг боломж, ашиг тус;

5) Шүүгчийн статустай нь хамааралгүй, бусад хүчин зүйлсэд тулгуурласан зургийн уралдаан зэрэг олон нийтэд нээлттэй тэмцээн, бусад үйл явдалд бусдын адил оролцож, өрсөлдсөнийх нь хувиар нь өгч буй шагнал;

6) Шүүгч эсэхээс нь үл хамааран, хэн бүхэнд адил шалгуур тавьж, адил нөхцөлийн дагуу олгосон тэтгэлэг;

7) Эрх зүй, эрх зүйн тогтолцоо, шүүх засаглалыг сайжруулахтай холбоотой чиг үүрэг буюу үйл ажиллагаанд шүүгч оролцохтой холбоотой аяллын зардал, шүүгч, түүний хамаатны тээвэр, орон байр, хоол ундны зэрэг зардлын нөхөн олговор буюу буцаан олголт;

8) Шүүхээс гадуурх хууль ёсны буюу зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны бодит төлбөр.

Тохиолдол 53: Шүүгч гадаад улсад албан томилолтоор суралцах болов. Өгөгдсөн нөхцөлийн дагуу 2 талын тээврийн зардлыг хувиасаа хариуцах байв. Шүүгчийн тухайн 10 сая төгрөгийн тээврийн зардлыг түүний бизнесмен, бага сургуулийн дотно найз нь төлсөн байна.

Асуулт:

1. Хэрэгт хамааралгүй, дотнын хүнээс өндөр үнийн дүнтэй бэлэг хүлээж авах нь ёс зүйн зөрчил мөн үү? Хүлээж авсны дараа тухайн этгээд хэргийн оролцогч болсон тохиолдолд татгалзах байдлаар шийдвэрлэж болох уу?
2. Ёс зүйн зөрчил мөн бол аль зөрчилд хамаарах вэ?

Тохиолдол 54: Шүүгч А-ын хүүгийн хуримд уригдсан шүүгчийн найз бизнесмен Б хуримын хосод хотын төвд 2 өрөө орон сууц бэлэглэсэн байна.

Асуулт: Шүүгчийн найз шүүгчийн ойр дотнын харилцаатай хүн мөн үү? Бэлэг хүлээж авах нь ёс зүйн зөрчилд тооцогдох уу?

Тохиолдол 55: Шүүгч А ээлжийн амралтаараа баруун аймгуудаар гэр бүлийн аялал хийжээ. Замд таарсан постуудаар шүүгчийн үнэмлэхээ үзүүлэн замын татвар, хураамж төлөлгүй явсан байна.

Асуулт: Шүүгчийн энэхүү үйлдэл ёс зүйн зөрчил мөн үү? Аль зөрчилд хамаарах вэ?

4.4. Шүүгчийн улс төрийн үйл ажиллагааны хязгаарлалт

Шүүгч нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болохын хувьд Үндсэн хуульд заасан иргэний зарим үндсэн эрхүүдээсээ татгалзах, хязгаарлуулах шаардлага тулгардаг. Үүний нэг жишээ бол улс төрийн ажиллагаанд оролцох эрхийн хязгаарлалт юм. Эрх зүйт ёсонд тулгуурласан ардчилсан чөлөөт улсын эрх зүйн тогтолцоонд шүүх эрх мэдэл улс төрөөс хамааралгүй байх нь үндсэн зарчим билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т: “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж зааснаараа шүүх эрх мэдлийг аливаа төрийн байгууллагын нөлөө, улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах зарчмыг тунхагласан.

Зарим улс оронд шүүгчдийг улс төрийн үйл ажиллагааны тодорхой төрөлд буюу үндэсний парламент, Европын парламент, орон нутгийн зөвлөлд оролцохыг хориглодог. Тэр ч бүү хэл зарим тохиолдолд шүүгчийн гэр бүлийн гишүүн (эхнэр, нөхөр, хүүхэд гэх мэт)-ийг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглодог⁴⁰ байна.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.9 дүгээр зүйлд болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 18.1, 18.2, 18.3 дугаар зүйлд шүүгчийн улс төрийн үйл ажиллагааны талаар зохицуулсан.

Шүүхийн эрх бүхий байгууллага ёс суртахууны хариуцлага хүлээлгэж чадаж буй эсэх дээр олон нийтийн итгэл оршдог. Энэ нь, шүүхийг бодит байдал дээр төдийгүй харагдах байдлын хувьд ч улс төрийн байр сууринаас

⁴⁰ Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл “Шүүгчдийн биеэ авч явах байдал, төвч байх зан байдлыг мэргэжлийн үүднээс зохицуулах зарчим болон дүрмийн тухай” (2000 №3) 30 дугаар тал

асуудалд хандахаас зайлсхийж, улс төрийн хүчний нөлөөллөөс бүрэн ангижрахыг шаарддаг.⁴¹ Шүүгчийн зүгээс шүүхийн аливаа шийдвэрт нөлөөлөх улс төрийн харилцааг зөвшөөрөх ёсгүй.

Шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын 2.2-т “Шүүгч нь шүүн таслах үйл ажиллагаа төдийгүй шүүхээс гадуурх өөрийн үйл ажиллагаагаар олон нийт, мэргэжлийн хуульчид, шүүх хуралдааны оролцогч талуудаас шүүх болон шүүгчийн төвийг сахих байдалд итгэх итгэлийг хадгалж, бэхжүүлнэ” гэж заасан. Тус заалтын талаарх тайлбарт /65 дахь хэсэг/ “Нэг талын ашиг сонирхол бүхий бүх улс төрийн үйл ажиллагаа, нэгдэл холбоо нь шүүхийн албаны талаарх ойлголтыг үгүй хийнэ. Шүүгчийн улс төрийн үйл ажиллагаа буюу олон нийтийн маргаантай асуудлаарх шүүхээс гадуурх мэдэгдэл нь төвийг сахих байдлыг сулруулж, улмаар нэг талаас шүүх, нөгөө талаас гүйцэтгэх, хууль тогтоох салбарын хоорондын харилцааны мөн чанарын талаар олон нийт төөрөгдөхөд хүргэнэ. Тодорхойлбол, олон нийтийн өмнөх шүүгчийн улс төрийн үйл ажиллагаа буюу мэдэгдэл нь мэтгэлцээний нэг талыг нөгөөгөөс нь ялган сонгож буй хэрэг юм. Хэрэв алагчилж байна гэх ойлголт нэгэнт батажсан бол, шүүгчийн үйл ажиллагаа нь шүүмжлэл, эсэргүүцлийн бай болно. Товчхондоо, шүүгч нь шүүхийн албаны давуу байдлыг ашиглаж улс төрийн талбарт орох нь шүүхийн төвийг сахих байдлын талаарх олон нийтийн итгэлийг эрсдэлд оруулна. Гэхдээ энд зарим үл хамаарах зүйлс бий. Тодруулбал, шүүгч нь зохих тохиолдолд шүүх эрх мэдлийг хамгаалж тайлбар хийх, олон нийтийн буюу мэргэжлийн хүмүүст хууль, шийдвэртэй холбоотой асуудлаар тайлбарлах, хүний үндсэн эрх, хууль дээдлэх ёсыг хамгаалах боломжтой. Хэдийгээр ийм тохиолдлууд байх боловч, шүүгч нь улс төрийн ашиг сонирхолтой гэж үзэж болох маргаантай асуудлаас аль болох зайлсхийх ёстой. Шүүгч нь улс төр, нийгмийн үзэл бодлоос нь үл хамааран бүх хүнд үйлчилдэг. Ийм учраас, шүүгч нь итгэл, найдлагыг хадгалахыг хичээх ёстой бөгөөд ингэх ч боломжтой юм” гэжээ.

Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудын 4.6-д “Шүүгч нь бусад иргэний адил үзэл бодлоо илэрхийлэх ..., эрх чөлөөг эдлэхдээ шүүхийн өндөр нэр хүнд, шүүхийн бие даасан, төвийг сахисан байдлыг хүндэтгэн дээдэлж биеэ авч явна” гэж тусгасан. Энэ талаарх Бангалорын зарчмуудын тайлбарын 134-т “Шүүгчээр томилогдсон нь түүнийг нийгмийн бусад гишүүний адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ... эрхээ эдлэхэд саад болохгүй. Гэхдээ шүүгч нь улс төрийн өмнөх итгэл үнэмшил, улс төрийн асуудлаарх ашиг сонирхлоо илэрхийлж болохгүй. Шүүгч нь шүүхийн бие даасан, төвийг сахих байдлын талаарх олон нийтийн итгэлийг хадгалахын тулд даруу төлөв байх шаардлагатай. Шүүхтэй холбоотой олон нийтийн

⁴¹ Baker v. Carr, Supreme Court of the United States of America, (1962) 369 US 186, per Justice Frankfurter.

маргаан, мэтгэлцээнд хэр хэмжээнд оролцохыг тодорхойлоход хоёр хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, шүүгч тухайн асуудалд оролцох нь түүний төвийг сахих байдлын талаарх итгэлийг алдах бодит эрсдэлтэй эсэх. Хоёрдугаарт, тэрхүү оролцоо нь шүүгчийг улс төрийн дайралтад өртүүлэх, шүүхийн албаны нэр хүндэд үл нийцэх эсэх юм. Хэрэв ийм нөхцөл байдалд орох бол, шүүгч нь тийнхүү оролцохоос зайлсхийх хэрэгтэй” гэжээ.

Мөн тус тайлбарын 135-д “Үндэсний парламент буюу орон нутгийн зөвлөлийн гишүүн зэрэг улс төрийн тодорхой үйл ажиллагаа нь шүүгчийн үүрэгтэй нийцэхгүй” гэжээ. Үүнээс гадна, тус тайлбарын 136-д “...Хэрэв шүүгч нь маргаантай асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн дунд маргаан үүсгэх, засгийн газрыг ил тод шүүмжлэх зэргээр улс төрийн тавцанд орж, олон нийтийн мэтгэлцээнд оролцдог бол тухайн шүүгчийг шүүхэд ажиллаж байх үед нь, шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна гэж харахгүй. Шүүгч тийнхүү үзэл бодлоо илэрхийлсэн асуудалтай нь холбоотой маргааныг шийдвэрлэх нь төвийг сахихгүй гэж харагдана. Ялангуяа, шүүгчийн зүгээс өмнө нь ил тод шүүмжилж байсан олны танил хүн, төрийн байгууллага нь хэргийн оролцогч, нэхэмжлэгч, гэрчээр оролцож буй хэрэг, маргааныг шүүгч төвийг сахин шийдвэрлэж чадахгүй гэж харагдах эрсдэлтэй” гэжээ.

Үүнээс гадна, дараах зүйлийг анхаарах ёстойг Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудын холбогдох тайлбарт тусгажээ. Үүнд:

- Шүүгч нь ажлын хэсэг, судалгааны багт оролцох эсэхийг шийдэхдээ, тухайн судалгааны сэдэв нь нийтийн бодлогын асуудлаар зөвлөхийг шаардах эсэх, ялангуяа улс төрийн мөн чанартай холбоотой асуудал эсэх /тайлбарын 162 дахь хэсэг/;
- Улс төрийн зорилготой байгууллага, шүүхийн нэхэмжлэлд байнга, тогтмол татагддаг байгууллагын үйл ажиллагаанд оролцохгүй байх /тайлбарын 167 дахь хэсэг/;
- Шүүгчийн гэр бүлийн гишүүд улс төрийн идэвхтэй байх эрхтэй хэдий ч, шүүгчийн төвийг сахих байдлын талаарх олон нийтийн ухамсарт нь шүүгчийн гэр бүлийн ойрын гишүүний улс төрийн үйл ажиллагаа нөлөөлнө гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой /тайлбарын 67 дахь хэсэг/;
- Хэрэв шүүгчийн эхнэр/нөхөр идэвхтэй улс төрч бол, шүүгчийн хувьд гэр бүлийн гишүүний зан үйлээс өөрийгөө тусгаарлах шаардлагатай. Ингэснээр, олон нийтийн зүгээс, шүүгчийг улс төрийн нэр дэвшигчийг дэмжиж байна гэж төсөөлөхгүй. Шүүгчийн эхнэр/нөхөр улс төрийн уулзалт, цуглаануудад оролцох үед, шүүгч түүнийг дагалдаж болохгүй. Мөн шүүгчийн гэрт тийм уулзалт, цуглаан зохиож болохгүй. Хэрэв шүүгчийн эхнэр/нөхөр тийм үйл ажиллагааг хүчлэн зохион байгуулж буй бол, шүүгчийн зүгээс оролцогчдод харагдахгүй байх, шаардлагатай бол арга хэмжээний үеэр гэртээ эзгүй байх зэргээр

өөрийгөө тус үйл ажиллагаанд хамааралгүй байлгах ухаалаг арга хэмжээ авах ёстой. Эхнэр/нөхөр нь улс төрийн аливаа хандив өгөх бол, шүүгчийн нэр, хөрөнгийг оролцуулахгүйгээр, шүүгчтэй хамтран эзэмшдэг данснаас бус зөвхөн өөрийнхөө нэрээр, өөрийнхөө хөрөнгөнөөс өгөх ёстой бөгөөд ийм зориулалттай хөрөнгө, дансаа тусдаа байлгах шаардлагатай. Энэ нь шүүхийн буюу шүүх засаглалын нэр хүндийг өсгөхгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Нөгөө талаас, шүүгчийн хувьд эхнэр/нөхрийн хамт парламентын үйл ажиллагааны нээлт, төрийн тэргүүний хүлээн авалт зэрэг цэвэр ёслолын шинжтэй үйл ажиллагаанд оролцох тохиолдолд, тухайн нөхцөл байдлаас хамаарч зохисгүй гэж тооцогдохгүй байж болно /тайлбарын 38 дахь хэсэг/.

Тохиолдол 56: Шүүгч Ц нь багын найз улс төрч Х-ийн сонгуулийн сурталчилгаанд хамт явах удаа дараагийн хүсэлтэд зөвшөөрөөгүй. Эцэст нь тэрхүү найзынхаа салхинд гарч амрах саналыг хүлээн авч хамт явсан байна. Гэвч очсон газар нь амрах газар биш сонгуулийн сурталчилгааны ажил болохыг гадарласан даруйд найздаа дургүйцэж огт ил гарахгүй байсаар хамт буцсан. Гэвч хожим нь шүүгч улс төрийн үйл ажиллагаанд оролцсон тухай орон нутгийн иргэд мэдээлэв.

Асуулт:

1. Андуурч гэнэдсэн үйлдлийг ёс зүйн зөрчилд тооцох уу?
2. Шүүгчийн үйлдэлд хууль зүйн бүрэн дүгнэлт хийнэ үү.

4.5. Итгэл үнэмшлээ илэрхийлэхэд баримтлах хязгаарлалт

Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх билээ. Харин шүүгчдийн хувьд энэхүү эрхүүд нь тодорхой хүрээнд хязгаарлагддаг бөгөөд ийнхүү хязгаарлаж буй үндэслэл нь шүүхийн хараат бус байх, төвийг сахьсан байх зарчмаас үүдэлтэй ба шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг өргөх, хадгалах, улмаар шүүх болон шүүгчийн шийдвэр аяндаа хүлээн зөвшөөрөгдөх мэргэжлийн зарчмуудтай уялдана. Тухайлбал: Шүүгч аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ өөрийн дотоод итгэл үнэмшлийг удирдлага болгох боловч түүндээ суурилсан урьдчилсан дүгнэлтээ хэргийн оролцогч болон бусад этгээдэд илэрхийлэх, танилцуулах болон тийнхүү илэрхийлж, танилцуулсан мэт ойлгогдохуйц байдал гаргахыг хууль, дүрмийн хүрээнд хориглосон билээ.

Нөгөө талаас шүүгч өөрийн гэсэн ертөнцийг үзэх үзэлтэй байж, тодорхой шашин шүтэх, эс шүтэх, улс төрийн үзэл баримтлал, байр суурийг дэмжих, аливаа үзэгдлийг зөв, буруу гэх зэргийн хувийн дүгнэлт хийх бүрэн эрхтэй, боломжтой боловч ийнхүү өөрийн дотоод үнэлэлт, дүгнэлтээ ил

зарлах, бусдад тулгах, уриалах зэргийг хориглодог. Учир нь хүн бүр шүтдэг шашин, дэмждэг нам, улс төрийн үзэл баримтлал зэрэг хандлагын хувьд харилцан ялгаатай байдгийн адил шүүхэд хандах иргэд мөн адил харилцан ялгаатай бодгалиуд юм. Тийм учраас шүүгч итгэл үнэмшил, байр сууриа ил зарлан илэрхийлэх нь шүүгч нэг талыг барьсан урьдчилсан дүгнэлттэй болж харагдах эрсдэлтэй, нөгөө талаас шүүгчийн зүгээс шүүхэд хандах иргэдийн тийнхүү зүй ёсны ялгаатай байдлыг ойлгож, хүлээн зөвшөөрөх бөгөөд ялгаатай байдал нь шүүгчийн гаргах шийдвэрт нөлөөлөхгүй байх учиртай. Түүнчлэн шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг зарчим, тэдгээрийн тайлбарт дурдсанаар шүүгч зөвхөн ёс суртахууны үүднээс өөрийн үзэл бодол, байр сууриа зайлшгүй (дайн, боолчлол, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн эсэргүүцэх гэх мэт) илэрхийлэхийг ёс зүйн зөрчилд тооцдоггүй байна. Шүүгч хууль тогтоомжийг боловсронгуй болгох, мэргэжлийн хөгжлийг дэмжих хүрээнд, эсхүл сургалтын зорилгоор хэлэлцүүлэг, зөвлөгөөнд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй байх бөгөөд гагцхүү энэ нь улс төрийн шинжтэй маргаан мэтгэлцээнээс ангид байх ёстой.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Шүүгч бусад иргэний адил үзэл бодлоо илэрхийлэх, шүтэж бишрэх эрхээ эдлэхдээ өөрийн итгэл үнэмшил, үзэл баримтлалыг бусдад тулгах, шахалт үзүүлэх, албан үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохыг хориглоно”* гэж заасан.

Шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын 4.6-д “Шүүгч нь бусад иргэний адил үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх ..., эрх чөлөөг эдлэхдээ шүүхийн өндөр нэр хүнд, шүүхийн бие даасан, төвийг сахисан байдлыг хүндэтгэн дээдэлж биеэ авч явна” гэж тусгасан.

Шүүгчийн итгэл үнэмшилтэй байх, түүнийгээ илэрхийлэхтэй холбоотой хязгаарлалт, анхаарах нөхцөлийг Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбарын 134, 136 дахь хэсэгт тусгажээ.

Тодруулбал, “Шүүгчээр томилогдсон нь түүнийг нийгмийн бусад гишүүний адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэхэд саад болохгүй. Гэхдээ шүүгч нь улс төрийн өмнөх итгэл үнэмшил, улс төрийн асуудлаарх ашиг сонирхлоо илэрхийлж болохгүй. Шүүгч нь шүүхийн бие даасан, төвийг сахих байдлын талаарх олон нийтийн итгэлийг хадгалахын тулд даруу төлөв байх шаардлагатай. Шүүхтэй холбоотой олон нийтийн маргаан, мэтгэлцээнд хэр хэмжээнд оролцохыг тодорхойлоход хоёр хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, шүүгч тухайн асуудалд оролцох нь түүний төвийг сахих байдлын талаарх итгэлийг алдах бодит эрсдэл эсэх. Хоёрдугаарт, тэрхүү оролцоо нь шүүгчийг улс төрийн

дайралтад өртүүлэх, шүүхийн албаны нэр хүндэд үл нийцэх эсэх юм. Хэрэв ийм нөхцөл байдалд орох бол, шүүгч нь тийнхүү оролцохоос зайлсхийх хэрэгтэй” /134/. Мөн “... шүүгч нь маргаантай асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн дунд маргаан үүсгэх, засгийн газрыг ил тод шүүмжлэх зэргээр улс төрийн тавцанд орж, олон нийтийн мэтгэлцээнд оролцдог бол тухайн шүүгчийг шүүхэд ажиллаж байх үед нь, шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна гэж харахгүй. Шүүгч тийнхүү үзэл бодлоо илэрхийлсэн асуудалтай нь холбоотой маргааныг шийдвэрлэх нь төвийг сахихгүй гэж харагдана. Ялангуяа, шүүгчийн зүгээс өмнө нь ил тод шүүмжилж байсан олны танил хүн, төрийн байгууллага нь хэргийн оролцогч, нэхэмжлэгч, гэрчээр оролцож буй хэрэг, маргааныг шүүгч төвийг сахин шийдвэрлэж чадахгүй гэж харагдах эрсдэлтэй” /136/.

Тохиолдол 57: Шүүгч ахлах ангид сурдаг хүүхдийнхээ “Эцэг, эхийн өдөрлөг” арга хэмжээнд өсвөр насны хүүхдүүдэд зориулж “Хууль зүйн анхан шатны мэдлэг” сэдвээр яриа хийжээ. Нэгэн сурагчийн асуултад хариулах явцдаа “Христос шашин шүтдэг олон хүүхдүүд амиа хорлож байгаа талаарх” сонины мэдээг жишээ болгохын сацуу “Монголчуудын уламжлалт шашин бол буддизм” гэж хэлсэн байна.

Асуулт: Шүүгч нь сонины мэдээ, эсхүл олонхийн нийтлэг үнэн гэж үздэг байр суурийг дамжуулснаараа шашны талаар байр сууриа илэрхийлсэн гэж ойлгогдох уу?

4.6. Эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах хязгаарлалт

Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, зарчим, шаардлагууд нь аливаа ёс зүйн маргааныг шийдвэрлэх хэрэгсэл болохын зэрэгцээ шүүгчдийн хувьд ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиг баримжаа болох сургалтын ач холбогдолтой. Шүүгчийн итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний хязгаарлалтууд нь Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн баримт бичиг, Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмууд зэрэг олон улсын байгууллагын зөвлөмж, зарчмуудад тусгалаа олсон байдаг бөгөөд манай улсын хувьд энэ харилцааг Шүүгчийн ёс зүйн дүрмээр зохицуулсан байдаг.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 4.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн хараат бус байдал, шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан.

Шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын”-ын 4.6-д “Шүүгч нь бусад иргэний адил ..., итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг эдлэхдээ шүүхийн өндөр нэр хүнд, шүүхийн бие даасан, төвийг сахисан байдлыг хүндэтгэн

дээдэлж биеэ авч явна” гэж тусгасан. Мөн тус зарчмуудын 4.11.4-д “Шүүхийн нэр хүндэд харшлахгүй, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд саад тоггор болохгүй нөхцөлд өөр бусад үйл ажиллагаанд оролцож болно”, 4.13-д “Шүүгч нь шүүгчдийн холбоо байгуулах, түүнд гишүүнээр элсэх, шүүгчийн эрх ашгийг хамгаалах бусад байгууллагад нэгдэх эрхтэй” гэжээ.

Шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрхийн хязгаарлалт, анхаарах нөхцөлийг Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбарын 167, 170, 176 дахь хэсэгт тусгажээ.

Шүүгч нь олон төрлийн ашгийн төлөө бус байгууллага, түүний удирдах байгууллагад гишүүн болж болно. Ийм байгууллагад буяны байгууллагууд, их сургууль, ахлах сургуулийн зөвлөл, шашны байгууллагууд, эмнэлгийн зөвлөлүүд, нийгмийн клубууд, спортын байгууллагууд болон соёл, урлагийн ашиг сонирхлыг дэмждэг байгууллагууд орно. Гэхдээ шүүгч эдгээр байгууллагад гишүүн болох бол дараах зүйлийг санаж байх хэрэгтэй. Үүнд:

1) Шүүгчийн хувьд, олон нийтийн маргаанд татан оролцуулах буюу улс төрийн зорилготой байгууллага, шүүхийн нэхэмжлэлд байнга, тогтмол татагддаг байгууллагын үйл ажиллагаанд оролцох нь зохисгүй;

2) Шүүгчийн хувьд, тухайн байгууллагад их цаг зарцуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой;

3) Шүүгч нь хуулийн зөвлөхийн хувиар ажиллах ёсгүй. Энэ нь хууль зүйн үр дагавартай асуудалд, шүүгч зөвхөн тухайн байгууллагын гишүүний хувиар санаа бодлоо илэрхийлэхийг хязгаарлахгүй. Гэхдээ тэрхүү санаа бодлыг нь хууль зүйн зөвлөгөө гэж үзэж болохгүй гэдгийг тодорхой хэлэх ёстой;

4) Шүүгч нь хөрөнгө босгох, сан арвижуулах үйл ажиллагаанд оролцох, нэрээ ашиглуулахдаа болгоомжтой байх хэрэгтэй;

5) Шүүгч нь дарамт шахалт үзүүлдэг буюу голчлон хөрөнгө босгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэж ойлгогдох байгууллагад биечлэн гишүүнээр элсэж болохгүй.

Үүнээс гадна, шүүгч нь арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, бусад байдлаар ялгаварлан гадуурхаж, хүний суурь эрхийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг аливаа байгууллагад гишүүнчлэлтэй байж болохгүй. Үүнтэй адилаар, ялгаварлан гадуурхах үйл ажиллагаатай гэдгийг нь мэдэж буй клубын уулзалтад шүүгч оролцох ёсгүй төдийгүй тийм клубын үйл ажиллагааг тогтмол, байнга зохион байгуулах ёсгүй Гэхдээ, шүүгч нь шашин, угсаатан, хууль ёсны соёлын үнэт зүйлийг хадгалах зориулалттай,

гишүүдийнхээ нийтлэг ашиг сонирхлыг хангах байгууллагад гишүүн болж болно.

Хэрэв шүүгч өмчлөгчдийн буюу оршин суугчдын холбоо бүхий барилгад байр өмчилдөг, эзэмшдэг бол, тэрхүү холбооны удирдлагын хороонд үйлчилж болох ч, хуулийн зөвлөгөө өгч болохгүй. Гэхдээ хууль зүйн үр дагавартай асуудлаар, зөвхөн гишүүнийхээ хувиар санаа бодлоо илэрхийлж болно. Ингэхдээ, түүний санаа бодлыг хууль зүйн зөвлөгөө гэж үзэж болохгүй гэдгийг тодорхой хэлэх хэрэгтэй. Тухайн байгууллагад ямар нэгэн хууль зүйн зөвлөгөө шаардлагатай бол мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах хэрэгтэй.

Шүүгч нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэхдээ, шүүгчдийн хөдөлмөрийн болон цалин хөлсний нөхцөлийг дэмжих, хамгаалах зорилгоор байгуулагдсан үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоонд нэгдэх буюу тийм үйлдвэрчний эвлэл, холбоо байгуулж болно. Гэхдээ шүүгч олон нийтэд үйлчлэх байдал болон Үндсэн хуулийн зохицуулалтын дагуу ажил хаях эрхээ хязгаарлуулна.

Тохиолдол 58: Үе залгамжилсан алдарт уяачийн удамт хүү, уяачдын Хийморь холбооны гишүүн шүүгч А нь өөрийн хурдан удмын соёолонгоо өвлийн морин уралдаанд оролцуулж түрүүлсэн. Нийгмийн зүгээс шүүгчийг хүүхэд, адуу зовоосон үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж байгааг хурц шүүмжилсэн. Энд шүүгчийн ёс зүйн зөрчлийн асуудал хөндөгдөх үү?

Асуулт: Шүүгчийн үйлдэлд хууль зүйн бүрэн дүгнэлт хийнэ үү?

ХЯНАЛТЫН АСУУЛТ

- Шүүгч багын дотно найзынхаа хүсэлтээр шүүх хуралдаанд түүний (хариуцагч) итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож болох уу?
- Шүүгч шинээр байгуулагдсан эмнэлгийн нээлтийн хямдралтай үйлчилгээгээр оношилгоо, эмчилгээ хийлгэсэн тухайгаа мэдүүлэх үүрэгтэй юу?
- Шүүгч УИХ-ын сонгуульд нэр дэвшин өрсөлдөж буй гэр бүлийн хүнээ дэмжихийг хамтран ажиллагч шүүгчдээс хүсэх нь шүүгчийн ёс зүйд нийцэх үү?
- Шүүгч ахлах ангид сурдаг хүүхдийнхээ “Эцэг, эхийн өдөрлөг” арга хэмжээнд өсвөр насны хүүхдүүдэд зориулж “Шашин” сэдвээр яриа өрнүүлсэн нь шүүгчийн ёс зүйд нийцэх үү?
- Улс төрийн сонгуульд нэр дэвшин өрсөлдөөд ялалт байгуулаагүй иргэн Б тухайн жилдээ шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцохоор

бүртгүүлсэн байна. Иргэн Б-г шүүгчид нэр дэвшүүлэхэд татгалзах үндэслэл бий юу?

АНХААРАХ АСУУДАЛ

Шүүгчийн хувийн амьдралд баримтлах ёс зүй буюу шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны зан үйлийг тодорхойлохдоо, олон нийтэд хэр зохистой харагдах эсэхийг нэн тэргүүнд анхаарч үзэх нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

1. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012
2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012
3. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. 2013
4. Монгол Улсын шүүхийн Шүүгчийн ёс зүйн дүрэм. 2014
5. Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмууд, 2002
6. Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудын тайлбар, 2007
7. Моригива Ясүтомо. Хуульчийн ёс зүй. УБ., 2006
8. Мөнхсайхан О. Хуульчийн ёс зүйн сургалтын гарын авлага. УБ., 2014

ТАВДУГААР БҮЛЭГ

ШҮҮГЧИЙН НИЙГМИЙН ХАРИЛЦААНД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ

Д.Мөнхөө, Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

Д.Нямбазар, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

Л.Галбаатар, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач-багш

СЭДЭВ 5. ШҮҮГЧИЙН НИЙГМИЙН ХАРИЛЦААНД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙ

Зорилго: Энэхүү хэсэгт шүүгчийн зүгээс ялгаварлах үзэл гаргахгүй байх, байгаль орчны талаарх хандлага, зохисгүй байдал гаргахгүй байх, олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахтай холбоотой ёс зүйн шаардлагыг олон улсын болон үндэсний хэм хэмжээнд тулгуурлан тайлбарлах замаар зохих цэгцтэй мэдлэг олгох, холбогдох тохиолдлыг шинжлэх замаар дээрх ёс зүйн шаардлагыг хангах ур чадвар олгоно.

Нэр томьёо: ялгаварлах, байгаль орчин, зохисгүй байдал, мэдээллийн сүлжээ

Дэд сэдэв:

- *Ялгаварлах үзэл гаргахгүй байх*
- *Байгаль орчны талаарх хандлага*
- *Зохисгүй байдал гаргахгүй байх*
- *Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглах*

5.1. Ялгаварлах үзэл гаргахгүй байх

Олон улсын болон бүс нутгийн холбогдох баримт бичигт нийгэм дэх эмзэг бүлгийг ялгаварлан гадуурхахыг хориглосон. Үүнд, “Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай” олон улсын конвенц (1965), “Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай” олон улсын конвенц (1979), “Шашин шүтлэг, итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхах, үл хүлцэх бүх хэлбэрийг устгах тухай” тунхаглал (1981), “Үндэстэн, угсаатан, шашин шүтлэг, хэлний цөөнхөд багтах хүмүүсийн эрхийн тухай” тунхаглал (1992) хамаарна.

Шүүгч нь “хүн бүр шүүхийн өмнө тэгш эрхтэй” болохыг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дугаар зүйлд баталгаажуулсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Ингэхдээ Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүн бүр арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, бусад байдлаас үл хамааран шударгаар шүүлгэх эрх”-ийг хүлээн зөвшөөрсөн гэж ойлгоно. Энд дурдсан “бусад байдал” гэдгийг тайлбарлахдаа, бэлгийн чиг хандлага, хөрөнгө чинээ, хөгжлийн бэрхшээл, БЗХӨ-өөс үл хамааран шүүхийн өмнө тэгш эрхтэй гэж үзнэ. Тиймээс шүүгч нь албан үүргээ гүйцэтгэхдээ, аливаа алдаа гаргах, ялгаварлан гадуурхахаас зайлсхийх, шүүх хуралдаан бүрт талуудын тэгш эрхийг хангах, тэнцвэржүүлэх замаар талуудын тэгш эрхийн зарчмыг хүндэтгэх үүрэгтэй.

Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Үнэт зүйл 2. Төвийг сахих” хэсэгт “2.1 Шүүгч өөрийн албан үүргээ бусдад давуу байдал олгох, шударга бус хандах эсхүл ялгаварлан гадуурхах байдал гаргахгүйгээр хэрэгжүүлнэ” гэжээ.

Тодруулбал, ялгаварлах үзэл гаргахгүй байх байдал, түүний илрэл нь шүүхийн үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлэхэд төвийг сахиж ялгаварлан гадуурхахгүй байх нь зайлшгүй чухал ач холбогдолтой гэх 2 дугаар зарчмыг тусгасан бөгөөд шүүгч ялгаварлах үзэл гаргахгүй байх нөхцөл, шаардлагыг Бангалорын зарчмын 2.1-2.2, 2.4-2.5.1, 2.5.3 дахь хэсэгт зохицуулжээ.⁴² Мөн Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын “Тайлбар”-т шүүгч ялгаварлах үзэл гаргахгүй байх нөхцөлийг хэрэг маргааны аль нэг талыг ялгаварлан гадуурхахгүй, түүнчлэн шүүгчийн зүгээс аливаа хууль зүйн асуудал, түүнийг шийдвэрлэхтэй холбоотой талуудын байр суурийг бүрэн сонсох, бодож эргэцүүлэх, хүлээн зөвшөөрөх эрмэлзэлтэй байхыг багтаан тайлбарлажээ.⁴³

“Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн “Ялгаварлах үзэл гаргахгүй байх” гэх 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлах, түүнчлэн тийм үйл ажиллагаанд дэмжиж оролцох эсхүл дээрх үйл ажиллагаа явуулдаг байгууллагад гишүүн байхыг хориглоно” гэж зохицуулжээ. Энэхүү хэсэгт “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Үнэт зүйл 2 Төвийг сахих” гэх хэсэгт тулгуурлан “... шүүгч хүн шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан эсхүл тийнхүү ойлгогдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийсэн бол ялгаварлах үзэл гаргасан” гэж үздэг.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.10-д “Шүүгч нь хэрэг, маргааны аль нэг талыг ялгаварлан гадуурхахгүй” байхыг үүрэг болгон зохицуулжээ. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 15.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг буюу “Тэгш хандах” гэх хэсэгт “Шүүгч албан үүргээ гүйцэтгэхдээ нас, хүйс, арьсны өнгө, жендэр, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, нийгмийн гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, хөрөнгө чинээ, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн байр суурь зэргээр ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэхийг хориглоно” гэж заасан.

⁴² The Bangalore Principles of Judicial Conduct, 2002

http://www.unodc.org/pdf/crime/corruption/judicial_group/Bangalore_principles.pdf

⁴³ United Nations Office on Drugs and Crime. Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct. September 2007.

https://www.unodc.org/documents/corruption/publications_unodc_commentary-e.pdf

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар, шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээд дээр дурдсан хориглосон үйлдэл, эс үйлдэхүй гаргасныг мэдсэн бол зогсоох арга хэмжээ авах бөгөөд шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа оролцогчоос заасан хориглолтыг зөрчихгүй байхыг шаардахаар байна.

Үүнийг дэлгэрүүлэн, Хуульчийн мэргэжлийн дүрмийн 17.5 дугаар зүйлд ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаанд оролцохыг хориглохдоо ялгаварлан гадуурхсан шинжтэй үйл ажиллагаанд оролцох, эсхүл тийм үйл ажиллагаа явуулдаг байгууллагад гишүүн байхыг хориглосон.

Ялгаварлах үзэл гаргахгүй байх гэж ойлгогдсон эсэхийг хэмжих шалгуур бол шүүгчийн явуулсан үйл ажиллагаа нь хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн эсхүл шүүгчийн үнэнч, төвийг сахисан, шүүгчийн зан төлөвт нийцэхгүй гэсэн ойлголтыг ухаалаг бие хүнд төрүүлэх үү гэсэн асуулт юм.

Шүүх хуралдааны тэмдэглэл хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэт бичигдсэн эсэх, оролцогчдын тайлбар, мэдүүлгийг бүрэн хэмжээнд тусгасан эсэх, шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд оролцогчдын үг хэлэх эрхийг тэгш эдлүүлэх, таслан зогсоохгүй байх, хүндэтгэлтэй хандахад онцгой анхаарах нь зүйтэй.

Шүүгч хүн шүүх танхимд болон шүүхээс гадуур шүүхийн тогтолцоо нь хараат бус, төвийг сахисан, үндэслэл бүхий шийдвэр, үйл ажиллагаагаар хэрэгждэг гэсэн ойлголтыг бий болгох, хадгалахын төлөө хичээх хэрэгтэй.

Энэ зорилгод хүрэхийн тулд шүүгч нь нэг талтай ганцаарчлан уулзахгүй байх, шүүх хуралдааны үед аль нэг тал үг хэлж байхад толгой дохихгүй, инээмсэглэхгүй, талуудын аль нэгэнд давуу байдал үүсгэхгүй байх, нэг талд үйлчлэхгүй байх нь чухал.

Ялгаварлах үзэл гаргахгүйн тулд шүүгч хувийн сэтгэл хөдлөлөөр хандаж болохгүй. Хэрэв тэгвэл, шүүхийн албаны онцгой шинж чанарыг алдагдуулах эрсдэлтэй. Үүнээс гадна, шүүгч нь шүүхийн байранд шударгаар шүүх орчин, ая тухыг бүрдүүлнэ. Шүүхийн байранд хүмүүст тэгш бусаар, ялгаатай харьцах буюу тийнхүү ойлгогдох харьцааг хүлээн зөвшөөрч болохгүй. Хуульч, өмгөөлөгч, хэргийн оролцогч, гэрч зэрэг шүүх дэх бүх хүний хувьд нэр төр, үндсэн эрхийг нь хүндэтгэн харьцахыг шаардах эрхтэй. Шүүгч нь шүүх дэх бүх хүнийг арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, бусад хамааралгүй нөхцөлөөр ялгаварлан гадуурхахаас хамгаална.

Тохиолдол:

“Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”-д орсон Шүүхийн ёс зүйн хорооны магадлалд ялгаварлах үзэл гаргахгүй байх байдал гаргасан гэх үндэслэлээр дараах зөрчлийг зүйлчилжээ.

Тохиолдол 59: Шүүгч Б.Х нь хэргийн оролцогч 80 настай, чих хатуу, амьжиргааны баталгаажих түвшин доогуур орлоготой иргэн А.Р-ыг чанга ярьж байна, бас олон удаа асууж байна гэж хэлж толгой сэгсрэх үйлдэл удаа дараа гаргажээ.

Асуулт:

- Ялгаварлах үзэл гаргасан уу?
- Төвийг сахих байдлаа алдсан уу? Ялгаварлах үзэл гаргасан бол аль зөрчилд нь орох вэ?

Тохиолдол 60: Олны танил трансжендэр А нь иргэний бүртгэлийн байгууллагад хүйсээ өөрчлөгдсөнийг бүртгүүлэх тухай өргөдөл гаргасныг хүчингүй болгосонтой холбоотой нэхэмжлэлийг шүүгч Э хүлээн авч, шүүх хуралдаан дээр А-гийн тайлбарыг сонсох явцдаа үл ойшоох, инээх, сэжиглэх зэргээр харьцжээ.

Асуулт: Шүүгч Э нь иргэн А-г ялгаварлан гадуурхсан уу?

Тохиолдол 61: Шүүгч А нь ижил хүйстнийг хүлээн зөвшөөрдөггүй нэгэн. Гэсэн хэдий ч энэ үзэл бодол нь шүүн таслах ажилд нөлөөлдөггүй. 2018 оны УИХ-ын сонгуулиар ижил хүйстнийг хүлээн зөвшөөрөх талаар мөрийн хөтөлбөртөө тусгасан намын эсрэг намд хандив өгсөн байна.

Асуулт: Шүүгч А шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.1-д заасан ялгаварлах үзэл гаргахгүй байх зарчимд харшлах уу?

5.2. Байгаль орчны талаарх хандлага

Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Үнэт зүйл 4. Зохистой байдал” хэсэгт “Зохистой байдалтай байх, тийнхүү харагдах нь шүүгчийн хийж гүйцэтгэх бүхий л үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай.” гэжээ.

Мөн тус зарчмын 4.2-т “Шүүгч нь олон нийтийн байнгын хяналтад байдаг тул жирийн хүний хувьд бэрхшээлтэй байж болох хувийн эрхийг хязгаарласан хэм хэмжээг өөртөө тогтоох ёстой бөгөөд үүнийг ямар нэг шахалт шаардлагагүйгээр, сайн дураараа өөрөө хэрэгжүүлэх ёстой.

Ялангуяа, шүүгч нь шүүхийн өндөр нэр хүндэд нийцүүлэн биеэ авч явбал зохино” гэж тусгасан.

Энэ талаарх Бангалорын зарчмуудын тайлбарын 115-д “Шүүгч нь бүрэн эрхийн хугацаандаа бусдад үлгэр жишээ болохуйц амьдрах хэрэгтэй. Шүүхийн үйл ажиллагаа нь шүүгчийг олон нийтэд үйлчлэхдээ мэдрэмжтэй байх, өөрийгөө хянахыг шаарддаг. Учир нь олиггүй зан авир гаргах нь шүүн таслах үйл ажиллагааны явцад сөргөөр нөлөөлж, шүүхийн нэр хүндэд үл нийцнэ” гэж бичсэн.

“Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн 2.2 дугаар зүйлд “Шүүгч нь байгаль орчинд халтай үйлдэл хийхийг хориглоно” гэх утгыг зохицуулжээ. Энэхүү зүйл нь “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Үнэт зүйл 4. Зохистой байдал” гэх хэсэгт тулгуурласан бөгөөд шүүгч нь иргэд олон нийтийн өмнө шүүгчийн ёс зүйг сахин мөрдөх бөгөөд байгаль орчинд халтай аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийсэн бол байгаль орчны талаарх зүй бус хандлага гаргасан, зохисгүй байдал гаргасан гэж үзэх юм.

Тохиолдол 62: Шүүгч Х өөрийн автомашинаараа хувийн ажлаар хөдөө явахдаа зохих зөвшөөрөл авч чоно авлаж машиныхаа капутан дээрээ тавьж аймгийн төвөөр явжээ. Мөн авласан чонынхоо урд сууж авхуулсан зургаа өөрийн хувийн фэйсбүүк хаягтаа нийтэлжээ.

Асуулт: Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргасан уу?

Тохиолдол 63: Шүүгч А, Б нар нь хориглосон цаг хугацаанд хилийн бүс нутагт албан тушаалын байдлаа ашиглан орж, загас барьж байхдаа байгаль орчны байцаагчтай таарчээ.

Асуулт: Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргасан уу?

Тохиолдол 64: “А” ТББ нь “Б” компанид холбогдуулан байгаль орчинд учирсан хохирол 5,0 тэрбум төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргасан. Шүүгч “Д” нь “А” ТББ-ын гаргасан нэхэмжлэлийн шаардлагатай холбоотойгоор “Хэр ач холбогдолтой зүйл вэ?” гэж асуужээ.

Асуулт: Шүүгч “Д” нь Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.2-т заасан “Шүүгч нь байгаль орчинд халтай үйлдэл хийхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн үү.

Тохиолдол 65: Шүүгч Б нь найзуудтайгаа өөрсдийн хэдхэн хоногийн зугаа цэнгэлийг хангаж, сэтгэлийн хөөрлөө дарахын тулд “Ниссан” маркийн том арзгар дугуйтай олон жийп автомашинаар гол усыг нааш цааш гаталж, бензин, тос, хог хаяж, голын эрэг, хөрс, ширгийг хуу хуу татах, голын амьтад,

загас жараахайн амгалан тайван байдал, хөрсний сул шороог агаар мандалд тоосжилт ихээр үүсгэсэн аялалыг зохион байгуулжээ.

Асуулт: Ёс зүйн зөрчил бий болсон уу? Эсхүл чөлөөтэй аялал зугаалга хийх нь шүүгч Б-ийн эрх үү?

5.3. Зохисгүй байдал гаргахгүй байх

Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Үнэт зүйл 4. Зохистой байдал” хэсэгт “Зүй зохистой байдал, түүний илрэл нь шүүгчийн бүх үйл ажиллагааны хэрэгжилтэд зайлшгүй шаардлагатай” гэх 4 дүгээр зарчмыг тусгасан бөгөөд шүүгч зохисгүй байдал гаргахгүй байх нөхцөл, шаардлагыг 4.1-4.16 дахь хэсэгт зохицуулжээ.⁴⁴ Мөн Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд “Тайлбар”-т шүүгч зохисгүй байдал гаргахгүй байх нөхцөлийг тайлбарлажээ.⁴⁵

Тодруулбал, Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбарын 111-т “Мэргэжлийн болон хувийн зүгээс зохистой байх, зохистой харагдах нь шүүгчийн амьдралын онцгой чухал хэсэг юм. Илүү чухал зүйл бол, шүүгч юу хийдэг, хийдэггүйн тухай бус, бусад хүн шүүгчийг юу хийсэн, юу хийх ёстой гэж бодож буй явдал юм. Жишээ нь, хянан хэлэлцэж буй хэргийн оролцогчтой шүүгч хувиараа удаан ярилцсан бол энэ нь тухайн этгээдэд давуу байдал бий болгосон гэж харагдана. Үүнд тэрхүү харилцан яриа тухайн хэрэгтэй огт хамааралгүй болох нь нөлөөлөхгүй. Шүүгч өндөр ёс зүйтэй байна гэж олон нийт бодож буй л бол, шүүгчийн зүгээс аливаа арга хэмжээнд оролцох, жижиг ч хамаагүй бэлэг авах эсэхдээ эргэлзэж буй бол ‘Олон нийтийн нүдэнд яаж харагдах бол?’ гэж асууж байх хэрэгтэй” гэжээ.

Зохисгүй байдлын шалгуурыг Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын тайлбарт авч үзсэн байна. Тодруулбал, тус тайлбарын 112-т дурдсанаар, зохисгүй байдлын шалгуур нь шүүгч шүүн таслах үүргээ шударга, төвийг сахиж, хараат бусаар, зохих эрх хэмжээтэйгээр гүйцэтгэх чадваргүйг илтгэх зан байдал гаргасан буюу, ухаалаг ажиглагчийн оюун санаанд шүүгч тийнхүү шүүн таслах үүргээ хэрэгжүүлж чадахгүй, хүсэлгүй байна гэж ухамсарлагдах байдал юм. Тухайлбал, төрийн албан тушаалтанд жирийн иргэнээс өөр, хүндэтгэлтэй харьцаж, тусад нь тухтай суудалд суулгах нь, ердийн ажиглагчийн нүдэнд тухайн төрийн албан хаагч шүүхийн

⁴⁴ The Bangalore Principles of Judicial Conduct, 2002

http://www.unodc.org/pdf/crime/corruption/judicial_group/Bangalore_principles.pdf

⁴⁵ United Nations Office on Drugs and Crime. Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct. September 2007.

https://www.unodc.org/documents/corruption/publications_unodc_commentary-e.pdf

өмнө болон шийдвэр гаргах үйл явцад тусгай эрхтэй гэж харагдана. Нөгөө талаар, шүүхтэй танилцаж буй сургуулийн хүүхдүүд ихэвчлэн тусгайлсан хэсэгт суудаг. Хүүхдүүдийн хувьд, эрх мэдэл бүхий хэсэг биш, ялангуяа тэдэнд боловсролын зорилгоор шүүхийг танилцуулж, тайлбарлаж буй тул зохисгүй нөлөө үзүүлж байна гэж харагдахгүй.

Энд анхаарах зүйл бол, хууль ёсны үйлдэл болгон зохистой харагдахгүй бөгөөд зохистой үйлдэл болгон хууль ёсны байх боломжтой. Шүүгчийн үйлдэл хууль ёсны байх нь түүний зохистой байдлыг бүрэн хэмжихгүй.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014.02.28-ны өдрийн 1/08 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдаж 2014.03.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байгаа “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн “Зохисгүй байдал гаргахгүй байх” гэх 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гэж, “зохисгүй байдал” гэдгийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д тодорхойлсон утгаар ойлгоно гэж тус тус зохицуулжээ.

Шүүхийн ёс зүйн хорооны 2015.03.17-ны өдрийн 22 дугаар магадлалын 5 дахь талд Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлийн 1-д заасан “Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ” гэх утгыг тайлбарлажээ. Энэхүү тайлбарт “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Үнэт зүйл 4. Зохистой байдал” гэх хэсэгт тулгуурлан “... шүүгч хүн шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан эсхүл тийнхүү ойлгогдох аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийсэн бол зохисгүй байдал гаргасан гэж үздэг. Зохисгүй гэж ойлгогдсон эсэхийг хэмжих шалгуур бол шүүгчийн явуулсан үйл ажиллагаа нь хууль, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн эсхүл шүүгчийн үнэнч, төвийг сахисан, шүүгчийн зан төлөвт нийцэхгүй гэсэн ойлголтыг ухаалаг бие хүнд төрүүлэх үү гэсэн асуулт юм. ... тахар болон шүүхийн бусад ажилтанд хууль бус шаардлага тавьдаг эсхүл бусдын ийм шаардлагыг сайшаан дэмждэг шүүгчийг хэрэг, маргаан шийдвэрлэхдээ хуулийг үнэнчээр хэрэглэж шударга шийдвэр гаргадаг эсэхэд ухаалаг бие хүн эргэлзэнэ. Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, бусад шүүгч болон өөрийн удирдлага дор ажиллаж байгаа хүмүүст зохисгүй аашилж, хууль бус шаардлага тавьж болохгүй. ... Шүүгчийн зохисгүй үйл ажиллагаа эсхүл зохисгүй харагдах үйл ажиллагаа нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хамгийн ихээр эвддэг. Зохисгүй байдлаас зайлсхийх зарчим нь шүүгчийн мэргэжлийн болон хувийн

амьдралд аль алинд нь үйлчилдэг. Шүүгч хүн шүүх танхимд болон шүүхээс гадуур шүүхийн тогтолцоо нь хараат бус, төвийг сахисан, үндэслэл бүхий шийдвэр, үйл ажиллагаагаар хэрэгждэг гэсэн ойлголтыг бий болгох, хадгалахын төлөө хичээх хэрэгтэй. Энэ зорилгод хүрэхийн тулд шүүгч нь ямагт шүүх танхимд байгаа мэт зан үйлээ авч явах шаардлагатай болдог. Энгийн иргэний хувьд хэрэгжвэл хэтэрхий дарамттай, хүнд мэт санагдаж болох олон нийтийн хяналтад байдаг тул жирийн иргэний хувьд бэрхшээлтэй байж болох хувийн эрхийг хязгаарласан хэм хэмжээг өөрөө өөртөө тогтоож мөрдөх ёстой бөгөөд эдгээр хязгаарлалтыг өөрөө сайн дураараа сахин хэрэгжүүлнэ. Ялангуяа шүүгч нь шүүхийн өндөр нэр хүндэд нийцүүлэн биеэ авч явбал зохино” гэж тайлбарлажээ.⁴⁶

Тохиолдол:

“Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”-д орсон Шүүхийн ёс зүйн хорооны магадлалд зохисгүй байдал гаргасан гэх үндэслэлээр дараах зөрчлийг зүйлчилжээ.

Тохиолдол 66: Шүүгч Х архи уусан үедээ шүүхийн байранд ирж, ажлын бус цагаар буюу шөнийн цагаар шүүхийн байранд ирсэн шүүгч нарыг машинаар гэрт нь хүргэж өгөхийг шүүгчийн аюулгүй байдал хариуцсан цагдаагийн албаны ажилтанд шаарджээ.⁴⁷

Асуулт:

- Шүүгч Х зохисгүй байдал гаргасан уу?
- Шүүгч Х тухайн нөхцөл байдалд зохисгүй байдал гаргахгүйн тулд хэрхэн биеэ авч явах ёстой байсан бэ?

Тохиолдол 67: Шүүгч Х хянаж байгаа хэргийнхээ нэг талтай хамаарал бүхий этгээдтэй ганцаарчлан уулзаж, түүнээс цүнхтэй зүйл хүлээн авчээ. Энэ талаар шүүгч Х тайлбарлахдаа “уг цүнх дотор хүнд захиж авчруулсан notebook компьютер байсан. Надад notebook компьютер авчирч өгсөн А-г зурагтаар харж байсан хүн байсан, өөрөөр түүнийг танихгүй, манай дүү надад компьютер явуулсан юм” гэжээ.⁴⁸

⁴⁶ Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”. Улаанбаатар. 2017. 8-9 дэх тал

⁴⁷ Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”. Улаанбаатар. 2017. 8-9 дэх тал

⁴⁸ Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”. Улаанбаатар. 2017. 141 дэх тал

Асуулт:

- Шүүгч Х зохисгүй байдал гаргасан уу?
- Шүүгч Х тухайн нөхцөл байдалд зохисгүй байдал гаргахгүйн тулд хэрхэн биеэ авч явах ёстой байсан бэ?

Тохиолдол 68: Шүүгч нь Х нь иргэн А-гийн зүгээс түүний эсрэг Шүүхийн ёс зүйн хороонд гаргасан гомдолд хариу тайлбар өгөхдөө “ичсэн хүн, хүн алав”, “шүүгч рүү сурсан аргаараа ноцон дайрч байгаа”, “идсэн эрүү хувхайрч, идүүлсэн бут дэлгэрдэг”, “жингэр хуцаж л байг, жингийн цуваа явдгаараа явна” хэмээн зохисгүй үг хэллэг хэрэглэжээ.⁴⁹ Мөн шүүгч нь Х нь Шүүхийн ёс зүйн хороонд гаргасан тайлбартаа гомдол гаргагчийг “энэ балмад этгээд увайгүй аашилж”, “хэрүүл зарга хийгээд”, “шүүхээр болон шүүгчийг дарамталж даажигнаж гомдол мэдүүлж байгаа” гэх зэргээр хэлжээ.⁵⁰

Асуулт:

1. Шүүгч Х зохисгүй байдал гаргасан уу?
2. Шүүгч Х тухайн нөхцөл байдалд зохисгүй байдал гаргахгүйн тулд хэрхэн биеэ авч явах ёстой байсан бэ?

5.4. Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглах

Өнөөгийн мэдээллийн эрин үед дэлхийн хүн амын дийлэнх нь олон нийтийн цахим сүлжээ хэрэглэж, мэдээллийн ихэнх хэсгээ тэрхүү сүлжээнээс авч, ихээхэн хамааралтай болжээ.⁵¹ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014.02.28-ны өдрийн 1/08 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдаж 2014.03.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байгаа “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн “Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглах” гэх 2.4 дүгээр зүйлд дараах байдлаар зохицуулжээ.

1. Шүүгч олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл

⁴⁹ Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”. Улаанбаатар. 2017. 191 дэх тал

⁵⁰ Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”. Улаанбаатар. 2017. 201 дэх тал

⁵¹ - What is the real impact of social media? <https://www.simplilearn.com/real-impact-social-media-article>

- The Negative Effect of Social Media on Society and Individuals

<http://smallbusiness.chron.com/negative-effect-social-media-society-individuals-27617.html>

ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дуу, дүрс бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл байршуулахыг хориглоно.

2. Шүүгч олон нийтийн мэдээллийн сүлжээнд өөрийнх нь өмнөөс бусад этгээд энэ зүйлийн 1-д заасан мэдээ, мэдээлэл байршуулах, цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээгээр дамжин хуулиар хамгаалагдсан мэдээлэл задрахаас урьдчилан сэргийлнэ.
3. Шүүгч мэдсээр байж олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээнд хэргийн оролцогчидтой харилцахыг хориглоно.

Шүүгчийн ёс зүйн олон улсын нийтлэг стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмууд”-ын “Тайлбар”-т шүүгч хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээнд хэрхэн хандах, ямар зан үйл хийж болох эсэх талаар зохих тайлбар өгчээ.⁵² Эдгээр тайлбарт дараах зүйлийг онцлон дурджээ:

- 28. ... Шүүгч нь тодорхой хэсэг бүлгийн ашиг сонирхол, олон нийтийн дуулиан, шүүмжлэлд автахгүй байх ёстой. Шүүхийн бие даасан байдал нь гаднын нөлөөллийн бүх хэлбэрээс бие даасан байна.
- 74. ... Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн төлөөлөл шүүхийн шийдвэрийг шүүмжилбэл, шүүгч хэвлэлд бичгээр хандахгүй байх, тэрхүү шүүмжлэлийн талаар тайлбар хийхээс зайлсхийх ёстой. Шүүгч зөвхөн хэргийг хянан шийдвэрлэсэн үндэслэл бүхий шийдвэрээр л ярих ёстой. Шүүгч нь шүүхийн шийдвэрийн үндэслэлийг олон нийтийн өмнө хамгаалах нь ерөнхийдөө зохисгүй байдаг.
- 75. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүн таслах үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх буруу мэдээлэл түгээсэн бөгөөд шүүгчийн зүгээс уг алдааг залруулах ёстой гэж үзвэл, шүүхийн захиргааны байгууллагаас хэвлэлийн мэдээ гаргах замаар бодит мэдээллийг хүргэх буюу залруулга хийх зохих арга хэмжээ авна.
- 76.б. ... Шүүгч тухайн хэргийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөх үүрэгтэйгээс бусад тохиолдолд, шүүгч нь өөрийн болон бусад шүүгчийн хянасан хэргийн талаарх мэдээлэл, тайлбарыг шүүхийн үйл ажиллагаанаас гадуур өгөх нь зохисгүй.

Дээрх зохицуулалт нь шүүгч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бүрэн хаалттай байх утга илэрхийлэхгүй. Тухайлбал, “Шүүхийн бие даасан байдал

⁵² 28. A judge must act irrespective of popular acclaim or criticism; 32. Contact with the community is necessary; 74. Media criticism; 75. Misreporting by the media; 76. Relations with the media. United Nations Office on Drugs and Crime. Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct. September 2007. p.43; 66; 67

https://www.unodc.org/documents/corruption/publications_unodc_commentary-e.pdf

ба хэвлэл мэдээллийн харилцааны тухай” 1994 оны Мадридын зарчмуудад “Шүүгч нь шүүхийн захиргааны үйл ажиллагаатай холбоотой хэвлэл мэдээллийн асуултад хариулахаас татгалзах ёсгүй” гэжээ.⁵³

2017 оны байдлаар Шүүхийн ёс зүйн хорооноос Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн “Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглах” гэх 2.4 дүгээр зүйл зөрчсөн гэх гомдлыг шийдвэрлээгүй байна.⁵⁴ Иймд тус зүйлтэй холбоотой бусад жишээг танилцуулж байна.

Тохиолдол 69: Мэдээллийн вэб сайтад Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгийн талаарх мэдээллийг хүргэжээ. Энэхүү мэдээллийг шүүгч А өөрийн фэйсбүүк хаягт олон нийтэд нээлттэй тохиргоотойгоор /public/ оруулжээ. Энэхүү оруулсан мэдээллийн дор шүүгч Х сэтгэгдэл бичсэн байх бөгөөд түүнд сонгуулийн үр дүн таалагдаагүйтэй холбоотойгоор тэрхүү сэтгэгдэлд “Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг шүүгч А зарлаж буй нь зохимжгүй байна” гэх утгатай зүйл бичжээ. Энэхүү сэтгэгдэл нь олон нийтэд ил бөгөөд фэйсбүүкийн хэрэглэгчдийн хувьд А болон Х нарыг шүүгч болохыг мэдэх боломжтой байсан.

Асуулт:

1. Шүүгч А ёс зүйн зөрчил гаргасан уу?
2. Шүүгч Х ёс зүйн зөрчил гаргасан уу?
3. Шүүгч Х нь ёс зүйн зөрчилд холбогдохгүйн тулд бие хэрхэн авч явах ёстой байсан бэ?

Тохиолдол 70: Шүүгч Х нь өөрийн компьютерийг нууц үгээр хамгаалалгүйгээр хэрэглэдэг. Түүнийг өрөөнөөсөө түр гарах хойгуур түүний найз А нь шүүгч Х-ийн фэйсбүүк хаягаар дамжуулан шүүх, шүүгчийн талаар гүтгэлгийн чанартай зүйл бичжээ.

Асуулт:

1. Шүүгч Х нь ёс зүйн зөрчил гаргасан уу?
2. Энэ тохиолдолд шүүгч Х ямар арга хэмжээ авах ёстой вэ?
3. Шүүгч Х-гийн найз А-д ямар нэгэн хариуцлага хүлээлгэх үү?

Тохиолдол 71: Иргэн А нь өөрийн хариуцагчаар оролцсон дүүргийн иргэний хэргийн шүүх хуралдааны дараа тус шүүхийн шийдвэрийг өөрийн

⁵³ The Madrid Principles on the Relationship between the Media and Judicial Independence, 1994 <https://www.icj.org/wp-content/uploads/2013/09/CIJL-Yearbook-media-and-judiciary-IV-1995-eng.pdf>

⁵⁴ Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”. Улаанбаатар. 2017

фэйсбүүк хуудаст нийтэлж, шүүхийн шийдвэр болон шийдвэр гаргасан Х шүүгчийн талаар шүүмжилж, шүүгчийг элдвээр доромжилжээ. Үүнийг шүүгч Х нь нэгэн найзаасаа сонссоны дараагаар иргэн А-гийн бичсэнийг олж, тэрхүү нийтлэлийнх нь дор өөрийн шийдвэрийн үндэслэлийг тайлбарлан, шийдвэрээ хамгаалан сэтгэгдэл бичжээ.

Асуулт:

1. Шүүгч Х нь зөрчил гаргасан уу?
2. Иргэн А-д хариуцлага тооцох ёстой юу?
3. Шүүгч Х нь иргэн А-гийн нийтлэлийн мөрөөр ямар арга хэмжээ авах ёстой вэ?

ХЯНАЛТЫН АСУУЛТ

- Ялгаварлан гадуурхахгүй байх нь зарчим мөн үү?
- Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй талаар /impropriety/ Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмуудад хэрхэн тусгасан бэ?
- Шүүгч нь гэр бүлийн гишүүнийг нэхэмжлэл, гомдол гаргахад нь төлөөлөн оролцох нь зохисгүй байдалд тооцогдох уу?
- Шүүгч нь түүний орон байрыг хуульч найз нь үйлчлүүлэгчтэйгээ уулзах зорилгоор ашиглахыг зөвшөөрч болох уу?
- Шүүгчийн гэр бүлийн гишүүд нь бусдад өөрийгөө танилцуулахдаа тухайн шүүгчийн гэр бүлийн гишүүн болохыг онцлох нь зохистой юу?
- Шүүгч нь хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоо, шүүхийн захиргааны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар нийтлэл бичих, хичээл заах нь зохистой байдалд хамаарах уу?
- Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөхгүй бөгөөд улс төрийн байр суурь илэрхийлэхгүй тохиолдолд шүүгч нь засгийн газрын комисс, хороо, зөвлөлдөх байгууллагад гишүүн байж болох уу?
- Шүүгчийн хянан шийдвэрлэх хэргийн оролцогч талаас шүүгчийн туслахад нь бэлэг, шагнал өгсөн нь шүүгчийн ёс зүйд нөлөөлөх үү? энэ тохиолдолд шүүгч ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?

АНХААРАХ АСУУДАЛ

Шүүгчийн нийгмийн харилцаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэрэглэх, тайлбарлахдаа шүүгчийн ёс зүйн дүрмийн зүйл, хэсэг дэх үгийн утгын тайлбарыг баримтлахаас гадна түүний зорилгыг тодорхойлох байдлаар тайлбарлах нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

1. The Bangalore Principles of Judicial Conduct, 2002
2. United Nations Office on Drugs and Crime. Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct. September 2007.
https://www.unodc.org/documents/corruption/publications_unodc_commentary-e.pdf
3. Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо. “Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /2013-2016/”. Улаанбаатар. 2017.
4. What is the real impact of social media? <https://www.simplilearn.com/real-impact-social-media-article>
5. The Negative Effect of Social Media on Society and Individuals
<http://smallbusiness.chron.com/negative-effect-social-media-society-individuals-27617.html>
6. The Madrid Principles on the Relationship between the Media and Judicial Independence, 1994 <https://www.icj.org/wp-content/uploads/2013/09/CIJL-Yearbook-media-and-judiciary-IV-1995-eng.pdf>

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ШҮҮГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, ОНОШЛОГООНЫ ТАЛААРХ СЭТГЭЛ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

*Ш.Батболд, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын
хүрээлэнгийн сэтгэл судлаач*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СЭДЭВ 6. ШҮҮГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, ОНОШЛОГООНЫ ТАЛААРХ СЭТГЭЛ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Зорилго: Энэхүү сэдвээр шүүгчийн ёс зүйг сэтгэл судлалын үүднээс таниулах, шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэхэд нөлөөлдөг сэтгэл зүйн шинжүүд, энэ талаарх судалгаа, оношлогооны талаарх ойлголт өгөх.

Нэр томьёо: ёс суртахуун, сэтгэл зүй, зан төлөв, сэтгэл зүйн оношлогоо

Дэд сэдэв:

- *Ёс суртахууны хөгжлийн талаарх сэтгэл судлалын үзэл*
- *Шүүгчийн зан төлөв, оношилгоо*
- *Шүүгчийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг сэтгэл зүйн хүчин зүйлс*

6.1. Ёс суртахууны хөгжлийн талаарх сэтгэл судлалын үзэл

Нэр томьёо:

- Этика /Ethics/ – Ёс зүй: ёс суртахуун ба ёс журмыг судалдаг философийн салбар шинжлэх ухаан.
- Мораль /Morality/ – Ёс суртахуун: хүмүүсийн мөрдлөг болгох ёстой зан үйлийн загвар, зарчим, төсөөлөл, үзэл санаа
- Нравственность /Sittlichkeit/ – Ёс журам: ёс суртахууны хүнд илэрч буй шинжүүд

Сэтгэл судлалд

Ёс суртахууны шинжүүдийг /мораль, morality/ хүн хэрхэн эзэмшдэг вэ?, ёс суртахуунтай хүн төлөвших үйл явц яаж явагддаг вэ гэдгийг судална. Ёс суртахууны шинжүүд хэрхэн төлөвшдөг вэ гэдгийг тайлбарладаг 3 гол онол сэтгэл судлалд байна. Энэ нь З.Фрейдийн психоанализ /1899/, Л.Колбергийн онол /1958/, К.Гиллиганы онол /1982/ юм.

З.Фрейдийн психоанализ /1899/: Тухайн хүний өөрийгөө бусдаас ялгах ойлголт төлөвшөөгүй /Эго/. Нийгмийн хэм хэмжээг мөрдөх, даган дуурайх загварыг эзэмшээгүй /Супер-Эго/ гэх 2 үндсэн шалтгаан ёс зүйгүй үйлдэл хийхэд хүргэнэ.

Л.Колбергийн онол /1958/: Ёс суртахууны үндсэн хэм хэмжээ, зарчмыг хүн гаднаас автоматаар эзэмшдэггүй, шагнаж эсвэл шийтгэж ёс зүйтэй болдоггүй харин хүнтэй харилцах явцдаа өөрийн болгодог. Колберг ёс суртахууны хөгжлийн онолоо боловсруулахын тулд ёс суртахуунд хамаатай янз бүрийн зөрчил үүсгэх баримт /дилемма/ цуглуулсан. Колберг хүмүүс ёс суртахууны зөрчлийг хэрхэн шийдэж байгаа логикийг сонирхсон. Тэрээр бидний ёс суртахууны хөгжил 3 үе шатаар явагддаг гэж дүгнэсэн.

К.Гиллиганы онол /1982/: Колберг болон бусад эрдэмтдийн үзэл баримтлал гол төлөв эрчүүдийг судалсан судалгааны үр дүнд тулгуурласан байдаг. Кэрол Гиллиган (1982) Колбергийн онол нь эмэгтэйчүүдийн ёс суртахууны хөгжлийг тодорхойлоход тохирдоггүй гэж үзсэн. Тэрээр охидын ёс суртахууны хөгжил өөр үе шатыг дамждаг гэж үзсэн. Хөвгүүдийн хөгжил өөрт төвлөрсөн сонирхлоос эхэлж хийсвэр зарчим руу шилждэг бол охид өөрт төвлөрсөн сонирхлоос өөрийн ба бусдын ашиг тусыг тэнцвэржүүлэхэд шилждэг. Эмэгтэйчүүдийн ёс суртахуун нь хийсвэрлэлээс илүү бусад хүмүүсийн хэрэгцээнд төвлөрдөг. Гиллиган ёс суртахууны хөгжлийн Колбергийн онолын 3,4 дүгээр түвшний агуулгыг өөрчлөх санал гаргасан. Колбергийн онол нь дүрэм журмыг биелүүлэхэд чиглэсэн байдаг бол Гиллиганы үзэж байгаагаар эмэгтэй хүний ёс суртахууны хөгжлийн эцсийн зорилго бол өөрийн хэрэгцээ болон бусад хүний өмнө хүлээх хариуцлагыг нэгтгэх чадвар байдаг. Түүнийхээр эмэгтэй хүний үндсэн үүрэг нь хүмүүстэй сайн харилцаагаа хадгалах, тэдэнд туслах байдаг. Ёс суртахууны хөгжлийн шинэ шатанд эмэгтэй хүн шилжихэд янз бүрийн хэм хэмжээнээс сонгох сонголт бус хариуцлагын объектийг сонгох сонголттой тулгардаг.

6.2. Шүүгчийн зан төлөв, оношлогоо

Шүүхэд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд сэтгэцийн эрүүл мэндийн ажилтнууд буюу сэтгэл зүйч, сэтгэл мэдрэлийн эмч, сэтгэл засалч нар шүүгчийг шийдвэр гаргахад үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй оролцдог. Тэдний явуулдаг үйл ажиллагааны чиглэлийг профессор Лионел Ховард томъёолсон.

Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэхэд нөлөөлдөг сэтгэл зүйн шинжүүд, судалгаа, оношлогоо

- Judicial temperament ба психограмма
- Сэтгэл зүйн тестүүд ба хэрэглээ.

Judicial temperament:

- Сайныг хүсэгч, энэрэнгүй /compassion/
- Зоримог шийдэмгий /decisive/
- Уян хатан, бүтээлч /open-mindedness/
- Мэдрэмжтэй /sensitive/
- Эелдэг /courtesy/
- Тэвчээртэй /patience/
- Үл ялгаварлах /freedom from bias/
- Шударга ёсыг эрхэмлэдэг /commitment to equal justice/

Шүүгчид байвал зохих бие хүний онцлог шинжүүд /психограмма/



1. Мэргэжилдээ дасан зохицох чадвар. Энэ нь ээдрээтэй, хурцадмал нөхцөл байдалд ч мэргэжлийн үйл ажиллагаагаа гүйцэтгэх чадвартай холбоотой. Энэ чадварыг төлөвшүүлэхэд нөлөөлдөг сэтгэл зүйн чанар нь:

- Мэргэжлийн өндөр мэдлэг
- Хуулийг хэлбэрэлтгүй мөрддөг зарчимч, шударга зан чанар
- Хувийн сахилга бат, хичээнгүй зан чанар.

Харин эдгээр шинж чанарын эсрэг дасан зохицох чадварт сөргөөр нөлөөлдөг зан чанар нь:

- Ёс суртахууны ухамсар дорой, шударга бус зүйлтэй эвлэрдэг
- Ажилдаа хариуцлагагүй ханддаг
- Согтууруулах ундаанд дурладаг

2. Шүүгчийн сэтгэл зүйн (сэтгэл хөдлөлийн) тогтвортой байдал. Энэ нь:

- Мэдрэлийн тогтолцооны уян хатан, хөдлөнгийн дасан зохицох чадвар өндөр
- Стрессийг тэсвэрлэх чадвартай
- Тэвчээртэй, сэтгэл хөдлөл болон зан үйлээ хянах чадвар өндөртэй
- Харилцааны мэдрэмж

Харин,

- Мэдрэлийн тогтолцоо хөшүүн-нэг зүйлээс нөгөөд шилжихдээ удаан
- Стресс хэт мэдрэг
- Сэтгэл хөдлөл тогтворгүй, амархан хөөрч бухимддаг
- Түрэмгий, зан төлөвийн хурцадмал шинжтэй зэрэг нь мэргэжлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

3. Оюун ухааны хөгжлийн өндөр түвшин, танин мэдэхүйн үйл ажиллагааны идэвх. Энэ хүчин зүйлс нь хувь хүний дараах чадваруудтай холбоотой:

- Хөгжингүй оюун ухаан
- Уян хатан, бүтээлч сэтгэхүй - гол зүйлийг ялгаж таних чадвар
- Танин мэдэхүйн процессуудын (хүртэхүй, ой тогтоолт, анхаарал) динамик чанар, идэвх
- Баялаг төсөөлөл, зөн совин, хийсвэрлэн бодох чадвар.

Харин,

- Сэтгэхүйн аналитик-логик чадвар муутай, явцуу мэдлэгтэй
- Тодорхой үйлдлийн хөшүүн сэтгэхүйтэй
- Урт хугацааны ой тогтоолт тааруу, анхаарлаа төвлөрүүлэх чадвар муу

- Төсөөлөн бодох, хийсвэрлэн сэтгэх чадвар тааруу

4. Шүүгчийн харилцааны эв дүй. Энэ хүчин зүйлс нь:

- Хэргийн оролцогчдын сэтгэл зүйн онцлогийг танин мэдэх чадвар
- Оролцогчдыг сонсох, ялгаваргүй хандах чадвар
- Хэлэхүйн ба хэлэхүйн бус харилцааны хэрэгслийг чадварлаг ашиглах чадвар
- Бусдад хүндэтгэлтэй хандаж зөрчилтэй нөхцөл байдлыг удирдах, харилцах арга барилаа өөрчлөх чадвар
- Бусдад сайныг хүсэгч, энэрэнгүй зан
- Хошин шогийн мэдрэмж.

Харин,

- Бүрэг ичимхий
- Өөрийн асуудал, сэтгэл хөдлөлдөө хэт их төвлөрөх
- Амархан гомдож бухимдах
- Хэл ярианы болон хэл ярианы бус харилцааны хэрэгслийг хангалттай эзэмшиж чадаагүй.


5. Зохион байгуулах чадвар. Мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх харилцааны явцад дараах чадваруудыг эзэмшсэн байх. Үүнд:


- Идэвх, санаачлагатай
- Зоримог шийдэмгий, зорилго чиглэлтэй зан чанар

Харин,

- Ажлыг сайжруулах, амжилт гаргах сэдэлгүй, хүрсэн байр суурьтаа сэтгэл ханасан
- Түгшүүртэй, өөртөө итгэдэггүй, зоригийн чанар хөгжөөгүй.

Хүний сэтгэл зүйн бүтэц





Intelligence /төрөлхийн/	Personality /төлөвшдөг/	Emotional Intelligence /хөгжүүлж болох/
Мэдрэлийн тогтолцооны уян хатан-хөдлөнгийн чанар	Мэргэжлийн өндөр мэдлэг	Тэвчээр – сэтгэл хөдлөл болон зан үйлээ хянах чадвар
Хөгжингүй оюун ухаан	Зарчимч, шударга зан чанар	Харилцааны мэдрэмж
Уян хатан, бүтээлч сэтгэхүй - гол зүйлийг ялгаж таних чадвар	Хувийн сахилга бат, хичээнгүй зан чанар	Стрессийг тэсвэрлэх чадвар
Танин мэдэхүйн процессуудын (хүртэхүй, ой тогтоолт, анхаарал) динамик чанар, идэвх	Идэвх, санаачлагатай	Хэргийн оролцогчдын сэтгэл зүйн онцлогийг танин мэдэх чадвар
Баялаг төсөөлөл, зөн совин, хийсвэрлэн бодох чадвар	Зоримог шийдэмгий, зорилго чиглэлтэй зан чанар	Оролцогчдыг сонсох, ялгаваргүй хандах чадвар
Хошин шогийн мэдрэмж	-	Харилцааны хэлэхүйн ба хэлэхүйн бус хэрэгслийг ашиглах чадвар
-	-	Бусдад хүндэтгэлтэй хандаж зөрчилтэй нөхцөл байдлыг удирдах, харилцах арга барилаа өөрчлөх чадвар
-	-	Бусдад сайныг хүсэгч, энэрэнгүй зан

Шүүгчийн сэтгэл зүйн онцлогийн 25 орчим хувь нь төлөвшлөөс, 30 орчим хувь нь төрөлхийн өгөгдлөөс, 45 орчим хувь нь хөгжүүлэлт, идэвх чармайлт, харилцаанаас хамаардаг.

Шүүгчийн бие хүний онцлог шинжийг тодорхойлох сэтгэл зүйн тестүүд

1. Оюун ухааны хөгжлийг тодорхойлох Г.Айзенк, Векслерийн тест
2. Сэтгэл хөдлөлийн оюун ухааныг тодорхойлох тест
2. Харилцах чадварыг тодорхойлох тест
2. К.Леонгардын зан төлөвийг тодорхойлох тест
3. ММРІ
3. Р.Кеттэл
3. Л.Сонди
3. Плутчик-Келлерман

6.3. Шүүгчийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг сэтгэл зүйн хүчин зүйлс

- Шүүгчийн хувь хүний хүчин зүйл
- Хэргийн оролцогчдын зүгээс нөлөөлдөг хүчин зүйл
- Социаль хүчин зүйлс

Шүүгчийн хувь хүний хүчин зүйл

Сэтгэл зүйч Либермэн ба Краус (2009) нарын судалгаагаар бусад шүүгчийн саналд тулгуурлаж шийдвэр гаргадаг шүүгч, нотолгоонд тулгуурлаж шийдвэр гаргадаг шүүгч гэсэн хэв шинжид хуваагддаг. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны деформацид орсон эсэх. Олон жил ажилласан шүүгч зөвхөн өөрийн зөв гэж үзсэн нотлох баримтыг хамгийн чухал нь гэж харах хандлагатай. Ятгалгад хэрхэн ханддаг, бүлгийн дарамтад хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг (бусад шүүгчдээс хараат бус, өөрийн байр сууриа хадгалах чадвар, бүлгийн дарамтад тэсвэртэй байх чадвар).

Хэргийн оролцогчдын зүгээс нөлөөлдөг хүчин зүйлс

- Хэргийн оролцогчийн гадаад төрх
- Гарал угсаа нэгтэй байх
- Үзэл бодол, өссөн орчин төстэй байх

Социаль хүчин зүйлс

Шалтгааныг тайлбарлах хандлага:

Шүүгчдийн гаргаж байгаа шийдвэр олон нийтэд таалагдах албагүй, мэргэжлийн мэдлэг чадварт тулгуурлан гаргасан шийдвэр ба олон нийтийн санаа бодол ялгаатай байдаг. Сэтгэл судлаач Ф.Хайдерийн (F.Heider): Мэдээлэл дутуу байгаа нөхцөлд хүмүүс шууд ажиглалтаар илэрдэггүй үзэгдлийн шалтгааныг авсан мэдээлэлдээ үндэслэн дүгнэдэг.

Боловсрол, үнэн зөв мэдээлэл муутай, популизм давамгайлсан сэтгэл зүйн хэв шинжтэй, иргэншээгүй нийгмийн сэтгэл зүй нь: “Үйл явдлын талаар нэг л тайлбарыг сонгож аваад тэр баримттай зөрчилдөж байгаа бүх зүйлийг хасч хаядаг”.

Энэ нь нийгмийн бүх гишүүдийн санаа бодол биш, байнга хувьсаж өөрчлөгддөг, тодорхой эрх ашиг бүхий этгээдүүд цуурхал хэлбэрээр дэгдээсэн байдаг гэдгийг шүүгчид байнга санаж байх ёстой. (И. Ю. Носков. Общественное мнение и решение судьи по делу. /Российский судья. - 2014. - № 7)

